



МОНГОЛ УЛСАД КОВИД-19 ЦАР ТАХЛЫН
♀ ХИД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН
НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН АМЬДРАЛД
ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨЛЛИЙН СУДАЛГАА

Улаанбаатар хот
2021 оны 3-р сар



Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ) нь ядуурал, тэгш бус байдал, уур амьсгалын өөрчлөлтийн шударга бус байдлыг арилгахын төлөө тэмцэж буй НҮБ-ын тэргүүлэгч байгууллага юм. Бид 170 улс орны мэргэжилтнүүд, түншүүдийнхээ өргөн сүлжээтэй хамтран ажиллаж, улс үндэстнүүдэд хүн төрөлхтөн, дэлхий ертөнцөд зориулагдсан цогц, удаан хугацааны шийдлийг бий болгоход нь тусалдаг.

Азийн Хөгжлийн Банк (АХБ) нь Ази, Номхон далайн бүс нутагт нэн ядуурлыг арилгах хүчин чармайлтаа үргэлжлүүлэхийн зэрэгцээ цэцэглэн хөгжсөн, хүртээмжтэй, тогтвортой, сөрөг нөлөөнд тэсвэртэй бүс нутгийг цогцлоохын төлөө тууштай ажилладаг. Анх 1966 онд байгуулагдсан тус банкны нийт 68 гишүүн орны 49 нь тухайн бүс нутагт оршдог. АХБ нь бодлогын хэлэлцүүлэг, зээл, өөрийн хөрөнгийн санхүүжилт, батлан даалт, буцалтгүй тусламж болон техникийн туслалцаа зэрэг олон төрлийн арга хэрэгслээр дамжуулан хөгжиж буй гишүүн орнууддаа дэмжлэг үзүүлж байна.

Ерөнхий мэдэгдэл:

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр эрхлэн хэвлүүлэв.

Энэхүү хэвлэлд дурдсан материал нь НҮБХХ эсхүл Засгийн Газрын байр суурийг илэрхийлээгүй болно. Тус хэвлэлд илэрхийлсэн үзэл бодол нь зохиогчийнх бөгөөд хамтран хэвлүүлсэн байгууллагуудын үзэл баримтлал, бодлогыг төлөөлөхгүй. Судалгаанд ашигласан мэдээллийн үнэн зөв эсэх, тухайн материалыг ашигласны улмаас гарах үр дагаварт хамтран хэвлүүлсэн байгууллагууд хариуцлага хүлээхгүй болно. Энэхүү баримт бичигт дурдсан аливаа бүс нутаг, засаг захиргааны нэгж, “улс орон”-ын талаар НҮБХХ ба АХБ-ны зүгээс ямар нэг байдлаар шүүмж өгөх, тэдгээрийн эрх зүйн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх зорилго агуулаагүй болно.

Үндэсний зөвлөх М.Чанцалсүрэн

© 2021 Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр

Зохиогчийн эрхийг хуулиар хамгаалсан. 2021 онд хэвлэв.

НҮБХХ-өөс зохих ёсны зөвшөөрөл авсан тохиолдолд тус судалгааг хувийн болон арилжааны бус зорилгоор хэвлэх эсвэл хуулбарлахыг зөвшөөрнө. НҮБХХ-ийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр арилжааны зорилгоор худалдах, түгээх, дуурайлган хэвлэхийг хориглоно.

Та дараах хаягаар орж тус судалгаатай танилцах боломжтой:

<http://mn.undp.org>

Та бидэнтэй дараах хаягаар холбогдож болно:

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр

НҮБ-ын нэгдсэн байр, НҮБ-ын гудамж 14,

Сүхбаатар дүүрэг, 14201,

Улаанбаатар хот, Монгол улс

Утас: + 976-11-327585

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГС.....	5
Талархал.....	6
Өмнөх үг.....	7
1. ТОВЧ ХУРААНГУЙ.....	8
СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮН.....	8
2. ТАНИЛЦУУЛГА.....	13
2.1 Судалгааны ажлын хүрээ.....	14
2.2. Судалгааны арга зүй.....	17
3. Судалгааны үр дүн.....	21
3.1. Нийгмийн үйлчилгээ.....	21
Эрүүл мэндийн үйлчилгээ.....	21
Боловсрол.....	23
Нийгмийн халамж, хамгаалал.....	27
3.2. Хөдөлмөр эрхлэлт ба орлого.....	31
Бичил, жижиг, дунд үйлдвэрлэл (ЖДҮ).....	31
Орлого.....	35
Гэрийн хөлсгүй хөдөлмөр.....	38
3.3. Засгийн газрын хариу арга хэмжээ.....	38
3.4. Эмзэг бүлэг.....	41
Өрх толгойлсон эмэгтэйчүүд.....	41
Охид эмэгтэйчүүд.....	43
Ахмад настан эмэгтэйчүүд.....	44
Хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүд.....	45
Малчин эмэгтэйчүүд.....	46
Шилжин суурьшсан эмэгтэйчүүд.....	48
4. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....	50
4.1 Дүгнэлт.....	50
4.2.Зөвлөмж.....	52
НОМ ЗҮЙ.....	54
ХАВСРАЛТ 1. Чиглүүлэх асуултууд.....	58
ХАВСРАЛТ 2. Засгийн газрын хариу арга хэмжээ, тойм.....	60

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Гүнзгийрүүлсэн ярилцлагад оролцогсдын мэдээлэл.....	19
Хүснэгт 2. Эхийн эндэгдэл.....	22
Хүснэгт 3. Бүх шатны боловсролын байгууллагын багш.....	23
Хүснэгт 4. Нэг сууцанд амьдардаг өрхийн тоо.....	23
Хүснэгт 5. Эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийг үйл ажиллагаа хэвийн бус явагдаж бизнестэй харьцуулсан байдал, эдийн засгийн үйл ажиллагааны салбар бүрээр.....	33

Зургийн жагсаалт

Зураг 1. Сонгогдсон салбарууд.....	15
Зураг 2. Багш нарын онлайн хичээлд бэлтгэгдсэн байдал.....	25
Зураг 3. Багш нарын цалин хөлс өөрчлөгдсөн эсэх.....	25
Зураг 4. Цар тахлын үед ажил үүрэг нь нэмэгдсэн гэж хариулсан хүүхдүүдийн эзлэх хувь.....	27
Зураг 5. LEWIE загварыг ашигласан үнэлгээний жишээ.....	28
Зураг 6. Гурав ба түүнээс дээш хүүхэдтэй ганц бие эх, эцгийн тэтгэмжийг хүртэгчдийн тоо.....	29
Зураг 7. Гэр бүлийн хүчирхийллийн дуудлагын тоо, өдөр бүрээр.....	30
Зураг 8. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн тоо, сараар.....	30
Зураг 9. ЖДҮ-дэд тулгамдаж буй бэрхшээл.....	32
Зураг 10. Орлого нь буурсан ААН, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар.....	34
Зураг 11. Бага цалинтай ажилчдын хувь.....	35
Зураг 12. Хөдөөгийн өрхийн орлогын бүтэц (2019 дотор талд, 2020 гадна талд).....	36
Зураг 13. Өрхийн орлогын бүтцэд бусдаас үнэгүй авсан орлогын эзлэх хувь.....	37

ТОВЧИЛСОН ҮГС

АХБ	Азийн Хөгжлийн Банк
БШУЯ	Боловсрол, Шинжлэх Ухааны Яам
ГБХ	Гэр бүлийн хүчирхийлэл
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэр
ЖСХ	Жендэрт суурилсан хүчирхийлэл
ЖҮХ	Жендэрийн Үндэсний Хороо
ЖЭТБХТХ	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай Монгол улсын хууль
ЗГ	Монгол Улсын Засгийн Газар
КОВИД-19	SARS-CoV2 төрлийн амьсгалын замын вирус
МҮХАУТ	Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхим
НОК	Нийслэлийн Онцгой Комисс
НҮБХАС	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн Амын Сан
НҮБХС	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
НҮБХХААБ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллага
НЦҮТ	Нэг цэгийн үйлчилгээний төв
ОУВС	Олон Улсын Валютын Сан
ОУХБ	Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
ОУШХБ	Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага
СХЗГ	Стандарт, Хэмжил Зүйн Газар
ТББ	Төрийн бус байгууллага
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
УОК	Улсын Онцгой Комисс
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХБХ	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд
ХНХСИ	Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Судалгааны Институт
ХНХЯ	Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам
ХХИТ	Хүүхэд Хөгшдийг Ивээх Төв ТББ
ХӨСҮТ	Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв
ЭМХТ	Эрүүл Мэндийн Хөгжлийн Төв
ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам

Талархал

Энэхүү бүтээлийг боловсруулж хэвлүүлэхэд хувь нэмрээ оруулсан бүхий л хүмүүст гүнээ талархсанаа илэрхийлье. Ялангуяа энэ судалгааг удирдан гүйцэтгэсэн зөвлөх М.Чанцалсүрэн болон тус судалгааг улам боловсронгуй болгоход мэргэжлийн зөвлөмж үзүүлсэн Монгол дах НҮБХХ-ийн орлогч суурин төлөөлөгч Нашида Саттар, эдийн засагч асан Т.Дэлгэрнаран, АХБ-ны Нийгмийн хөгжил, жендэрийн асуудал хариуцсан ахлах ажилтан Б.Цолмон, НҮБХХ-ийн Ази Номхон Далайн Бүсийн Жендэрийн зөвлөх Кох Мияаой, Энди Куан нарт гүн талархлаа илэрхийлж байна.

Түүнчлэн, энэхүү ажлыг үр дүнтэй зохион байгуулахад дэмжлэг туслалцаа үзүүлсэн ХНХЯ-ны Хүүхэд, залуучууд, ахмад настан, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн дарга Н.Баярмаа, ХНХЯ-ны Жендэр хариуцсан ахлах мэргэжилтэн Р.Нарантуяа, ЖҮХ-ны Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Т.Энхбаяр, мэргэжилтэн Х.Цэнджав, АХБ-ны Монгол улс дах Суурин төлөөлөгчийн газрын хамт олон, тухайлбал Дэд захирал бөгөөд Суурин төлөөлөгчийн орлогч Деклан Магий, Эдийн засаг хариуцсан ахлах ажилтан С.Болд, Нийгмийн салбар хариуцсан ахлах ажилтан Л.Итгэл, Хөрөнгө оруулалт хариуцсан ахлах ажилтан Э.Энэрэлт, Нийгмийн салбар хариуцсан ахлах ажилтан Ж.Алтантуяа, Нийгмийн хөгжлийн (Жендэр ба хөгжил) мэргэжилтэн Вероника Мендизабал, Монгол дах НҮБХХ-ийн бүсийн эдийн засагч Г.Уянга, Ази Номхон Далайн бүсийн НҮБХХ-ийн бүсийн эдийн засаг, стратегийн ахлах зөвлөх Балазс Хорват, Хүүхэд, хөгшдийг ивээх төв ТББ-ын судалгааны багийн хамт олон Г.Амарсанаа, Б.Цогбаяр, НҮБХХ-ийн Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах төслийн зохицуулагч Б.Эрдэнэбилэг нарт талархсанаа илэрхийлж байгааг үүгээр уламжилъя.

Өмнөх үг

КОВИД-19 цар тахал нь эрүүл мэнд, нийгэм, эдийн засаг болон хүмүүнлэгийн хямралыг улам бүр нэмэгдүүлж байна. Энэ байдал нь жендэрийн эрх тэгш байдлыг хангахад олон сөрөг үр дагаврыг дагуулах төдийгүй өмнө нь байсан тэгш бус байдлыг цаашид гүнзгийрүүлж болзошгүй байна. Коронавирусын хурдацтай тархалтын улмаас олон улс орон иргэдийнхээ зорчих хөдөлгөөнд бүтэн болон хэсэгчилсэн байдлаар хязгаарлалт хийхэд хүрсэн. 2020 оны 1-р сараас эхлэн Монгол Улсын Засгийн газар улс орон даяар хөл хорио тогтоох, тусгаарлах, сургууль, цэцэрлэг болон олон нийтийн газруудын үйл ажиллагааг хаах зэргээр халдварын эрсдэлээс иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, эдийн засаг, нийгмийн тогтолцоог аль болох эрсдэлд оруулахгүй байхад анхааран ажиллаж байна.

Хүн төрөлхтөнд нүүрлэсэн энэхүү хямралын үед хүний амь нас эрсдэх, иргэдийн аж амьдрал сүйдэхээс сэргийлж хамтарсан, цогц хариу арга хэмжээ авах нь нэн чухал байна. КОВИД-19 цар тахлын охид, эмэгтэйчүүдэд үзүүлж буй нөлөөг илрүүлэх, тэдний онцлог хэрэгцээг харгалзсан шаардлагатай арга хэмжээ, үйлчилгээний талаарх мэдээллээр Монгол Улсын Засгийн газрыг хангаснаар цар тахлын нөлөөг бууруулах, охид, эмэгтэйчүүдийн хямралыг даван туулах чадварыг нэмэгдүүлэх, жендэрийн эрх тэгш байдлыг сайжруулахад хувь нэмэр оруулах зорилгоор Нэгдсэн Үндэстний байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ) Азийн Хөгжлийн Банк (АХБ) болон Жендэрийн Үндэсний Хороо (ЖҮХ)-той хамтын ажиллагааны хүрээнд энэхүү судалгааг дэмжин ажиллав. Судалгааны үр дүнгээс харахад КОВИД-19 цар тахал нь эдийн засаг, боловсролын тэгш бус байдал, хүний эрх болон хот, хөдөөгийн иргэдийн амьжиргааны тэгш бус байдлыг улам бүр нэмэгдүүлсэн байна. Судалгаа нь хямралын үеийн олон талт үр дагавар болон түүнийг даван туулж байгаа стратегид дүн шинжилгээ хийж, ялангуяа цар тахлаас үүдэлтэй нийгэм-эдийн засгийн нөлөө, гэрийн ажил, асаргаанд зарцуулах хөлсгүй хөдөлмөрийн тэгш бус хуваарилалт, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой асуудалд анхаарсан. Түүнчлэн 2020 оны 11-р сарын 20-ноос 2021 оны 2-р сарын 22-ны хооронд үйлчилсэн хатуу хөл хорионы үеийн бодит байдал, төрөөс зайлшгүй үзүүлэх ёстой нийгмийн үйлчилгээний хүртээмжийн талаарх цаашид анхаарах шаардлагатай нэн чухал асуудлуудыг тусгасан болно.

Монгол Улсын Засгийн газраас КОВИД-19 цар тахлын эсрэг олон чухал хариу арга хэмжээг авч хэрэгжүүлсэн хэдий ч цаашид хийгдэх ажил их байна. КОВИД-19 цар тахлын хямралыг даван туулах хариу арга хэмжээ нь иргэдийн хэрэгцээнд тулгуурласан байхын зэрэгцээ охид, эмэгтэйчүүдийн нийгмийн оролцоог дэмжин, тэднийг хүчирхэгжүүлсэнээр жендэрийн тэгш бус байдлыг арилгахад чиглэсэн байх нь чухал юм. Төрийн аливаа үйлчилгээг хүргэхдээ хүний эрхийг хангахын тулд жендэрийн мэдрэмжтэй бодлогуудыг илүүтэй авч үзэж хэрэгжүүлэх, жендэрт суурилсан болон гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх арга замыг сайжруулах, хямралаас иргэдээ хамгаалах нийгмийн хамгааллын арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, охид, эмэгтэйчүүдийн дижитал чадавх, ур чадварыг нэмэгдүүлэх, эмэгтэйчүүдийг бизнес эрхлэлтийг дэмжих, КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авахтай холбоотой шийдвэр гаргах үйл явцад эмэгтэйчүүдийг татан оролцуулах, эмэгтэйчүүдийн байгууллага болон түүний сүлжээ байгууллагуудыг илүүтэй хамруулахад цаашид анхааран ажиллах нь зүйтэй.

Бид Тогтвортой хөгжлийн зорилтын 2030 он хүртэлх хэрэгжилтийг хангах, үүнд хэнийг ч орхигдуулахгүй байхад Монгол Улсын Засгийн газар болон Монголын ард түмнийг дэмжин ажилладаг. Энэхүү судалгаанд дурдагдсан санал, зөвлөмж нь охид, эмэгтэйчүүдийг хүчирхэгжүүлэх, өсөн дэвжихэд нь хувь нэмэр болно гэдэгт итгэлтэй байна.

Илейн Конкиевич

Elaine M. Conkiewicz

НҮБХХ-ийн Монгол дах Суурин төлөөлөгч

Павит Рамачандран



АХБ-ны Монгол дах Суурин төлөөлөгч

Т.Энхбаяр



ЖҮХ-ны Нарийн бичгийн дарга бөгөөд

Ажлын албаны дарга

1. ТОВЧ ХУРААНГУЙ

КОВИД-19 цар тахал нь олон нийт, тэр дундаа эмзэг бүлгийн охид, эмэгтэйчүүдийн ахуй амьдралд ихээхэн нөлөөлж байна. Энэхүү судалгаагаар нийгмийн үйлчилгээ, ажил эрхлэлт ба орлого, төрөөс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, эмзэг бүлэг зэрэг харилцан уялдаа бүхий дөрвөн салбарт эмэгтэйчүүд, охидод үзүүлэх КОВИД-19 цар тахлын нөлөөлөл, нөхцөл байдлыг дараах гурван зорилгын хүрээнд судлан авч үзсэн болно:

- Охид, эмэгтэйчүүдийн өдөр тутмын аж амьдрал, бие даасан байдал болон шийдвэр гаргахад тулгарч буй бэрхшээлийг тодорхойлох,
- КОВИД-19 цар тахал нь охид, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, нийгэм-эдийн засгийн нөхцөл байдалд хэрхэн нөлөөлж буйг үнэлэх,
- Цар тахлын улмаас охид, эмэгтэйчүүдэд тулгарч буй бэрхшээлийг арилгах үүднээс жендерийн ялгаатай байдлыг харгалзан бодлогын түвшинд авч хэрэгжүүлэх зөвлөмж өгнө.

Тус судалгаагаар охид, эмэгтэйчүүдэд цар тахал болон цаашид цар тахлын улмаас гарч болзошгүй хямралыг даван туулахад олон нийт, төрөөс ямар дэмжлэг тусламж хэрэгтэй байгааг тодруулахыг зорьсон. Цар тахлын улмаас хоёрдогч мэдээллийн эх үүсвэрт дүн шинжилгээ хийж, гүнзгийрүүлсэн ярилцлагыг утсаар хийлээ. Судалгааны мэдээллийг 2020 оны 11-р сарын 20-оос 12-р сарын 23-ны хооронд цуглуулсан. Завхан, Хэнтий, Дундговь аймаг болон Улаанбаатар хотод ажиллаж амьдардаг нийт 100 иргэн (68 эмэгтэй, 32 эрэгтэй) гүнзгийрүүлсэн ярилцлагад хамрагдлаа.

Судалгааны үр дүнгээс харахад КОВИД-19 цар тахал нь эдийн засаг, боловсрол, хүний эрх, иргэдийн ахуй амьдрал болон хот хөдөөгийн тэгш бус байдлыг улам бүр нэмэгдүүлж байна. Тэгш бус байдал нэмэгдэж байгаа нь ТХЗ-ын хүрээнд хүрсэн ололт амжилтыг бууруулахад нөлөөлж болзошгүй байна. Энэ судалгаа нь КОВИД-19 цар тахлын охид, эмэгтэйчүүдийн аж амьдралд үзүүлж буй нөлөөллийн талаар холбогдох талуудын ойлголтыг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулна гэж үзэж байна.

СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮН



Нийгмийн үйлчилгээ

- Коронавирусын цар тахалтай тэмцэх ажилд эмэгтэйчүүд тэргүүн эгнээнд ажиллаж байна. Дэлхий дахинд эрүүл мэндийн салбарын нийт ажилтан албан хаагчдын 70 хувь эмэгтэйчүүд¹ байдаг бол Монгол улсад эрүүл мэндийн салбарт ажиллагсдын 81.9 хувь²-ийг эмэгтэйчүүд бүрдүүлж байна. Эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудад нийгэм болон гэр бүлийнхээ өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлэхэд тусламж дэмжлэг хэрэгтэй. Тэдний асрамжинд байдаг ар гэрийн гишүүд, тухайлбал үр хүүхдүүд, ахмад настай эцэг эх, хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүд халамжлах хүнгүй гэртээ үлдэж байна. 2020 оны 12-р сарын 15-ны байдлаар Монгол улсад эрүүл мэндийн 41 албан хаагч КОВИД-19 вирусээр халдварлагдсан.³ Энэхүү

¹ WHO. 2019. A Gender and Equity Analysis of the Global Health and Social Workforce.

² ЭМХТ. Монгол улсын эрүүл мэндийн үзүүлэлт. 2019

³ Ажлын хэсгийн гишүүдийн коронавируст (Ковид-19) халдварын голомтод ажиллаж байгаа эмч, эмнэлгийн ажилтнуудын эрүүл мэнд, цаг үеийн нөхцөл байдлын асуудлаарх цахим хурал. 2020 оны 12 сарын 15. <http://parliament.mn/n/9rbyu>

мэдээлэлд хүйсийн ялгааг дурдаагүй боловч тухайн салбарт ажиллах эмэгтэйчүүдийн эзлэхувь өндөр байгааг харгалзан үзвэл эмэгтэйчүүд халдварт илүү өртсөн байж болзошгүй.

- Хөл хорионы үед эмэгтэйчүүд, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон жирэмсэн эмэгтэйчүүдэд эмнэлгийн яаралтай тусламж авахад хүндрэлтэй байсан бөгөөд зарим хөгжлийн бэрхшээлтэй иргэд шаардлагатай эм тариагаа авч чадаагүй байна. Цар тахлын үед эхийн эндэгдэл өнгөрсөн гурван жилтэй харьцуулахад 27.8 хувь өссөн байна. 2020 оны 3-р сараас 10-р сар хүртэлх хугацаанд Баян-Өлгий аймагт эхийн эндэгдлийн 5 тохиолдол бүртгэгдсэн нь коронавирусын халдвараас сэрэмжлэн эмнэлэгт хандахаас зайлсхийж, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ авч чадахгүй байсантай холбоотой байна.⁴
- КОВИД-19 цар тахал нь эрэгтэйчүүдтэй харьцуулахад эмэгтэйчүүдийн сэтгэл зүйд илүү сөргөөр нөлөөлж байна. Хөл хорионы улмаас нийгмийн харилцаанд биечлэн орж чадахгүй болох, гэртээ олуулаа удаан хугацаагаар хамтдаа байх, гэрийн хөлсгүй хөдөлмөрийн ачаалал нэмэгдсэн нь эмэгтэйчүүдийн сэтгэцийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, сэтгэл зүйн дарамтанд оруулж байна гэдгийг ярилцлага өгсөн дийлэнх эмэгтэйчүүд илэрхийлсэн.
- Охид, эмэгтэйчүүдийн гэрийн ажил нэмэгдсэн нь охидын боловсролд тэгш хамрагдах боломжийг багасгаж байна. Гэр хороолол, алслагдсан бүс нутагт амьдардаг охид гэртээ асран халамжлах ажлыг түлхүү хийж байгаагаас тэдний суралцах цаг хугацааг хязгаарлаж, цаашдын сайн сайхан байдалд нь сөргөөр нөлөөлж байна. Сурагчид багштайгаа биечлэн харилцах боломж теле хичээлийн үеэр багассан. Түүнчлэн эмзэг бүлгийн хүүхдүүдэд цахим сургалтын төхөөрөмж, хэрэгсэл дутмаг байгаа нь боловсрол дахь тэгш бус байдлыг улам бүр нэмэгдүүлж байна.
- Ихэнх багш нар цахим хичээл зааж байсан туршлагагүй, цахим сургалтын тоног төхөөрөмж дутмаг, интернэт ашиглах боломж хангалтгүйгээс гэрээс ажиллах ажлын бүтээмж нь буурсан. Багш нар сурагчид, тэдний эцэг эхтэй шууд харилцаж чадахгүй байна. Багш нарын дийлэнх нь болох эмэгтэй багш нарын хувьд хичээл заахаас гадна гэрийн хөлсгүй хөдөлмөрт ихээхэн цаг хугацаа зарцуулах болсон нь цахим хичээлийн чанарт сөргөөр нөлөөлөх магадлал өндөр байна. Судалгаанд оролцогчдын мэдээлж байгаагаар багш нар зайнаас ажиллахын тулд утас, интернэтийн төлбөр төлөх, тоног төхөөрөмж худалдан авах зэргээр бүхий л зардлыг өөрсдөө хариуцаж байна.
- Хөл хорионы үед эцэг эхчүүдэд тулгарч буй сэтгэл санааны асуудлууд нь хүүхдүүдийн зан үйл, бие физиологи, сэтгэл зүйн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна.
- Коронавирустэй тэмцэх арга хэмжээ, хөл хорионы үед жендерт суурилсан, гэр бүлийн хүчирхийлэл өссөөр байна. Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага буурсан боловч энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил өссөн. КОВИД-19 цар тахлын хямрал нь охид эмэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мөлжлөг, үл хайхрах байдал, хүчирхийлэлд өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

⁴ НҮБХАС Монгол. КОВИД-19: Нөхцөл байдлын тайлан №5. 2020 оны 11 сар



Хөдөлмөр эрхлэлт ба орлого

- КОВИД-19 цар тахлын эсрэг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ нь Монгол Улсын эдийн засагт хүндрэл учруулсаар байна. Эмэгтэйчүүд давамгайлсан салбар болох ЖДҮ эрхлэгчдийн хөрөнгийн эргэлт, эрэлт, нийлүүлэлт буурч, бараа материал, түүхий эдийн нийлүүлэлт тасалдах зэрэг бэрхшээлтэй тулгарч байна. Жижиг бизнес эрхлэгчид түрээсийн төлбөр, зээлийн эргэн төлөлтөө хийж чадахгүйд хүрсэн. ЖДҮ-ийн салбарт бизнес эрхлэгчдийн орлого буурч, бизнесийнхээ ирээдүйд итгэл алдарч байна.
- Хөдөлмөрийн тухай хуульд ажилтны буруу биш шалтгаанаар гарсан сул зогсолтын хугацаанд ажил олгогч нь ажилтанд олговор олгохоор заасан.⁵ КОВИД-19 цар тахлын улмаас дийлэнх ААН-ийн үйл ажиллагаа зогссон хэдий ч эдгээр аж ахуйн нэгжүүд хуулийн дээрх заалтад хамаарч сул зогсолтын олговор олгох ёстой эсэх нь тодорхойгүй байна. ААН-үүдээс энэ талаар тодруулахад, хөл хорио эхлэхээс ч өмнө санхүүгийн хүндрэл бэрхшээлтэй тулгарч эхэлсэн тэдний хувьд ажилтандаа сул зогсолтын үеийн олговор олгосон тохиолдол гараагүй.
- Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн талаар хүйсээр ангилсан тоон мэдээлэл дутмаг байна. Түүнчлэн, эмэгтэй өмчлөгчтэй ЖДҮ-ийг тодорхойлсон хуулийн албан ёсны тодорхойлолт байдаггүй. Хуулиар энэхүү тодорхойлолтыг баталгаажуулснаар хүйсээр ангилсан тоон мэдээллийн санг бий болгож улмаар энэхүү тоон мэдээлэлд үндэслэн бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг бодитоор дэмжих, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд түлхэц болно. Эмэгтэй өмчлөгчтэй ЖДҮ-д зориулсан техникийн туслалцаа, бизнесийг цаашид хэрхэн үргэлжлүүлэх төлөвлөгөө боловсруулах болон бизнесийн тохирсон загвар гаргах талаар дэмжлэг үзүүлэхүйц зөвлөх үйлчилгээ үгүйлэгдэж байна.
- Орлого нь буурсан эсвэл орлогогүй болсон хувиараа хөдөлмөр эрхлэгчид зээлийн төлбөр, нийгмийн даатгал, татвар, түрээсийн төлбөр төлөхөд хүндрэл учирч байна. Хөл хорионы улмаас албан бус буюу хувиараа хөдөлмөр эрхэлдэг эмэгтэйчүүд түлхүү ажилладаг худалдаа, үйлчилгээний салбар хаагдсан нь тэдэнд хүндээр тусаж байна.
- Цар тахлын улмаас тогтоосон хөл хорионы үед, эмэгтэйчүүд хөлсгүй хөдөлмөрт ихэнх цагаа зарцуулж байгаа нь өөртөө анхаарал тавих, суралцах, хөгжихөд нь сөргөөр нөлөөлж байна. Мөн ахмад настай эмэгтэйчүүд сургууль, цэцэрлэг хаагдсаны улмаас ач, зээ нараа харах ажилд илүү дайчлагдах болсон. Гэрийн ажил дах хөдөлмөрийн тэгш бус хуваарилалт нь жендэрийн хэвшмэл ойлголт болон нийгмээс тулгах хэм хэмжээний талаарх үзэл хандлагатай шууд холбоотой.
- Хөл хорионы арга хэмжээний улмаас өрхийн орлого багасч, гэр бүлийн гишүүд, садан төрлийн хүмүүсийн бие биедээ үзүүлэх дэмжлэгт сөргөөр нөлөөлсөн. Өндөр настан, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүдээ асрах, гэр орны ажилд туслах, бусад сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх нь багассан байна.

⁵ Хөдөлмөрийн тухай хууль, 56-р зүйл

Төрөөс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ



- КОВИД-19 цар тахлын сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор Засгийн газраас амьжиргааг дэмжих тэтгэмж, халамжийг нэмэгдүүлсэн нь эмзэг бүлэгт дэмжлэг болж чадсан. Гурав ба түүнээс дээш хүүхэдтэй ганц бие өрх толгойлсон эцэг, эхэд өгөх нийгмийн халамжийн тэтгэмж, хүнсний эрхийн бичгийн мөнгөн дүнг нэмэгдүүлсэн нь зохих эзэндээ хүрч, ялангуяа нийгмийн хамгийн ядуу бүлэг, эмзэг бүлгийн эмэгтэйчүүдэд хүрч чадсаныг статистик мэдээлэл болон гүнзгийрүүлсэн ярилцлага харуулж байна. Хүүхдийн мөнгө, нийгмийн даатгалын хөнгөлөлт, татварын чөлөөлөлт нь өрхөд шууд орлого болон хүрсэн. Өрхийн хэрэглээний дүн 2020 оны 1-р улиралд эрс буурч байсан ч 2, 3-р улиралд өссөн үзүүлэлттэй байна.
- Орон нутгийн болон үндэсний хэмжээнд шийдвэр гаргагчид, хууль сахиулах байгууллагуудын хооронд харилцан үл ойлголцол ажиглагдсан. Орон нутгийн болон үндэсний хэмжээнд шийдвэр гаргагчид, хууль сахиулах байгууллагуудын авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, өгч байгаа мэдээлэл нь хоорондоо зөрөлдөөнтэй байсныг судалгаанд оролцогчид мэдээлсэн. Мөн теле хичээл явуулах, аж ахуйн нэгжид үзүүлсэн хөнгөлөлт, чөлөөлөлт зэрэг цар тахлын эрсдэлийг бууруулах арга хэмжэээр дүнгээ өгч буй эсэхэд тэд эргэлзэж байна. Сайн дурын болон цалингүй хөдөлмөр эрхэлдэг эмэгтэйчүүдийн ихэнх нь гэр бүлийн бизнес буюу албан бус салбарт хамаарагддаг бөгөөд хөл хорионы улмаас бизнесийн үйл ажиллагаа нь хаагдсан. ЗГ-ын зүгээс эдгээр албан бус салбарыг дэмжсэн бодлого үгүйлэгдэж байна.
- Шийдвэр гаргах үйл явц дахь жендэрийн тэгш бус байдал эрс зөрүүтэй байна. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт сул, шийдвэр гаргах түвшинд жендэрийн квот хангагдаагүй байгаа нь эмэгтэйчүүдийн оролцоог хязгаарлаж, улмаар цар тахлын үед эмэгтэйчүүдийн ялгаатай хэрэгцээ шаардлагыг хайхрахгүй өнгөрөөх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Улсын Онцгой Комисс нь 26 гишүүнтэйгээс дөнгөж 3 буюу 11.5 хувь эмэгтэй байна.

Эмзэг бүлэг



- КОВИД-19 цар тахлаас ч өмнө байсан ядуурал, тэгш бус байдал нь нийгмийн эмзэг бүлгүүд буюу охид, эмэгтэйчүүд, ХБХ, өндөр настай эмэгтэйчүүд, шилжилт хөдөлгөөн хийсэн эмэгтэйчүүд, ялангуяа хөдөө орон нутагт амьдарч буй эмзэг бүлгийн иргэдэд сөргөөр нөлөөлсөөр байна. Тэдний олонх нь ажилгүйдэл, хөдөлмөрийн дутуу ашиглалт болон орлогогүй болсноос үүдэлтэйгээр ядууралд гүнзгий өртөх өндөр эрсдэлтэй байна.
- Цар тахал нь олон ядуу өрхийн тэр дундаа охид эмэгтэйчүүдийн хоол хүнсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байна.
- КОВИД-19 цар тахал нь охид, эмэгтэйчүүд, ахмад настан болон ХБХ-ийн хувьд хүчирхийлэл, үл хайхрах байдал, мөлжлөг, болон бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Гэрийн ажил болон теле хичээлээс үүдэлтэйгээр өрх толгойлсон ганц бие эхчүүдийн дунд санаа зовох байдал, бухимдал, стрессийн түвшин нэмэгдэж байна.
- Дижитал хэрэглээний ялгаатай байдал нь эмзэг бүлэг, тэр дундаа хөдөө орон нутагт амьдардаг хүүхэд, залуучуудын боловсрол дахь тэгш бус байдлыг нэмэгдүүлсээр байна. Алслагдсан



бүс нутаг, хөдөөгийн болон гэр хорооллын хүүхдүүд ухаалаг утас, компьютер техник дутмаг, интернэт сүлжээ хангалтгүйгээс боловсролын үйлчилгээг хүртээмжтэй авч чадахгүй байна. Хөдөө орон нутгийн хүүхдүүдийн дунд цахим хичээлээс завсардах, багш нартайгаа болон үе тэнгийхэнтэйгээ тогтмол харилцаж чадахгүй байдал элбэг байна.

- Цөөн малтай малчин өрх, тэдний гэр бүлийн эмэгтэй гишүүд КОВИД-19 цар тахлын нөлөөнд илүүтэй өртөж байна. Цар тахал төдийгүй, зудын нөхцөл байдал нь тэдний амьдрал ахуйд сөргөөр нөлөөлөхийн зэрэгцээ хөлсгүй хөдөлмөрт зарцуулах цаг хугацаа нь теле хичээлтэй холбоотойгоор улам ихэссэн байна.
- КОВИД-19 цар тахлын улмаас хил хаасан нь хилийн ойролцоох боомт болон суурин газар амьдардаг иргэдийн аж амьдралд ихээхэн өөрчлөлтийг бий болгож байна. Улмаар дотоодын шилжилт хөдөлгөөнд энэ нь нөлөөлж болзошгүй боловч хүйсээр ангилсан тоон мэдээлэл хангалтгүй тул жендэрийн нөлөөллийг үнэлэхэд бэрхшээлтэй байна.

2. ТАНИЛЦУУЛГА

Монгол улсад КОВИД-19 цар тахлын зөөвөрлөгдсөн анхны тохиолдол 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдөр бүртгэгдсэн бол 2020 оны 11-р сарын 10-ний өдөр дотоодын халдвар анх батлагдсан. Засгийн газрын зүгээс КОВИД-19 цар тахлын халдвар тархах эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлж байна. 2020 оны 12 сарын 23-ны өдрийн байдлаар Монгол улсад 1063 хүн коронавирусын халдвараар өвчилж, 541 хүн эдгэрч, 513 хүн эмчлүүлж байгаа бөгөөд 9 гадаадын иргэн өөрийн хүсэлтээр эх орондоо буцсан. Дотоодын халдварын нийт 671 тохиолдлын 452 нь эмэгтэйчүүд бөгөөд одоогийн байдлаар халдварын улмаас нас барсан тохиолдол бүртгэгдээгүй байна.

2020 оны 1-р сарын сүүлээс эхлэн хэсэгчилсэн хөл хорио тогтоож, олон хүний бөөгнөрөл үүсгэхгүй байх, хил хаах, аймаг хот хоорондын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түр хориглох, зарим худалдаа, үйлчилгээ, олон нийтийн үйл ажиллагаа, бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагааг зогсоох зэрэг арга хэмжээг авахын зэрэгцээ иргэдийг олон нийтийн газарт заавал амны хаалт зүүхийг шаардаж байв. Хэдийгээр сүүлийн арван сарын хугацаанд дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлж байсан ч 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр дотоодын халдварын анхны тохиолдол бүртгэгдсэн. Иймээс КОВИД-19 цар тахлын дэгдэлтийг хумихын тулд Засгийн газраас өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг нэмэгдүүлж бүх нийтийн бэлэн байдлын зэрэг буюу хатуу хөл хорионы дэглэмд⁶ шилжүүлсэн. Хатуу хөл хорионы үед дээрх шаардлагуудыг үргэлжлүүлэн мөрдөхөөс гадна хүнсний дэлгүүр, эм, эмнэлгийн үйлчилгээ авах зэргээс бусад тохиолдолд аль болох гэрээсээ гарахгүй байхыг иргэдэд анхааруулж байв.

КОВИД-19 цар тахлын үр нөлөөг гүйцэд тодорхойлоход эрт байгаа хэдий ч Монгол улсын нийгэм, эдийн засагт учруулж буй үр дагавар илт мэдрэгдэж байна. Жишээлбэл ДНБ-ний 66.2 хувийг дангаараа үйлдвэрлэдэг,⁷ 1.6 сая орчим хүн амтай Улаанбаатар хотод КОВИД-19 цар тахлын хүрээнд хэрэгжүүлсэн хөл хорионы улмаас олон аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа бүрэн зогссон. 2020 оны 3-р улирлын байдлаар Монгол Улсын эдийн засаг 7.3 хувиар унасан. Үүнд ДНБ-ний 19.7 хувийг эзэлдэг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн хэмжээ 20.7 хувь буурсан нь нөлөөлсөн байна. Түүнчлэн ДНБ-ний 42.6 хувийг бүрдүүлдэг үйлчилгээний салбар 7 хувь, хөдөө аж ахуйн салбар 16.9 хувь, барилгын салбар 10.8 хувь тус тус буурсан үзүүлэлттэй байна.⁸

Хэдийгээр халамжийн багц арга хэмжээ тус дөхөм үзүүлж байгаа боловч сүүлийн үеийн судалгаанаас харахад КОВИД-19 цар тахал нь нийгмийн эмзэг, ядуу бүлгийнхэнд хүнд тусч байна. Тухайлбал, Монгол дах НҮБХХ-өөс хийсэн түргэвчилсэн үнэлгээнд КОВИД-19 цар тахлын улмаас өрхийн эдийн засгийн нөхцөл байдалд сөргөөр нөлөөлсөн гол хүчин зүйл нь ажилгүйдэл бөгөөд ялангуяа эмэгтэйчүүд зонхилдог ЖДҮ, албан бус, хувиараа хөдөлмөр эрхлэгчид байна гэж дурджээ.⁹ Хөдөлмөр эрхлэлт, цалин хөлсний өөрчлөлтүүд өрхийн орлогод сөргөөр нөлөөлж, өрх толгойлсон эмэгтэйчүүдийн цалин хөлсний орлого 29 хувь буурсан үзүүлэлттэй байна.¹⁰

⁶ Хатуу хөл хорионы дэглэм гэдэг нь бүх нийтийн онцгой байдлын хоёрдугаар түвшинг хэлнэ. Өндөржүүлсэн бэлэн байдал нь эхний түвшин болно.

⁷ УСХ. 2019. Дотоодын нийт бүтээгдэхүүн. https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NS0_0500_007V1

⁸ УСХ. ДНБ-ний 2020 оны 3-р улирлын тайлан

⁹ UNDP. May 2020. Rapid Socio-Economic impact assessment of COVID-19 prevention measures on vulnerable groups and value chains in Mongolia

¹⁰ Мөн тэнд

НҮБХАС-ын судалгаанд¹¹, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн зөрчил 47 хувь өссөн бол нэг цэгийн үйлчилгээний төв, хамгаалах байранд үйлчлүүлсэн ЖСХ/ГБХ-ийн хохирогчдын тоо 87 хувь өссөн байна. Судалгааны үр дүнгээс харахад КОВИД-19 цар тахал нь эрэгтэйчүүдтэй харьцуулахад эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засгийн амьдралд илүүтэйгээр сөрөг нөлөө үзүүлсэн байна. Үүний улмаас жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн ажлын үр дүн, амжилтаасаа ухарч болзошгүй нөхцөлд хүрээд байна.

Дэлхийн олон улс оронд короновирусын тархалтыг зогсоохын тулд авч хэрэгжүүлж буй Засгийн газрын арга хэмжээнүүдийн улмаас үйлчилгээний салбарууд тухайлбал жижиглэн худалдаа, боловсрол, хоолны үйлчилгээ, зоогийн газар, зочид буудал, аялал жуулчлал, соёл урлагийн салбарууд буюу эмэгтэйчүүд олноор ажилладаг салбарууд ихээхэн өртөж, улмаар орлого нь буурсан байна. Түүнчлэн цэцэрлэг, сургууль, өдөр өнжүүлэх төвүүдийг хаасны улмаас хүүхэд харах, хөгжлийн бэрхшээлтэй эсхүл өвчтэй гэр бүлийн гишүүнээ асрах, гэрийн ажлын ихэнх ачааллыг эмэгтэйчүүд үүрч байна. Монгол улсад эмэгтэйчүүд гэрийн хөлсгүй хөдөлмөрт өдөрт 273 минут (ойролцоогоор 4.5 цаг) зарцуулдаг нь эрэгтэйчүүдээс 2.6 дахин их байгааг цаг ашиглалтын судалгаанд¹² дурджээ.

Цар тахлын улмаас өмнө байсан тэгш бус байдал гүнзгийрч, нийгэм, улс төр, эдийн засгийн тогтолцооны сул тал нь охид, эмэгтэйчүүдэд үзүүлэх цар тахлын сөрөг нөлөөллийг улам бүр нэмэгдүүлж байгааг НҮБ-ийн бодлогын зөвлөмжид онцолсон байна.¹³ Мөн охид, эмэгтэйчүүд нь аливаа гамшиг, онцгой байдлын үед ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийн хохирогч болох, ажил хөдөлмөр эрхлэх боломжоороо хязгаарлагдах зэргээр хамгийн их эрсдэлд өртөж байдгийг НҮБХХ-өөс анхааруулсан байна.¹⁴ Тиймээс КОВИД-19 цар тахлын эсрэг Засгийн газрын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь жендэрийн мэдрэмжтэй байдлыг хангаж, онцгой байдлын үед хүний эрх, нэр төрийг хүндэтгэх зарчмыг баталгаажуулах нь амин чухал бөгөөд хэрэгжилтэд байнгын хяналт тавих шаардлагатай байна.

2.1 Судалгааны ажлын хүрээ

КОВИД-19 цар тахлын улмаас охид, эмэгтэйчүүдэд хамгийн их нөлөө үзүүлж буй нийгэм-эдийн засгийн салбарыг тодорхойлохын тулд дараах асуудлыг харгалзан үзсэн:

- Аль салбарт охид, эмэгтэйчүүд түлхүү хамрагдаж байна?
- Эдгээр салбарын хүрээнд КОВИД-19 цар тахлын нөхцөл байдал нь охид, эмэгтэйчүүдэд хэрхэн нөлөөлж байна вэ?
- КОВИД-19 цар тахал нь охид, эмэгтэйчүүдийн аж амьдрал, эдийн засгийн үйл ажиллагаанд тодорхой нөлөө үзүүлсэн үү?

Дээрх асуултад хариулт олохын тулд холбогдох баримт бичиг, тайлан мэдээ, хэрэгжүүлж буй бодлого болон санаачлагууд, улс орон даяар хийсэн судалгаа, үнэлгээний тайлан, жендэрийн зөрүүтэй байдлын индексийн шалгуур үзүүлэлт зэргийг судалж, оролцогч талуудтай зөвлөлдсөн.

¹¹ НҮБХАС Монгол. КОВИД-19: Нөхцөл байдлын тайлан №1. 2020 оны 6 сар.

¹² ҮСХ. Цаг ашиглалтын судалгаа. УБ. 2019.

¹³ НҮБ. Бодлогын зөвлөмж: КОВИД-19-ийн нөлөө эмэгтэйчүүдэд. 2020 оны 4 сар

¹⁴ UNDP. 2020. Briefing note: The economic impacts of COVID-19 and gender inequality. Recommendations for policy makers

Судалгааны чиглэлийг тодорхойлоход үндэсний онцлог шинж чанар, хэнийг ч үл орхигдуулах зарчмыг харгалзан үзсэн болно.

Эцэст нь, КОВИД-19 цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, хариу арга хэмжээг үнэлэх НҮБХХ-ийн аргачлал, судалгааны удирдамж болон НҮБХХ, АХБ, ХНХЯ-тай хамтран ажилласны дүнд КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах арга хэмжээ нь охид, эмэгтэйчүүдийн аж амьдрал, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалд хэрхэн нөлөөлж байгааг үнэлэх зорилгоор дараах салбаруудыг сонгон судаллаа. (Зураг 1).

Зураг 1. Сонгогдсон салбарууд



НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭ



Коронавирус нь нийгмийн үйлчилгээнд тулгамдаж буй асуудлуудыг улам бүр даамжруулж, иргэдэд хүрч буй боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжид сөргөөр нөлөөлж байна. Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг хэзээ ч орхигдуулж болохгүй бөгөөд ялангуяа цар тахлын үед энэхүү үйлчилгээг анхааралгүй орхих нь ихээхэн хор уршиг дагуулж болзошгүй.

Монгол улсад боловсрол, эрүүл мэндийн салбарт эмэгтэйчүүд хамгийн ихээр ажилладаг бөгөөд багш нарын 80.2 хувь¹⁵, эрүүл мэндийн ажилчдын 81.9 хувь¹⁶ нь эмэгтэйчүүд байна. Хөл хорио, хязгаарлалттай холбоотой арга хэмжээ нь эмэгтэйчүүдийг эмчийн тогтмол үзлэг хяналт, бэлгийн

¹⁵ ЭМХТ. Монгол улсын эрүүл мэндийн үзүүлэлт 2019

¹⁶ ҮСХ. 2019. Бүх шатны сургалтын байгууллагын үндсэн багш. https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NS0_2002_067V1

болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдахад илүү төвөгтэй болгож болзошгүй. Түүнчлэн, нийгмийн хамгааллын арга хэмжээ нь охид, эмэгтэйчүүдийн аж амьдралд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг. Цар тахлын үед дэлхийн ихэнх улс орон нийгмийн хамгааллын үйлчилгээний хамрах хүрээгээ өргөжүүлж байгаа бөгөөд Монгол улсын Засгийн газар мөн адил нийгэм эдийн засгийг дэмжих багц арга хэмжээ, тухайлбал хүнсний эрхийн бичгийн үнийн дүнг хоёр дахин нэмэгдүүлэх гэх мэт нийгмийн халамжийн бусад арга хэмжээг өргөн хүрээтэйгээр хэрэгжүүлж байна. Үүнээс үзэхэд КОВИД-19 цар тахлын үед авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, түүний дотор нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээ нь охид, эмэгтэйчүүдэд хэрхэн нөлөөлж байгааг дэлгэрүүлэн судлах шаардлагатай байна.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БА ОРЛОГО



КОВИД-19 цар тахал нь ажилгүйдэл, ядуурлын түвшин өндөртэй улс орнуудын макро эдийн засгийн нөхцөл байдлыг улам бүр сулруулж байна. Олон нийтийн хөл хорио тогтоож, хил хаасны улмаас экспорт, импортод тулгарч буй бэрхшээл нь бизнес эрхлэгчид, тэр дундаа олон ЖДҮ эрхлэгчдэд хүндээр тусаж байна.

ТӨРӨӨС КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ



Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, иргэд олон нийтийг КОВИД-19 цар тахлын халдвараас цаашид хамгаалах үүднээс Монгол Улсын Их Хурал 2020 оны 4-р сарын 29-ний өдөр “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль” батлан хэрэгжүүлж эхэлсэн. Мөн 2020 оны 1-р сараас эхлэн Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комисс нь зайлшгүй шаардлагын үүднээс нэмэлт хурлуудыг тогтмол зохион байгуулж олон арга хэмжээ, бодлогын шийдвэрүүдийг гарган хэрэгжүүлж байна.

ЭМЗЭГ БҮЛЭГ



КОВИД-19 халдвар дотоодод бүртгэгдсэн нь эмзэг бүлгийн иргэдийн нөхцөл байдал илүү хүндрэх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Энэхүү судалгаанд эмзэг бүлгийг тодорхойлохдоо Нийгмийн халамжийн тухай Монгол Улсын хууль¹⁷, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг¹⁸ тус тус үндэслэл болгон авч үзсэн. Бие бялдар, нийгэм, эрүүл мэндийн байдал нь бусдаас сул дорой, хүн амын зонхилох хэсэгтэй харьцуулбал эдийн засаг, хүрээлэн буй орчин, нийгэм, эсхүл соёлын ялгаатай шинж чанараасаа шалтгаалан гадуурхагдсан буюу үл ойшоогдсон бүлэг хүмүүсийг эмзэг бүлэгт багтаан авч үздэг. Гэвч дээр дурдагдаж буй бүх хүнийг эмзэг бүлэгт хамруулах нь учир дутагдалтай бөгөөд хувь хүн бүр өөрийн гэсэн нийгэмд эзлэх байр суурь, үнэлэмжтэй гэдгийг бодолцох хэрэгтэй. Эмзэг бүлгийг энэхүү судалгаанд илүү нарийвчлан дараах бүлгүүдэд анхаарч судалсан.

¹⁷ Нийгмийн халамжийн тухай хууль. 2012. <https://www.legalinfo.mn/law/details/393>

¹⁸ Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль 2020. <https://www.legalinfo.mn/law/details/15312?lawid=15312>

Өрх толгойлсон эмэгтэйчүүд



Бэлэвсэн, салсан, тусдаа амьдарч буй эсвэл ганцаараа бие даан амьдрах сонголт хийсэн ганц бие өрх толгойлсон эхчүүд нь ажил орлогогүй болох, хүүхэд асрах зэргээр цар тахлын үед хүндрэл бэрхшээлтэй нүүр тулж байна. Тэдний нийгмийн дэмжлэг буюу сургууль, цэцэрлэг, өдөр өнжүүлэх төв зэрэг байгууллагууд хаагдаж, олон нийт болон гэр бүлийн бусад гишүүд, ах дүү, хамаатан саднаасаа авах тусламж хумигдсанаар ажлын ачаалал нь ихээхэн нэмэгдсэн.

Охид болон залуу эмэгтэйчүүд



Цар тахлын дэгдэлт нь охид, залуу эмэгтэйчүүдийн аюулгүй байдал, аж амьдрал, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжид сөрөг нөлөө үзүүлж байна. Ялангуяа, орлого багатай гэр бүлийн өсвөр насны охид, залуу эмэгтэйчүүд нь сэтгэл санааны болон бие махбодын хүчирхийлэлд өртөх эрсдэл өндөр байна. Тус судалгаагаар 15-24 насны охид, эмэгтэйчүүдийг энэ бүлэгт хамруулан авч үзсэн.

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд



Цар тахлын үед 55 ба түүнээс дээш насны иргэд, өмнө нь ямар нэгэн байдлаар эмзэг байдалд байсан хүмүүс илүү их эрсдэлд ордог байна. Гэрийн ажлын ачаалал, стресс, орлогогүй болох, нийгмээс тусгаарлагдан ганцаардах зэрэг нь бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэндэд нь эрсдэл учруулж байна.

Малчин эмэгтэйчүүд



Хөдөө орон нутагт ядуурлын түвшин өндөр (30.8 хувь) байгаа бөгөөд таван малчин тутмын гурав нь ядуу байна¹⁹. Цаг агаарын өөрчлөлт, өвөлжилт хүндэрсэн зэрэг нь цар тахлын нөхцөл байдалтай хавсран малчдын амьжиргаанд сөргөөр нөлөөлж байна.

Шилжин суурьшсан эмэгтэйчүүд



Төв суурин газар, уул уурхайн бүс нутагт чиглэсэн шилжих хөдөлгөөн сүүлийн жилүүдэд ихэссэн бөгөөд энэ нь тухайн хөдөлгөөнт хүн ам, шилжин суурьшигчид төдийгүй орон нутагт хүндрэл, бэрхшээлийг бий болгож байна. Цар тахал нь улирлын чанартай болон, гадаад, дотоодод шилжин суурьшиж ажил хөдөлмөр эрхлэгчдийн нөхцөл байдалд учрах эрсдлийг нэмэгдүүлж болзошгүй байна. Хөл хорио, зорчих хөдөлгөөн болон нислэгийн хязгаарлалт, нийгмийн тусгаарлалт зэрэг нь тэдний амьжиргаа, ажиллах нөхцөлд сөргөөр нөлөөлж байна.

2.2 Судалгааны арга зүй

Судалгааны үр дүнг КОВИД-19 цар тахлын охид, эмэгтэйчүүдийн аж амьдралд үзүүлж буй нөлөөллийн талаар илүү тодорхой ойлголттой болох, судалгааны зорилгыг хангах үүднээс доорх

¹⁹ Дэлхийн Банк, УСХ. Өрхийн нийгэм, эдийн засгийн 2018 оны судалгааны мэдээлэлд суурилсан Ядуурлын дүр төрх 2018 тайлан. 2020 он.

арга, аргачлалуудыг энэхүү судалгаанд ашиглав. Нийгэм-эдийн засгийн янз бүрийн түвшин дэх үзүүлэлт, мэдээллүүдийг цуглуулан, дүн шинжилгээ хийлээ. КОВИД-19 цар тахлын охид, эмэгтэйчүүдэд үзүүлж буй нөлөөллийн талаарх тус судалгаа нь хатуу хөл хорио тогтоохоос өмнөх (2020 оны 3-р сарын 10-наас 11-р сарын 11-ний хооронд) болон дараах (2020 оны 11-р сарын 12-оос 12-р сарын 23-ны хооронд) хугацааг хамруулсан.

Хүний эрх, жендэрт суурилсан аргачлалд тулгуурлан дүн шинжилгээ хийх замаар иргэдийн аж амьдрал, бодлого боловсруулах үйл явцад хүний эрхийг дээдлэх зарчмыг хэрхэн хангаж, тусган ажиллаж байгааг тус судалгаанд анхааран авч үзсэн. Энэ нь цар тахалтай холбоотой бодлого, журмын хэрэгжилт эмэгтэйчүүдийн оролцооны түвшин; цар тахлын үе дэх жендэрийн зөрүүтэй байдал; соёлын хэм хэмжээ, орон нутгийн нийгэм эдийн-засгийн үзүүлэлт болон жендэрийн асуудал зэргийг дүгнэн шинжлэхэд тус дөхөм болсон.

Хоёрдогч мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ

КОВИД-19 цар тахлын охид, эмэгтэйчүүд, тэдний гэр бүлд үзүүлж буй нөлөөллийн талаарх хоёрдогч тоон мэдээлэл, бодлогын бичиг баримт, тайлан мэдээ, төрөөс цар тахлын эсрэг авч хэрэгжүүлж буй хариу арга хэмжээ, хууль тогтоомжийг холбогдох яам, агентлагаас авч зэрэгцүүлэн судалсан. Хоёрдогч тоон мэдээллийг харилцан уялдаа бүхий дараах дөрвөн чиглэлд хамруулан дүн шинжилгээ хийсэн: (i) нийгмийн үйлчилгээ, (ii), хөдөлмөр эрхлэлт ба орлого, (iii) КОВИД-19 цар тахлын эсрэг төрөөс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ (iv) эмзэг бүлэг. Тоон болон чанарын мэдээллийг нас, хүйс, газарзүйн байршил, хот хөдөө, хөгжлийн бэрхшээл, боловсролын түвшин, шилжилт хөдөлгөөн, гэр бүлийн байдал, өрхийн бүтэц, хөдөлмөр эрхлэлт зэргээр нь ангилан авч үзсэн.

Чанарын судалгаа

Хөл хорионы улмаас фокус бүлгийн болон ганцаарчилсан уулзалтуудыг биечлэн хийх боломжгүй болсон тул утсаар ярилцлага хийх аргыг хэрэглэсэн. Төрийн үйлчилгээ, мэдээллийн хүртээмж, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны талаар мэдээллийг авах үүднээс яам, агентлаг, төрийн болон төрийн бус байгууллагууд, мэргэжилтнүүд, олон нийтийн төлөөллүүдтэй холбогдож дээр дурдсан харилцан хамаарал бүхий салбаруудын хүрээнд ярилцсан (Зураг 1).

Нас, хүйс, хөгжлийн бэрхшээл зэрэг нийгмийн байдлаар нь ялгаварлахгүйгээр үйлчилгээ үзүүлж байгаа эсэх, хөл хорио нь иргэдийн аж амьдрал, эдийн засгийн нөхцөл байдалд хэрхэн нөлөөлж буйг тодруулах зорилгоор нийт 100 оролцогчтой (68 эмэгтэй, 32 эрэгтэй) утсаар гүнзгийрүүлсэн ярилцлага хийсэн болно. (Хүснэгт 1)

КОВИД-19 цар тахал нь хот, хөдөөгийн охид, эмэгтэйчүүдэд хэрхэн нөлөөлж байгааг харьцуулан судлахын тулд газарзүйн ялгаатай байрлалд буй Завхан, Хэнтий, Дундговь аймаг болон Улаанбаатар хотыг дараах шалгуур үзүүлэлтээр сонгосон:

1. **Байршил.** Хэнтий аймаг нь Монгол улсын зүүн бүс, Дундговь аймаг нь төвийн бүсэд харьяалагддаг бол Завхан аймгийг баруун бүсийн төлөөлөл болгон сонгож авсан. Монгол улсын нийслэл Улаанбаатар хотыг хүн амын төвлөрлийн хувьд зайлшгүй сонгох шаардлагатай гэж үзсэн болно.

2. **Ядуурлын түвшин.** Ядуурлын түвшин Дундговь аймагт 21.7 хувь, Завхан аймагт 25.7 хувь байгаа нь улсын дунджаас (28.4 хувь) доогуур байхад, Хэнтий аймагт 38 хувь байгаа нь улсын дунджаас өндөр байна. 2016-2018 оны хооронд хөдөөгийн ядуурал 29,6 хувиас 28.5 хувь болж ялимгүй буурсан ч хөдөө орон нутгийн ядуурлын түвшин нь хот суурин газартай харьцуулбал өндөр хэвээр байна. Ядуу иргэдийн 63.5 хувь нь хот суурин газарт, ялангуяа Улаанбаатар хотод ядуу иргэдийн 41.8 хувь нь амьдардаг тул тус судалгаанд дээрх аймаг, хотыг зориуд сонгосон.²⁰
3. **Цаг агаарын төлөв байдал, ган, зудын эрсдэл.** Аймгуудыг сонгохдоо уур амьсгалын өөрчлөлт, ган, зудын эрсдлийг харгалзан үзсэн. Дундговь аймгийн Дэлгэрцогт сум нь зудын эрсдэл ихтэй, Хэнтий аймгийн Жаргалтхаан сумыг отрын бүс нутаг, Завхан аймгийн Яруу сумыг зудын эрсдэл багатай нутаг хэмээн авч үзэж сонгосон. Цаг агаартай холбоотой хүчин зүйлсийн улмаас малчид зудын эрсдэлийг даван туулахын тулд бусад газар нутагт оторлоход хүрч байна. 2020 онд Дундговь аймагт өвөлжилт хүндэрсэн тул олон малчид Төв болон Хэнтий аймагт отор хийж байна.²¹
4. **Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний оролцооны түвшин.** Судалгаанд хамрагдах аймгуудыг сонгохдоо хөдөлмөр эрхлэлт болон ажиллах хүчний оролцооны түвшинг авч үзсэн. Завхан аймагт эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 81.9 хувь, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 81.1 хувь байгаа нь улсын хэмжээнд хамгийн өндөр байна. Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин Дундговь аймагт 62.0 хувь, Хэнтий аймагт 58.2 хувь байгаа бол хөдөлмөр эрхлэлтийн түвшин Дундговь аймагт 59.0 хувь, Хэнтий аймагт 56.3 хувь байгаа нь улсын дундажтай ойролцоо байна. Улаанбаатар хотод эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 45.8 хувь, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин 43.0 хувь²² байгаа нь дээр дурдсан аймгуудтай харьцуулахад арай доогуур түвшинд байна.

Чанарын судалгааны мэдээллийг цуглуулахдаа **утсаар гүнзгийрүүлсэн ярилцлага хийх** аргыг ашигласан бөгөөд эхлэн ярьсан оролцогчоос дараагийн ярилцах боломжтой хүний утасны дугаарыг авч холбогдох замаар (цасан бөмбөлгийн аргаар) мэдээлэл цуглуулсан болно.

Хүснэгт 1. Гүнзгийрүүлсэн ярилцлагад оролцогчдын мэдээлэл

Ярилцлагад оролцогчид	Улаанбаатар		Завхан		Хэнтий		Дундговь		Бүгд
	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	
ЖДҮ, хувиараа хөдөлмөр эрхлэгч	4	4	1	3	1	3	1	3	20
Малчин, шилжин суурьшигч иргэн	2	2	1	3	1	3	1	3	16
ХБХ, ахмад настан	2	2	1	3	1	3	1	3	16
Өрх толгойлсон эцэг, эх	2	2	1	3	1	3	1	3	16
Охид, залуу эмэгтэйчүүд	2	2	1	3	1	3	1	3	16
Багш, эрүүл мэндийн ажилтнууд	2	2	1	3	1	3	1	3	16
Бүгд	14	14	6	18	6	18	6	18	100

²⁰ Дэлхийн Банк, УСХ. Өрхийн нийгэм, эдийн засгийн 2018 оны судалгааны мэдээлэлд суурилсан Ядуурлын дүр төрх 2018 тайлан. 2020

²¹ Дундговь аймгийн бэлчээрийн даац 2019-2020 он. 2020, <http://dundgov.gov.tsag-agaar.gov.mn/>

²² УСХ. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшин. 2020 он 3-р улирал, https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_0400_035V3



Судалгааны хязгаарлагдмал байдал

Энэхүү судалгаа нь дараах хэд хэдэн хязгаарлагдмал талтай байсан. Нэгдүгээрт, хөл хорионы дэглэм нь судалгааны арга зүй болон оролцогчдын тоог хязгаарласан. Судалгааны түүврийн хэмжээ бага байгаа нь төлөөлөх чадварт нөлөөлөх, түүвэрлэлтийн алдаа үүсгэх магадлалыг нэмэгдүүлж байна. Чанарын судалгаанд зөвхөн утсаар ярилцлага хийх аргыг ашигласан нь цаг хугацааны хувьд хязгаарлагдмал, нүүр тулсан ганцаарчилсан ярилцлагын адил оролцогчдыг биеийн хэл, нөхцөл байдлыг ажиглах боломж олгодоггүй сул талтай. Түүнчлэн, КОВИД-19 цар тахалтай холбоотой үндэсний хэмжээний хүйсээр ангилсан судалгаа, мэдээлэл дутмаг байсан нь судалгааны хязгаарлагдмал байдлыг нэмэгдүүлж байлаа.

Судалгааны ёс зүй

Судалгааны зорилго, ярилцлагын талаар оролцогчдод дэлгэрэнгүй тайлбарлаж, судалгаанд хамрагдах зөвшөөрлийг утсаар авсан бөгөөд нууцлалыг чандлан хадгалах тухай танилцуулсан болно. Ярилцлагын үед дараах ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллав.

1. Судалгаанд оролцогчдын аюулгүй байдал болон хувь хүний эрхийг дээдлэх тал дээр анхаарал тавьж байсан. Охид, эмэгтэйчүүдийн утсаар чөлөөтэй, тайван ярих боломжийг анхаарсан.
2. Судалгаанд оролцогчдын хувийн орон зай, нууцлалыг хамгаалсан.
3. Ярилцлагын явцад оролцогчдын сэтгэл санааны байдлыг хүндэтгэн үзлээ.


3. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

3.1 Нийгмийн үйлчилгээ

Эрүүл мэндийн үйлчилгээ

Монгол Улс нь засаг захиргааны бүх түвшинд эрүүл мэндийн үйлчилгээг өргөн хүрээнд үзүүлэх хүчин чадал бүхий эрүүл мэндийг тогтолцоог бүрдүүлж чадсан улс боловч эрүүл мэндийн салбарт эмэгтэйчүүд давамгайлж байгаа нь хүний нөөцийн хувьд хүйсийн тэнцвэр алдагдсаныг харуулж байна. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн статистик мэдээгээр²³ нийт эрүүл мэндийн салбарын ажилтнуудын 81.9 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байгаа нь олон улсын түвшин²⁴ (70 хувьтай харьцуулахад өндөр үзүүлэлт юм.

Эрүүл мэндийн ажилтнууд нь коронавируст цар тахалтай тэмцэх ажилд тэргүүн эгнээнд ажиллаж байна. 2020 оны 12-р сарын 15-ны байдлаар 41 эрүүл мэндийн ажилтан коронавирусын халдвар авсан²⁵ бөгөөд энэхүү тоон мэдээллийг хүйсээр ангилаагүй байна. Цар тахлын энэ үед эрүүл мэндийн ажилтнууд бага цалин урамшууллаар илүү ачаалалтай, өндөр эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байна. Ийм нөхцөл байдлын зэрэгцээ хот, орон нутагт ялгаагүй КОВИД-19 цар тахалтай холбоотой онлайн сургалт (ялангуяа ажлын цаг дууссанаас хойш) зохион байгуулж буй нь ажлын ачааллыг улам нэмэгдүүлж байна. Хөдөө орон нутагт сумын эрүүл мэндийн төвүүдийн төсөв хангалтгүйгээс эмч ажилтнууд хөл хорионы үед эрүүл мэндийн тусгай хамгаалалтын хэрэглэгдэхүүнгүй ажиллахад хүрч байна.


 *КОВИД-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас сумын эрүүл мэндийн төвийн захиргаанаас уртасгасан цагаар ажиллах шинэ ажлын цагийн хуваарийг батлан хэрэгжүүлж байгаа. Бидэнд 24 цагаар ээлжинд гарах үед хамгаалалтын хувцас хэрэгсэл, хоол хүнс өгдөггүй.*

Сумын эмч эмэгтэй, Дундговь

 *Хамгаалалтын хувцсыг удаан өмсөхөд их хэцүү. Материал нь агаар нэвтрүүлдэггүй, хөлрүүлдэг. Хэмжээ нь таардаггүй, чанар муутай.*

Резидент эмч эмэгтэй, Улаанбаатар

Эрүүл мэндийн ажилтнууд ямар ч нөхцөлд, цаг хугацаатай уралдан эрүүл мэндийн шуурхай үйлчилгээ үзүүлж ажилладаг учраас тэдэнд сэтгэлзүйн болон бусад дэмжлэг туслалцаа хэрэгтэй байдаг. Тиймээс ЭМЯ коронавирусээр халдварласан өвчтөнтэй тулж ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтнуудад үндсэн цалин дээр нэмэлт урамшуулал олгосон тухай мэдээлсэн байна.

 *ХӨСҮТ-ийн захирал Д.Нямхүү: ХӨСҮТ-д өнөөдрийн байдлаар 800 гаруй эмч, сувилагч, үйлчлэгч, ажилтан ажиллаж байна. Халдвар гарахаас өмнө эмч нар 1.5 сая төгрөгийн цалинтай байсан бол одоо илүү цаг, нэмэгдэл зэргийг тооцвол дунджаар 4.5 сая төгрөгийн цалин авч байна.²⁶ <https://livetv.mn/p/164583>*

Хөдөлмөр эрхлэлт дэх жендэрийн тэгш бус байдал эрүүл мэнд болон боловсролын асуудалд сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Дэлхий даяар хүүхэд эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ авах байдал цар тахлын үед 20%-иар буурсан байна.²⁷ Монгол улсад эрүүл мэндийн үйлчилгээ

²³ ЭМХТ. Монгол улсын эрүүл мэндийн үзүүлэлт. 2019


²⁴ WHO. Mar 2019. Gender equity in the health workforce: Analysis of 104 countries

²⁵ Ажлын хэсгийн гишүүдийн коронавируст (Ковид-19) халдварын голомтод ажиллаж байгаа эмч, эмнэлгийн ажилтнуудын эрүүл мэнд, цаг үеийн нөхцөл байдлын асуудлаарх цахим хурал. 2020 оны 12 сарын 15. <http://parliament.mn/n/9rbyn>

²⁶ Ажлын хэсгийн гишүүдийн коронавируст (Ковид-19) халдварын голомтод ажиллаж байгаа эмч, эмнэлгийн ажилтнуудын эрүүл мэнд, цаг үеийн нөхцөл байдлын асуудлаарх цахим хурал. 2020 оны 12 сарын 15. <http://parliament.mn/n/9rbyn>

²⁷ UNICEF. GLOBAL COVID-19 Mid-Term Situation Report No. 9, Feb–July 2020.

тасалдуулахгүй үзүүлж байгаа хэдий ч цар тахлын үед олон хүний бөөгнөрөл үүсэхээс сэргийлэх зорилгоор авч хэрэгжүүлж буй хөл хорио тогтоолт нь иргэдийн, ялангуяа хүүхэд эмэгтэйчүүдийн тогтмол авдаг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хүндрэл учруулж байна.²⁸ Хөдөө орон нутагт амьдардаг хүүхэд, өрх толгойлсон эх, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авч чадахгүйд хүрч байгааг чанарын судалгаа харуулж байна.

 Манай охин цусны хавдартай, байнгын хяналтанд байдаг. Сар бүр эмчид тогтмол үзүүлэх ёстой боловч хөл хорионы улмаас бид Улаанбаатар явж хугацаандаа үзүүлж чадаагүй.

Өрх толгойлсон эмэгтэй, Хэнтий

Манай улсад 2020 оны 12 сарын байдлаар КОВИД-19 цар тахлын улмаас нас барсан тохиолдол бүртгэгдээгүй боловч, хөл хорионы үед иргэдийн амь нас эрсдсэн хэд хэдэн тохиолдол гарсан. Эдгээр тохиолдлууд нь улс, нийслэл болон орон нутгийн түвшинд гарсан зөрүүтэй шийдвэрүүд, коронавирусээс айх айдас, мэдээллийн хүртээмжгүй байдал зэргээс үүдэлтэй байна.

Монгол Улс 2000-2015 онд Мянганы хөгжлийн зорилт (МХЗ)-ыг хэрэгжүүлэх хугацаандаа эхийн эндэгдлийн түвшинг амжилттай бууруулж чадсан 9 орны нэг болж байсан.²⁹ Гэвч 2020 оны эхний 11 сарын байдлаар эхийн эндэгдлийн нийт бүртгэгдсэн 23 тохиолдлыг өмнөх 3 жилийн эхийн эндэгдлийн статистик мэдээлэлтэй харьцуулахад 27.8 хувь өссөн нь анхаарал татаж байна. КОВИД-19 цар тахлын хязгаарлалтын дэглэмийн үед эхийн эндэгдэл нэмэгдэж байна. Эдгээр 23 тохиолдлоос 10 нь Улаанбаатар хотод, 5 нь Баян-Өлгий аймагт бүртгэгдсэн. НҮБХАС-ын 2020 оны 11-р сарын КОВИД-19 цар тахлын нөхцөл байдлын тайланд дурдсанаар Баян-Өлгий аймагт гарсан дээрх 5 тохиолдол нь коронавирусын халдвараас болгоомжилж эмнэлэгт хандахаас зайлсхийх, эмэгтэйчүүдийн ар гэрийн ажлын ачаалал, үйл хайхрал болон гэр бүлийн хүчирхийлэл зэрэг хэд хэдэн хүчин зүйлтэй тодорхой хэмжээгээр холбоотой байна.³⁰

Хүснэгт 2. Эхийн эндэгдэл

Хамрах хугацаа	2017 оны эхний 11 сарын байдлаар	2018 оны эхний 11 сарын байдлаар	2019 оны эхний 11 сарын байдлаар	2020 оны эхний 11 сарын байдлаар
Эндсэн эхийн тоо	18	18	18	23

Эх сурвалж: 1212.mn, YCX, 2020 оны эхний 11 сарын байдлаар

Цар тахлын үед охид, эмэгтэйчүүдэд чиглэсэн эмнэлгийн тусламжийг хүргэхдээ үйлчилгээний чанарыг сайжруулах, эмнэлгийн үйчилгээ авах, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний мэдээллийг хүн бүрт ойлгомжтой, хүртээмжтэй хүргэх хэрэгцээ байна.

Гэр бүлийн хүчирхийлэл (энэхүү тайлангийн “Жендэрт суурилсан хүчирхийлэл” хэсгээс нэмэлт мэдээллийг харна уу) өссөний улмаас эмэгтэйчүүдийн эрүүл мэндтэй холбоотой үр дагавар тухайлбал хүүхэд бага жинтэй төрөх, эхийн эндэгдэл, сэтгэл гутрал зэрэг асуудлууд нэмэгдэж болзошгүй байдаг. ДЭМБ-ийн 2013 онд хийсэн “Дотнын хамтрагч болон бусдын зүгээс үйлдсэн бэлгийн хүчирхийллийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөө” судалгаа нь хүчирхийлэлд өртөж байсан


²⁸ НҮБХАС Монгол. КОВИД-19: Нөхцөл байдлын тайлан №5. 2020 оны 11 сар

²⁹ ЖҮХ. Монгол улсын жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ, 2005 оноос өнөөг хүртэлх ололт амжилт ба сорилт, сургамж. УБ. 2019

³⁰ UNFPA Mongolia. November 2020. Situation Report No. 5 on COVID-19 response.

эмэгтэйчүүд эрсдэлт зан үйл, эрүүл мэндийн асуудалтай болох магадлал өндөр байгааг харуулсан байна.³¹ Хүчирхийлэлд өртөж байгаагүй эмэгтэйчүүдтэй харьцуулбал, тэд бага жинтэй хүүхэд төрүүлэх магадлал 16 хувиар их, сэтгэл гутралд орох болон үр хөндүүлэх байдал хоёр дахин их байна.

Хөл хорионы улмаас сургууль, цэцэрлэг хаагдаж, гэр бүлийн гишүүд гэртээ байх болсон тул гэрт харьцангуй их бөөгнөрөл үүсч байна. Гэр бүлийн нягтаршлын судалгаанд өгүүлснээр нэг гэрт хэт олуулаа амьдардаг эмэгтэйчүүд сэтгэл санааны хямралд өртөх нь эрэгтэйчүүдээс илүү байдаг бөгөөд ялангуяа бага насны хүүхэдтэй тохиолдолд сэтгэл санааны гүн хямрал орох эрсдэлийг нэмэгдүүлдэг байна.³² Энэ үзэгдэл ганцаарчилсан ярилцлагын үед мөн ажиглагдаж байсан бөгөөд орлого багатай, олон хүүхэдтэй, нэг гэрт олуулаа бөөгнөрөн амьдардаг эмэгтэйчүүд сэтгэл санааны хямралд өртөх байдал түлхүү байна. Хүснэгт 3-т нэг сууцанд амьдарч буй өрхийн тоон мэдээллийг харуулав.

 Сургуулийн хүүхдүүдтэй бидэнд их хэцүү байна, хичээл ихтэй, гэрийн даалгавар нь ч их юм. Хичээлээс нь болоод бүр санаа зовж, стрессдэж байна.

Өрх толгойлсон эмэгтэй, Дундговь

Хүснэгт 3. Нэг сууцанд амьдардаг өрхийн тоо хот ба хөдөө

	Нэг сууцанд амьдарч буй өрхийн		Өрхийн тоо	
	хот	хөдөө	хот	хөдөө
Нийт дүн (мянга)	557.2	213.7	606.3	291.1
Нэг сууцанд амьдарч буй өрхийн тоо			1.09	1.36

Эх сурвалж: 2020 Монгол Улсын Хүн ам, орон сууцны тооллого, YCX

Боловсрол

Боловсролын салбарын дийлэнх хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байна. Сургуулийн өмнөх боловсролын салбарт ажиллагчдын 96.8 хувь, ерөнхий боловсролын сургуулийн багш нарын нарын 81.5 хувь нь эмэгтэйчүүд байна.³³ (Хүснэгт 4)

Хүснэгт 4. Бүх шатны боловсролын байгууллагын багш

Сургалтын байгууллагын ангилал	Нийт	Үүнээс эмэгтэй	Эмэгтэйчүүдийн эзлэх хувь
Нийт	49,871	40,000	80.2%
Цэцэрлэг	8,068	7,809	96.8%
Ерөнхий боловсролын сургууль	32,085	26,149	81.5%
Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага	2,388	1,551	64.9%
Их, дээд сургууль, коллеж	7,330	4,491	61.3%

Эх сурвалж: 1212.mn, YCX, 2020 оны байдлаар

Засгийн газраас боловсролын бүх түвшний танхимын сургалтын үйл ажиллагааг зогсоож, цахим болон теле хичээл оруулахаар шийдвэрлэсэн. Боловсролын үйлчилгээнд гарсан энэхүү өөрчлөлт багш нарын ажлын ачааллыг нэмэгдүүлсэн төдийгүй сэтгэл санааны түгшүүр, стресс бухимдал үүсэхэд хүргэж байна. 2020 оны 11-р сард цахим хэлбэрээр зохион байгуулсан судалгаагаар теле-


³¹ WHO. 2013. Global and regional estimates of violence against women: prevalence and health effects of intimate partner violence and non-partner sexual violence

³² Wendy C. Regoeczi. 2008. Crowding in Context: An Examination of the Differential Responses of Men and Women to High-Density Living Environments.


³³ YCX. Бүх шатны сургалтын байгууллагын үндсэн багш. https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NS0_2002_067V1

хичээл зааж эхэлсэнээс хойш эмэгтэй багш нарын 79.2 хувь, эрэгтэй багш нарын 60 хувь нь ажлын ачаалал нэмэгдсэн болохыг тус бүр хүлээн зөвшөөрсөн байна.³⁴ Оюутан, сурагчдын ар гэрийн амьдралын ялгаатай байдал, эцэг эхийн харилцан адилгүй анхаарал халамж зэрэг нь суралцагчдын онлайн болон теле хичээлийн үр дүнд шууд нөлөөлж буйг олонх багш санаа зовнин өгүүлж байлаа. Багш нар цахимаар хичээл заах, нөгөө талаар сурагчид гэрээсээ суралцах туршлага аль аль талдаа бага байгаа нь хичээлийн хоцрогдлыг бий болгох эрсдэлтэй байна.

Хатуу хөл хорио тогтоосноос хойш төрийн холбогдох байгууллагуудын зүгээс багш нарт багшлах ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн цөөн хэдэн сургалт, семинарыг зохион байгуулсан байна. Ихэнх багш нар КОВИД-19 цар тахал эхлэхээс өмнө ямар нэгэн онлайн сургалтанд хамрагдаж байгаагүй, мөн цахим сургалт зохион байгуулж байгаагүй байна. Онлайн сургалтын туршлага бага байгаа нь багш нарт сэтгэл санааны давхар дарамт үүсгэж байна. Утсаар хийсэн ганцаарчилсан ярилцлагын үеэр эмэгтэй багш нар хичээл заах энэхүү шинэ арга барилдаа ихээхэн санаа зовж байгаагаа илэрхийлж байлаа. Ялангуяа ахимаг насны багш нарын хувьд энэ нь ихээхэн бэрхшээлтэй байгаа тухай дурдаж байсан. (Зураг 2)


 Сургууль хаагдсан энэ өдрүүдэд ажлын ачаалал огцом нэмэгдсэн. Би бага ангийн багш учир ангийнхаа 48 хүүхэд нэг бүртэй онлайн байдлаар тулж ажиллах шаардлага гарч байгаа. Өдөр бүр тэдний хийсэн хичээл, даалгаврыг хүлээн авч шалгадаг. Ер нь бага ангийн багш нарын дийлэнх нь эмэгтэйчүүд байдаг, эрэгтэй багш нар голдуу биеийн тамир, дүрслэх урлагийн хичээл заадаг. Тэд нараас бага ангийн бид чинь илүү их ачаалалтай болчихоод байгаа юм.

Эмэгтэй багш, Улаанбаатар

 Өнгөрсөн жил манай хүү 3-р ангид байсан. Түүний теле-хичээлийг хийлгэнэ гэдэг том асуудал, бөөн стресс. Манай нөхөр хүүгийн хичээлд ер санаа зовсон шинжгүй, хичээлд нь тусална гэж байхгүй, энэ нь бас надад давхар уурлах шалтаг болдог.

Залуу эмэгтэй, Хэнтий


Гэрээсээ ажиллах нөхцлийг бүрдүүлэх үүднээс багш нар нэмэлт техник, тоног төхөөрөмж худалдан авч, технологийн ур чадвараа хөгжүүлэх шаардлагатай болсон. Цахим хичээлтэй холбоотой бүх зардал гар утасны төлбөр, интернэтийн хураамж зэргийг багш нар хувиасаа төлж байна. Харамсалтай нь, технологийн энэхүү шинэ шаардлагуудыг төрийн өмчит сургуулиуд анхааралдаа аваагүй байна. Жишээ нь, төрөөс улсын сургуулийн багш нарт 5 гаруй жилийн өмнө хангалтаар өгсөн зөөврийн компьютерууд ашиглалтын шаардлага хангахгүй болсон байна. Гэрээсээ ажиллах болсонтой холбогдуулан дээрх асуудал багш нарт, ялангуяа салбарын дийлэнх болсон эмэгтэй багш нарын өрхийн амьжиргаа, орлогод сөргөөр нөлөөлж байна.

 Би англи хэлний багш, төгсөх 12-р ангийн сурагчидтай ойр нягт ажиллах шаардлагатай байдаг. Сургууль хаагдахад тэд онлайн-аар хичээллэх болж, миний тусламж ч бас их хэрэгтэй болсон. Тэр ч утгаараа миний интернэт дата төлбөр их өндөр гарах болсон. Энэ бүх зардал миний халааснаас л гарна. Багш нарын цалин бага, гэтэл би гэр бүл, цалин хөлсөө зарцуулах ёстой шүү дээ.

Эмэгтэй багш, Улаанбаатар


³⁴ Ч.Бат-Уянга. Багшлах, суралцах үйлд Ковид-19 ийн үзүүлсэн нөлөө бичил судалгааны илтгэл. 2020. Боловсролын цахим форум 2020 оны 12 сарын 9-10

Зураг 2. Багш нарын онлайн хичээлд бэлтгэгдсэн байдал



Багш нарын ажлын ачаалал ба авч буй цалингийн хамаарлын талаар үнэлгээ хийх зайлшгүй шаардлагатай байна. Утсаар авсан гүнзгийрүүлсэн ярилцлагын үеэр анги даасан багш нарын ажлын ачаалал огцом нэмэгдсэн хэдий ч цалингийн хэмжээ харьцангуй буурсан тухайгаа илэрхийлж байлаа. Эмэгтэйчүүд давамгайлсан энэ салбарт нэгэнт бага цалин авдаг байсан багш нарын цалин хөл хорионы үед дахин багассан нь тэдний нөхцөл байдлыг улам хүндрүүлж байна (Зураг 3).

Зураг 3. Багш нарын цалингийн өөрчлөлт



Эх сурвалж: Багшлах, суралцах үйлд КОВИД-19 цар тахлын үзүүлэх нөлөө, онлайн бичил судалгаа, 2020

Дээрх судалгаанаас харахад сургууль дээр ажиллах цаг багассан тул илүү цаг болон бусад нэмэгдэл олгохгүй байгаатай холбоотойгоор багш нарын сарын цалин буурсан байна.³⁵

Би бага насны хүүхэдтэй болохоор гэрээс ажиллахад их хүндрэлтэй байна. Онлайн хичээл хийж байх үед манай хүүхэд чимээ гаргах, уйлах зэргээр анхаарал сарниулж сургалтын чанарт нөлөөлж байна. Нялх, бага насны хүүхэдтэй над шиг багш нар гэрээсээ ажиллах нь хүүхэддээ зарцуулах цагийг нэмэгдүүлж байна даа.

Анги удирдсан эмэгтэй багш, Улаанбаатар

Хөл хорионы үеэр ерөнхий боловсролын 640,449 сурагч, тэдний 50 хувь нь эмэгтэй сурагч телевиз болон онлайнгаар хичээлээ үзэж эхэлсэн. Дээд боловсролын хувьд зөвхөн онлайн хичээл хийх

³⁵ Ч.Бат-Уянга. Багшлах, суралцах үйлд Ковид-19 ийн үзүүлсэн нөлөө бичил судалгааны илтгэл. 2020. Боловсролын цахим форум 2020 оны 12 сарын 9-10

шаардлагатай болсон нь оюутнуудаас заавал интернэттэй байхыг шаардах болсон. Интернэтийн хурд тэдний гэр бүлийн орлого, амьдарч буй газар зэргээс шууд хамааралтай байна. Монгол Улсын хэмжээнд нийт 148.4 мянган оюутан суралцдагаас 61 хувь эмэгтэй байна. Эдгээр оюутнууд, ялангуяа амьдралын баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн оюутан, сурагчид боловсролын үйлчилгээнд тэгш хамрагдаж чадахгүй байх эрсдэлтэй байна.

 Гэнэт дотуур байрандаа хорионд орчихсон. Хоол хүнс ч үгүй, интернэт нь удаан, нилээд санаа зовж байсан шүү.

Эмэгтэй оюутан, Завхан

Интернэтэд холбогдох боломж багатай хөдөө алслагдсан газар, гэр хороололд амьдардаг хүүхдүүдийн хувьд дижитал хэрэглээний ялгаатай байдал нь тэдний эмзэг байдлыг улам бүр нэмэгдүүлж байна. Энэ талаар Монгол Улсад хийсэн судалгаа хангалттай байгаагүй боловч утсаар хийсэн гүнзгийрүүлсэн ярилцлагын үеэр оролцогчид интернэтэд холбогдох боломж хөдөө орон нутагт хүндрэлтэй байдаг талаар дурдаж байлаа.

 Манай ангид хөдөө амьдардаг, интернэт орох боломжгүй 3 хүүхэд бий. Онлайнар шалгалт авна, хичээл заана, яг тэр 3 хүүхэд л орж чаддаггүй. Тэр хүүхдүүдтэй утсаар л ярьдаг юм.

Багш эмэгтэй, Хэнтий

 Хүүхдүүдээ онлайн хичээлээ хийхэд аль чадахаараа л тусалдаг юм. Гэхдээ их хэцүү, бас их дарамттай байна. Учир нь манайд телевизийн нөхөж үзэх үйлчилгээ байдаггүй, хүүхдүүд компьютер авмаар байдаг ч надад тийм мөнгө байхгүй.

Өрх толгойлсон эмэгтэй, Дундговь


Хүүхэд залуучуудын эмзэг байдлыг нэмэгдүүлж буй бас нэг хүчин зүйл бол хөл хорионы үед тэд гэртээ олуулаа бөөнөөр байгаа явдал юм. Хөл хорионы улмаас нэг гэрт амьдарч буй хүүхдүүд бүгд нэг зэрэг теле болон цахим хичээл хийж байгаа нь олон ам бүлтэй өрхийн хүүхдүүдийн хувьд хүндрэлтэй байна. Нилээн хэдэн судалгаагаар нэг өрхөд олон хүн бөөгнөрөн амьдрах нь тухайн өрхийн хүүхдийн нийгмийн байр суурь, сурч боловсроход сөргөөр нөлөөлдөг болохыг баталсан байна.³⁶

Монгол дахь Хүүхдийг ивээх сангийн цар тахлын үр нөлөөний үнэлгээгээний дүнгээс харахад хүүхдийн гэрийн ажилд зарцуулах цаг мэдэгдэхүйц өссөн боловч, охид хөвгүүдийн хувьд ялгаатай байна. Ялангуяа КОВИД-19 цар тахал охидын боловсролд сөргөөр нөлөөлж байна. Тэд хичээл хийхээс илүүтэй орон гэрийн ажил, дүү нараа асрахад хөвгүүдээс илүү цаг зарцуулж байна. Дээрх байдлын улмаас охид боловсролын үйлчилгээнд хамрагдахад сөргөөр нөлөөлөх талтай юм.

(Зураг 4)

³⁶ Leonard M Lopoo and Andrew S London. Syracuse University. 2016. Household Crowding During Childhood and Long-Term Education Outcomes

Зураг 4. Цар тахлын үед ажил үүрэг нь нэмэгдсэн гэж хариулсан хүүхдүүдийн эзлэх хувь



Эх сурвалж: Коронавируст цар тахлын үр нөлөөний үнэлгээ, Хүүхдийг ивээх сан, 2020

Хөл хорионы үеэр нөхөр бид 2 ажилтай байсан, манай 9 настай охин л гэртээ 4 настай дүүгээ хараад үлддэг. Эрүүл мэндийн ажилтан эмэгтэй, Дундговь

2019-2020 оны хичээлийн жилд хөдөөгийн малчин өрхийн 119,080 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд хамрагдсанаас сургуулийн дотуур байранд амьдарч байсан 35,757 хүүхдийн 18,608 нь эмэгтэй сурагчид байна. Сургуулиуд цахим хэлбэрт шилжсэнтэй холбоотойгоор хөдөө орон нутагт амьдарч буй охид хичээл болон амьдралын шинэ хэв маягт дасан зохицох шаардлагатай болсон. Тэдний дүү нараа асрах гэх мэт гэр орны ажилд зарцуулах цаг нь нэмэгдсэнээр өөртөө болон хичээлдээ анхаарах цаг нь мөн адил багассан байна. Хөдөө алслагдмал газар нутагт амьдардаг охидын хувьд дээрх байдал нь тэднийг сэтгэл санааны хямрал, стресс бухимдалд өртөх магадлалыг нэмэгдүүлж байна.

Манай охин 10-р ангид сурдаг. Танхимын сургалт хаагдсанаас хойш онлайн аргаар хичээлээ хийхийн зэрэгцээ гэрийн ажилд тусалдаг. Хөл хорионы үед охин маань даалгавраа хийхээс илүүтэй дүүгийнхээ хичээлийг хийлгэдэг болсон. Сумын төвөөс хол амьдардаг болохоор найзуудтайгаа ч Facebook-ээр харьцаж чадахгүй болсон уу, дуугаа хураагаад байхаар нь санаа зовоод л байна. Манай хүү бол, 8-р анги, эгчээсээ шал өөр. Хөдөө байгаа ч гэсэн хүн амьтан, найз нөхөдтэйгээ уулзаад гарч ороод л явдаг.

Малчин эмэгтэй, Завхан

Нийгмийн халамж, хамгаалал

Амьжиргааг дэмжих багц арга хэмжээ

Засгийн газраас КОВИД-19 цар тахлын сөрөг нөлөөг бууруулах үүднээс өрхийн амьжиргаа, эдийн засгийг дэмжих багц арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. 2020 оны 4-р сараас 9-р сарыг дуустал хагас жилийн хугацаанд 2 багц арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бөгөөд эхний багцыг 2020 оны 3-р сард, хоёр дахь багцыг 5-р сард танилцуулсан.

Зураг 5. LEWIE загварыг ашигласан үнэлгээний жишээ



Засгийн газраас цар тахлын үед эдийн засаг, иргэдийн амьжиргаанд дэмжлэг үзүүлэх эхний 2 багц арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулж 793 тэрбум төгрөгийг зарцуулах тооцоо гаргасан.

НҮБ-ын Хүнсхөдөө аж ахуйн байгууллагаас хөгжиж буй 7 оронд 2008-2014 онд хэрэгжүүлсэн хүүхэд, гэр бүлд олгодог тэтгэмж нь эдийн засагт нь хэрхэн нөлөөлж байгааг үнэлсэн байна. Энэхүү судалгааг хийхдээ орон нутгийн эдийн засагт нөлөөллийг тооцох LEWIE аргачлалыг ашигласан бөгөөд дараах үр дүнг илрүүлсэн байна:

- Засгийн газраас иргэдэд тараасан 1 доллар бүр нь эдийн засагт 1.5-2.5 долларын орлого болж эргэн орж ирдэг.
- Үр шимийг хүртэгч өрхөд тараасан 1 доллар бүр нь үр шимийг хүртээгүй өөр өрхөд 1.03 долларын орлого болж нөлөөлдөг.

Хэрэв Засгийн газраас 793 тэрбум төгрөгийг иргэдэд тараасан гэж үзвэл, энэ нь ДНБ-ийг 1,189.5-1,982.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Эх сурвалж: Эдийн засгийн нөлөөллийг тооцох үнэлгээний аргачлал (LEWIE): Нийгмийн халамжаар тараасан тэтгэмж хэрхэн үржигддэгийг үнэлсэн нь, Олон улсын бодлогын хэлэлцүүлэгт танилцуулсан тайлан хэлэлцүүлэг, 2014 оны 9-р сарын 10-11, Бразилиа хот, НҮБХХААБ

ҮСХ-ны статистик мэдээнд 2020 оны 5-р сараас 10-р сарын хооронд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг дунджаар 1.1 сая хүүхдэд эцэг эхээр дамжуулан хүргэсэн байна.³⁷ Гүнзгийрүүлсэн ярилцлагад оролцогчдын хэлж байгаагаар тэд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг голлон хоол хүнс, эрүүл ахуйн бараа худалдан авахад зориулсан бол багахан хэсгийг хувцас, орон сууцны хэрэглээний төлбөрт зарцуулсан байна. 2018 оны байдлаар гурав ба түүнээс дээш хүүхэдтэй өрхийн 52 хувь ядуу амьдарч байгааг Монгол Улс дахь ядуурлын дүр төрх судалгаанд дурджээ.³⁸ Үүнээс үзэхэд хүүхдийн мөнгөн тэтгэмж хамгийн ядуу өрхийн орлогыг сар бүр доод тал нь 240,000 төгрөгөөр нэмэгдүүлж чадсан байна. Хүнсний эрхийн бичиг, хүүхдийн мөнгөний нэмэгдэл нь өрхөд чухал дэмжлэг болж чадсан гэдгийг гүнзгийрүүлсэн ярилцлагын оролцогчид цохон тэмдэглэж байлаа.



Би 4 хүүхэдтэй. КОВИД-19 халдвар гарахаас өмнө хүнсний зах дээр ажилладаг, сардаа 800,000 төгрөгний орлоготой байсан. Одоогоор би ажиллахгүй, орлогогүй байгаа ч хүүхдийн мөнгөний 400,000 төгрөг дэмжлэг болж байна.

Өрх толгойлсон эмэгтэй, Завхан

Засгийн газраас ядуу өрхийн хүнсний хангамжийг тасалдуулахгүйн тулд хүнсний эрхийн бичгийн сарын мөнгөн дүнг насанд хүрэгчдэд 32,000, хүүхдэд 16,000 төгрөг болгон 2 дахин нэмэгдүүлсэн. ХНХЯ-ны тайлан мэдээнд 2020 оны 11-р сард нэн ядууд тооцогдох 44,314 (Монгол Улс дахь нийт 897,427 өрхийн 5 хувь нь нэн ядуу) өрхийн 241,962 хүнд нэмэгдсэн мөнгөн дүнгээр хүнсний эрхийн бичиг олгосныг дурджээ.³⁹ Халамж хүртэгчдийн 53 хувийг охид, эмэгтэйчүүд эзэлж байна.⁴⁰


Хүнсний эрхийн бичиг нь тодорхой мөнгөн дүнгээр, ваучер хэлбэрээр олгогддог тэтгэмж бөгөөд түүнийг дотоодын мах, сүүн бүтээгдэхүүн, гурил, цөцгийн тос, элсэн чихэр, жимс, ногоо, будаа, ургамлын тос, өндөг гэх мэт 10 нэр төрлийн бүтээгдэхүүнийг худалдан авахад хэрэглэж болно. Тухайн эрхийн бичгээр гэртэйгээ ойр байдаг гэрээт хүнсний дэлгүүрт үйчлүүлэх ёстой бөгөөд гүнзгийрүүлсэн ярилцлагад оролцогчдын хэлж байгаагаар эдгээр дэлгүүрийн хүнсний бүтээгдэхүүний үнэ бусад дэлгүүрийнхтэй ойролцоо гэдгийг хүлээн зөвшөөрсөн.

³⁷ NSO. October 2020. Persons involved in social welfare activities. https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NS0_2200_016V1

³⁸ Дэлхийн Банк, ҮСХ. Өрхийн нийгэм, эдийн засгийн 2018 оны судалгааны мэдээлэлд суурилсан Ядуурлын дүр төрх 2018 тайлан. 2020

³⁹ ХНХЯ. Монгол Улсын Засгийн газраас нэн ядуу өрхийн иргэдэд 11 сарын хүнсний эрхийн бичиг олгов. 2020 оны 11-р сарын 14 <https://www.facebook.com/mlsp.gov.mn/posts/4642405795830825>

⁴⁰ ADB. June 2020. Project administration manual 54214-001, Mongolia: Shock-Responsive Social Protection Project


 Манайх картаар (хүнсний эрхийн бичгийг картаар олгодог) хүнсээ авдаг. Тухайн картаараа хорооны халамжийн ажилтны зааж өгсөн дэлгүүрээс хүнсээ авдаг ... тухайн дэлгүүрийн үнэ нь ч бусад дэлгүүртэй ойролцоо байдаг юм.

Өрх толгойлсон эмэгтэй, Улаанбаатар

Зарим нийгмийн халамжийн тэтгэмж (нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй ганц бие ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хагас болон бүтэн өнчин хүүхэд, 3 ба түүнээс дээш хүүхэдтэй ганц бие эх, эцэгт олгох мөнгөн тэтгэмж)⁴¹-ийн хэмжээ Засгийн газраас авч хэрэгжүүлсэн багц арга хэмжээний дүнд сар бүрийн 188,000 төгрөгөөс 288,000 төгрөг болж нэмэгдсэн. Нийт 62,600 халамж хүртэгч энэ төрлийн тэтгэмжийг 2020 оны 5-р сараас 12-р сарыг дуустал хугацаанд хүлээн авч байна.

Энэхүү халамжийн тэтгэмжийн зорилтот бүлэг бол 3 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон иргэд юм. ҮСХ-ны статистик мэдээгээр өрх толгойлсон ганц бие эцэг, эхийн 80 хувь нь өрх толгойлсон эмэгтэйчүүд байна. Үүнээс 3 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт өгөх тэтгэмжийн 80 хувь нь өрх толгойлсон эхчүүдэд шууд хүрч байна гэж дүгнэх боломжтой байна. Дунджаар 6,845 өрх толгойлсон эх, эцэг сүүлийн 5 сарын турш энэхүү тэтгэмжийг хүртэж байна (Зураг 6).

Зураг 6. Гурав ба түүнээс дээш хүүхэдтэй ганц бие эх, эцгийн тэтгэмжийг хүртэгчдийн тоо



Эх сурвалж: 1212.мн, ҮСХ, 2020

Жендэрт суурилсан хүчирхийлэл


2020 оны эхний 11 сарын байдлаар нийт бүртгэгдсэн гэмт хэргийн хохирогчдын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25 хувь буурч, улмаар эмэгтэй хохирогчдын тоо 28 хувь буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Улсын хэмжээнд ГБХ-ийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 2020 оны эхний 11 сард 1,044 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.6 хувь нэмэгдсэн, ГБХ-ийн улмаас үйлдэгдсэн зөрчил 9,786 бүртгэгдэж, 2019 оны мөн үетэй харьцуулахад 18.9 хувиар өссөн байна.

Цагдаагийн шуурхай дуудлагын 102 утсанд нэг өдөрт ирдэг ГБХ-ийн дуудлагын тоо хатуу хөл хорио тогтоосон үед бусад өдрүүдийнхээс 2.4 дахин багассан байна (Зураг 7).


⁴¹ Нийгмийн халамжийн тухай хууль 2012. <https://www.legalinfo.mn/law/details/393>

Зураг 7. Цагдаагийг шуурхай дуудлагын 102, ГБХ-ийн дуудлагын тоо, өдөр бүрээр, 2020 оны 10 сарын сүүлээс 12 сарын эхэн хүртэл



ГБХ-ийн дуудлага хатуу хөл хорио тогтоосон үед огцом буурсан хэдий ч өмнөх сартай харьцуулахад ГБХ-ийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 42.7 хувь, зөрчлийн тоо 0.7 хувиар тус тус нэмэгдэж бүртгэгдсэн байна (Зураг 8). Хөл хорио эмэгтэйчүүдийг илүү удаан хугацаанд хүчирхийлэгчийн хяналтанд байлган, тусламж авах боломжийг нь хязгаарлаж байгааг НҮБХАС-ын түргэвчилсэн үнэлгээнд дурдсан байна.⁴² Цар тахлын үед авч хэрэгжүүлж буй хөл хорио, хязгаарлалтын улмаас охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нэмэгдэж, амьдарч буй гэр нь тэдний хувьд аюултай орчин болж байна.

Зураг 8. ГБХ-ийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил 2020 оны 10, 11 сар



Source: Central Police. 2020. Monthly report on domestic violence.

Засгийн газраас хатуу хөл хорио тогтоохдоо тухайн үед зайлшгүй ажиллах шаардлагатай газрууд (хүнсний үйлдвэрлэл, түгээлт, хүнсний дэлгүүр, хэвлэл мэдээлэл, банк, оршуулгын үйлчилгээ)-ыг тодорхой хязгаартайгаар үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрч олон нийтэд зарласан. Харин ЖСХ/ГБХ-ийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд хэвийн ажиллаж байсан боловч Засгийн газраас энэ үйлчилгээг нээлттэй эсэхийг олон нийтэд мэдээлээгүй нь ГБХ-ийн хохирогчид шаардлагатай тусламж авч чадахгүй байх эрсдлийг нэмэгдүүлж байна. Энэхүү нөхцөл байдлаас харахад иргэдийн ГБХ-ийн ойлголт сул байна. Тухайлбал гүнзгийрүүлсэн ярилцлагад оролцогчдын олонх нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах зориулалттай, улсын хэмжээнд үйл


⁴² НҮБХАС Монгол. КОВИД-19 цар тахлын ЖСХ/ГБХ, түүний хохирогчид үзүүлэх үйлчилгээнд үзүүлэх нөлөөлөл, түргэвчилсэн үнэлгээний тайлан, 2020 оны 5 сар

ажиллагаа явуулж байгаа 15 нэг цэгийн үйлчилгээний төв (НЦҮТ) болон 14 түр хамгаалах байрны талаар огт мэдэхгүй байсан.⁴³

 Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид туслах нэг цэгийн үйлчилгээний төв, хамгаалах байр байдаг гэж би ер сонсоогүй юм байна. Харин гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдээллийг олон нийтийн сүлжээнээс сонссон.

Өрх толгойлсон эмэгтэй, Завхан

ОУХБ, НҮБХС-ын хамтарсан мэдэгдэлд дурдсанаар КОВИД-19 цар тахлын хямралаас үүдэн сая сая хүүхэд хөдөлмөр эрхлэхэд хүрч байна.⁴⁴ Дэлхийн Зөн Монгол Олон улсын байгууллагын хийсэн эдийн засгийн сэргэлтийн судалгаанд оролцсон 658 иргэдийн 63.3 хувь нь төрөөс тодорхой тусламж дэмжлэгийг үзүүлж байгаа хэдий ч ирэх 4-6 сарын амьжиргаандаа санаа зовж байна гэдгээ илэрхийлсэн. Судалгаанд оролцогчид орлого багассан нөхцөл байдлаа даван туулахын тулд эм, эмчилгээний зардлаа бууруулна (39 хувь), түр ажил олж хийнэ (19 хувь), хүнсний хэрэглээгээ багасгана (11 хувь) мөнгө зээлнэ (5.4 хувь) гэж хариулсан байна. Мөн тэдний зарим шийдвэр нь хүүхдэд халтай шийдвэрүүд байсан бөгөөд тухайлбал, хүүхдээрээ ажил хийлгэх (10 хувь), хүүхдээ хамаатан, садан төрлийн айлд аваачих (8 хувь), гуйлга гуйлгах (1 хувь) гэж хариулжээ.⁴⁵

 Манай ажил зогсчихсон. Хүүхдээ хэрхэн тэжээхээ мэдэхгүй л байна. Асуудал хэрэв энэ чигээрээ хүндэрвэл хоёр хүүхдээ хөдөө байдаг ахынх руугаа явуулдаг ч юм билүү гэж бодож байгаа. Хүүхдүүд тэнд гэр бүлийнхэнд нь туслаад хонь мал харж өгөөд, алзахгүй. Тэгээд сургууль нээгдэхээр эргээд ирчихнэ.

Шилжин суурьшсан эмэгтэй, Улаанбаатар

3.2 Хөдөлмөр эрхлэлт ба орлого

Бичил, жижиг, дунд үйлдвэрлэл (ЖДҮ)

Монгол улсад ЖДҮ нь ДНБ-ий 17.8 хувийг эзэлдэг бөгөөд нийт ажиллах хүчний 72 хувийг бүрдүүлдэг. Мөн ЖДҮ дэх худалдаа, үйлчилгээний салбарт эмэгтэйчүүд давамгайлж байна.⁴⁷ 2020 оны эхний 11 сарын байдлаар, нийт идэвхтэй бизнес эрхлэгчдийн 67 хувь (65,692) нь улсын ДНБ-ний 66.2 хувийг үйлдвэрлэдэг Улаанбаатарт үйл ажиллагаагаа явуулж байна.⁴⁸ Эдгээр статистик мэдээнээс харахад ЖДҮ нь хөдөлмөрийн зах зээл, үйлдвэрлэл, эдийн засгийн өсөлтөд голлох үүрэг гүйцэтгэдэг байна. Монгол улсад Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК)-ийн 2014 онд хийсэн судалгаанаас⁴⁹ өөр эмэгтэй-өмчлөгчтэй ЖДҮ-ийн талаарх тодорхой тоон мэдээлэл байхгүй байна. Тус судалгаанд Монгол Улс дахь нийт ЖДҮ-ийн ихэнх буюу 60 хувийг эмэгтэй-өмчлөгчтэй ЖДҮ бүрдүүлж байна. Монгол улсад худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэлийн салбарын ЖДҮ-г тодорхойлохдоо тухайн үйл ажиллагааг явуулж байгаа ажиллах хүчний тоо болон жилийн борлуулалтын орлого нь 2.5 тэрбум төгрөгнөөс доош байх зэрэгт үндэслэн тогтоодог.⁵⁰ Үүнд ганц өмчлөгчтэй, нөхөрлөл хоршоо, өрхийн бизнес зэрэг хуулийн хэлбэрээс үл харгалзан бүх төрлийн бизнес эрхлэгчид хамаарна. Гэвч эмэгтэй-өмчлөгчтэй ЖДҮ-г хуульчилсан тодорхойлолт байхгүй тул АХБ-ны тодорхойлолтыг

⁴³ ADB. 7 July 2020. ADB to help address and prevent domestic violence in Mongolia amid COVID-19.

⁴⁴ ILO, UNICEF. 2020. COVID-19 and child labour: A time of crisis, a time to act

⁴⁵ UNICEF. Aug 2020. Mongolia Novel Coronavirus (COVID-19) Situation Report No.4

⁴⁶ ADB. COVID-19 impact and recovery options for micro, small, and medium-sized enterprises (MSMEs) and the informal sector in Mongolia, 2020


⁴⁷ UN. April 2020. Policy brief: The impact of COVID-19 on women

⁴⁸ YCX. Дотоодын нийт бүтээгдэхүүн. https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NS0_0500_007V1

⁴⁹ IFC. 2014. MSMEs and Women-owned MSMEs in Mongolia. Washington, D.C.

⁵⁰ Жижиг дунд үйлдвэрийн тухай хууль, 2019. <https://www.legalinfo.mn/law/details/14525>


голдуу ашигладаг байна.⁵¹ Эмэгтэй-өмчлөгчтэй бизнесийг дэмжихийн тулд энэ төрлийн статистик мэдээллийг цуглуулж нэгтгэдэг байх шаардлагатай бөгөөд үүний тулд эмэгтэй-өмчлөгчтэй ЖДҮ-г хуульчлан тодорхойлох зайлшгүй шаардлагатай. Эмэгтэй өмчлөгчтэй ЖДҮ-д ээлтэй хууль, дүрэм журмыг бий болгосноор эмэгтэйчүүдийг бизнес эрхлэх боломжийг нь нэмэгдүүлэх, тэдэнд санхүүгийн тусламж үзүүлэхэд дэмжлэг болж чадна.

 Манай ажлын байр орон сууцны подвальд түрээсээр байрладаг. КОВИД-19 цар тахлын улмаас олон улсын нислэгүүд зогсож, бид үйлчлүүлэгчдээ (жуулчид) алдсанаар орлогогүй болсон. Одоо бид түрээсээ ч, цахилгаан дулаанаа ч төлж чадахгүй байгаа. КОВИД-19 цар тахлын үеэр бид өөр баталгаатай орлогын эх үүсвэрийн талаар бодох хэрэгтэй болж байна. Нэмж хэлэхэд, олон улсад эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан төсөл хөтөлбөрүүд зарлагддаг ч манайх тус шалгуурыг нь хангах эсэх нь ойлгомжгүй байдаг. Монгол Улсад эмэгтэй-өмчлөгчтэй ЖДҮ гэж хэн бэ гэдгийг тодорхойлдог хуулийн тодорхойлолт байдаггүй юм билээ.

Дундын хоршооны тэргүүлэгч, Улаанбаатар

2020 оны эхэн үед дотоод, гадаад нийгэм эдийн засгийн байдал ихээхэн өөрчлөгдөж, улмаар 3-р улирлын байдлаар КОВИД-19 цар тахалтай тэмцэх арга хэмжээний улмаас эдийн засаг 7.3 хувиар унасан.⁵² Ажлын байраа хадгалж үлдэх, ажилтнуудын цалинг тасралтгүй олгох үүднээс ЖДҮ-д яаралтай санхүүгийн тусламж хэрэгтэй болсон нь цар тахлын улмаас мөнгөний урсгалд тодорхой саад учирч байгааг харуулж байна. МҮХАҮТ-аас хийсэн 3,530 оролцогчтой судалгаагаар цар тахлын хямралын улмаас ЖДҮ-д тулгараад буй саад бэрхшээлийг тодорхойлж харуулсан байна. Тэдэнд тулгарч буй томоохон бэрхшээлүүдэд (i) ажлын байр хадгалах буюу ажилтнуудынхаа цалинг төлөх (24 хувь), (ii) бизнесийн зээлийн эргэн төлөлт (21 хувь), (iii) хөл хориотой холбоотой төрийн ойлгомжгүй, холбоо хамааралгүй шийдвэрүүд (17 хувь), (iv) түрээсийн төлбөр (16 хувь) гэж дурдсан байна.⁵³ (Зураг 9)

Зураг 9. ЖДҮ-дэд тулгамдаж буй бэрхшээлүүд



Эх сурвалж: Хатуу хөл хорионы үеийн бизнесийн нөхцөл байдал судалгааны тайлан, МҮХАҮТ, 2020

МҮХАҮТ-ын тус судалгаанд нийт 3,530 оролцогчдын 66% нь 2020 оны 11-р сарын 12-ноос хатуу хөл хорио тогтоосноос хойш үйл ажиллагаа нь бүрэн зогссон, 22% нь хязгаарлагдмал хүрээнд ажиллаж байгаа, 10% нь гэрээс ажиллах зохицуулалтыг хийж байгаа гэжээ.⁵⁴

2020 оны 11-р сард улс даяар 6,400 хүн шинээр ажилгүй иргэдийн тоонд бүртгүүлсэнээс 55.3 хувь

⁵¹ ADB. 2014. Gender Toolkit for Micro, Small and Medium-Sized Enterprise Finance and Development. Manila (i) at least 50% of ownership is controlled by women, (ii) at least senior manager are women, or (iii) at least 50% of the registered contractual employee are women.


⁵² ҮСХ. Монгол улсын нийгэм эдийн засгийн байдал, сарын танилцуулга. УБ. 2020 оны 11 сар

⁵³ МҮХАҮТ. Хатуу хөл хорионы үеийн бизнесийн нөхцөл байдал судалгааны тайлан. УБ. 2020 оны 11 сар

⁵⁴ Мөн тэнд

нь ажлаас халагдсан байна. Ажилгүйдэл нь өмнөх сараас 16.7 хувиар нэмэгдсэн бөгөөд тэдний 53.2 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.⁵⁵ Энэхүү судалгаанд цар тахлын үед эмэгтэйчүүдийн ажилгүй болох эрсдэл эрэгтэйчүүдээс илүү их, ялангуяа ЖДҮ-д ажилладаг эмэгтэйчүүдийн хувьд энэ эрсдэл харьцангуй өндөр байна.

Цар тахал эхлэхээс өмнө ч ЖДҮ-ийн салбар дах ажилтнуудын тоо буурсаар ирсэн байна.⁵⁶ МХАҮТ-ийн нийт 4,074 байгууллагыг хамруулсан судалгаанд сүүлийн 3 жилийн турш салбарын ажилчдын тоо өссөн үзүүлэлт тун бага ихэвчлэн буурсан үзүүлэлттэй байсныг анхааруулсан. Түүнчлэн, 2018 онтой харьцуулахад жижиг бизнесийн тоо 18.5 хувиар, дунд хэмжээний бизнесийн тоо 9.7 хувиар буурсан. 2020 онд жижиг, дунд бизнест ажиллагчдын тоо 50-иас дээш хувиар буурсан болохыг тус судалгаанд онцолсон байна.

 *Манай компанийн орлого КОВИД-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас 80 хувиар буурсан. Манай ажилчдын 90 хувь нь эмэгтэй, тэдний ихэнх нь өрх толгойлсон эмэгтэйчүүд байдаг. Цалинг нь бууруулах шаардлагатай болсны улмаас зарим нь ажлаас гараад явчихсан. Уг нь 20-иод ажилчинтай байсан, одоо тал нь л үлдлээ.*

Эмэгтэй бизнес эрхлэгч, Улаанбаатар

ААН-ийн үйл ажиллагаанд үзүүлж буй Коронавирусийн нөлөөлөл II шатны судалгаагаар 1,147 (нийт судалгаанд оролцогчдын 47.8 хувь) ААН-ийн үйл ажиллагаа цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний улмаас жигд бус явагдаж байгааг тогтоосон.⁵⁷ Хүснэгт 5-д эмэгтэй ажиллагчдын эзлэх хувь болон цар тахлын улмаас бизнесийн үйл ажиллагаа нь жигд бус явагдаж байгаа ААН-үүдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбар тус бүрээр нь харуулсан. Энэхүү хүснэгтээр эмэгтэйчүүд давамгайлсан салбарт 50-иас дээш хувь ААН-үүдийн үйл ажиллагаа доголдсоныг харьцуулан харж болно.

Хүснэгт 5. Эмэгтэйчүүдийн давамгайлсан салбар болон цар тахлын улмаас үйл ажиллагаа нь жигд бус явагдаж буй салбарууд, эдийн засгийн үйл ажиллагааны салбар бүрээр

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Нийт ажиллагчдад эмэгтэйчүүдийн эзлэх хувь	Нийт ААН-д үйл ажиллагаа нь жигд бус явагдаж буй ААН-ийн эзлэх хувь
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	44.3%	39.8%
Уул уурхай, олборлолт	17.7%	48.4%
Боловсруулах үйлдвэрлэл	52.1%	54.6%
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	34.5%	33.3%
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	60.5%	22.2%
Барилга	19.0%	40.9%
Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар, үйлчилгээ	51.5%	37.2%
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	22.2%	61.2%
Байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	79.9%	53.0%
Мэдээлэл, холбоо	49.8%	44.8%

⁵⁵ УХС. Монгол улсын нийгэм эдийн засгийн байдал, сарын танилцуулга. УБ. 2020 оны 11 сар

⁵⁶ МҮХАҮТ. Монголын бизнесийн орчин 2020 судалгааны тайлан. УБ. 2020 оны 12 сар

⁵⁷ УХС. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд үзүүлж буй Коронавирусны нөлөөлөл судалгаа, 2 дахь шат. 2020 оны 9 сар


Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	66.7%	40.2%
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	74.0%	57.1%
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	41.0%	51.4%
Захиргаа болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	46.4%	37.5%
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	49.8%	21.4%
Боловсрол	72.3%	56.1%
Эрүүл мэнд ба нийгмийн хамгаалал	80.8%	30.4%
Урлаг, үзвэр, тоглоом наадам	46.4%	59.0%
Бусад үйл ажиллагаа	56.3%	60.3%

Тэмдэглэл: Энэхүү хүснэгтээр тодруулсан тоонуудаар 50 дээш хувь эмэгтэйчүүд давамгайлсан салбар болон КОВИД-19 цар тахлын улмаас тухайн ААН-үүдийн үйл ажиллагаа доголсоныг харуулсан.

Эх сурвалж: ААН-ийн үйл ажиллагаанд үзүүлж буй Коронавирусийн нөлөөлөл II шатны судалгаа, YCX, 2020

Мөн дээрх судалгаагаар КОВИД-19 цар тахлын улмаас үйл ажиллагаа нь жигд бус явагдаж байгаа нийт 1,147 ААН-ийн 86.3 хувь буюу 990 ААН-ийн орлого буурсан байна. Орлого нь буурсан ААН-үүдийн дор хаяж 63.5 хувийг эмэгтэйчүүд зонхилсон бизнесийн салбар эзэлж байгааг дараах дугуй графикаас харж болно. Үүнд хүйсээр ангилсан мэдээлэл нь олдохгүй байгаа аялал жуулчлал болон бусад салбарыг хамруулаагүй. (Зураг 10)

Зураг 10. Орлого нь буурсан ААН, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар



Эх сурвалж: ААН-ийн үйл ажиллагаанд үзүүлж буй Корона вирусийн нөлөөлөл II шатны судалгаа, YCX, 2020


Банкны зээлийн өрийн үлдэгдэлтэй ЖДҮ-үүдэд хамгийн их бэрхшээл тулгарч байна. Төрөөс зээлийн эргэн төлөлтийг тодорхой сараар хойшлуулах боломжийг бүрдүүлж өгсөн ч төлөх зээлийн хүү хэвээрээ байгаа тул зээлийн эргэн төлөлттэй холбоотой санхүүгийн дарамтаас салж чадахааргүй байна.

 *Өр төлбөр, орлогын эх үүсвэртэй холбоотой шийдвэр гаргахдаа эхлээд жижиг дунд бизнесийнхээ нөхцөл байдлыг анхааралтай сайн судалмаар байна. Тэгэхгүй бол яг тэдэнд хандсан зөв шийдвэр гаргаж чадахгүй шүү дээ.*

Эмэгтэй бизнес эрхлэгч, Дундговь

Эмэгтэйчүүд голдуу оёдлын салбарт ажилладаг. Гэтэл энэ салбарын эрэгтэй, эмэгтэй ажиллагчдын хүйсээр ангилсан нарийн тоон мэдээлэл хангалтгүй, олдсон тоо баримт нь нийт ажиллагчдын талаарх ерөнхий мэдээллийг багтаасан байна. Оёдлын салбарын мэргэжлийн нэгдсэн холбооны хүйсээр ангилаагүй тоон мэдээгээр энэ салбарт нийтдээ 15,530 хүн ажиллаж байгаа бөгөөд 1,531 ХХК, 3,230 хувиараа хөдөлмөр эрхлэгчид оёдлын бизнес эрхэлж байна.⁵⁸

Цар тахлын улмаас авч хэрэгжүүлж байгаа зорчих хөдөлгөөний хязгаарлалт нь оёдлын салбарын эрэгтэй, эмэгтэй ажилтнуудын бизнест маш сөргөөр нөлөөлж, зарим нь ямарч орлогогүй болсон байна.

 *Миний бизнес зогссон, тиймээс оёдлын машин болон бусад багаж хэрэгслээ гэртээ авчирсан. Би материал нийлүүлдэг газраасаа зээлээр баахан материал авчирсан байсан, бас түрээсийн өртэй. Гэртээ ажиллах гэхээр гэрийн ажил, хүүхэд асрах гэх мэтээр ажиллах боломж бараг байхгүй болчихоод байна.*


Хувиараа хөдөлмөр эрхлэгч эмэгтэй, Завхан

Орлого

Ажлын байрыг хадгалах үүднээс цалинг хугацаандаа олгох, ажилчдадаа зээл, хөрөнгийн дэмжлэг үзүүлэх нь өрхийн орлогыг дэмжих сайн арга болдог. Гэтэл олонх ЖДҮ-үүд үүнд бэлэн бус байсан нь гүнзгийрүүлсэн ярилцлагаас илэрхий харагдсан. Ялангуяа, нэн шаардлагатай бус үйлчилгээ гэсэн ангиллаар хөл хорионы үед үйл ажиллагаа нь хаагдсан бизнесүүдийн хувьд хөрөнгийн хангалттай эх үүсвэргүйн улмаас ажилчдынхаа цалинг олгож чадахгүйд хүрч байна.

Монгол Улсад эмэгтэйчүүд эдийн засгийн харьцангуй эмзэг байдалд байна: Эмэгтэй ажилчдын 39.1 хувь нь бага цалинтай ажил хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд энэ нь эрэгтэйчүүдээс 10.3 пунктээр их байна⁵⁹ (Зураг 11). Цар тахлын улмаас бага цалинтай эмэгтэй, эрэгтэй ажилчдын аль аль нь өөрсдийгөө болон гэр бүлээ тэжээхэд хүндрэл бэрхшээлтэй тулгарч байгаа хэдий ч бага цалинтай ажилд эмэгтэйчүүд давамгайлж буйг анхаарах хэрэгтэй. Эмэгтэйчүүд голлон ажиллаж буй орлого багатай хүүхэд асрагч, үйлчлэгч, гал тогооны туслах зэрэг ажлууд цар тахлын үед зогсонги байдалд орсноор орлогогүй, ажилгүй болох магадлал өндөр байна. Тэдэнд хадгаламжийн хуримтлал үүсгэх боломж байхгүй тул эдийн засгийн хямралыг даван туулахад хэцүү төдийгүй хэрвээ ганцаараа ар гэрээ авч явдаг бол нөхцөл байдал нь илүү хүндрэхээр байна.

Зураг 11. Бага цалинтай ажилчдын хувь



Эх сурвалж: 1212.mn, YCX, 2019 оны байдлаар

⁵⁸ Оёдлын Салбарын Мэргэжлийн Нэгдсэн Холбоо ТББ. <https://www.facebook.com/oyodol.mn/posts/1814209592061302>

⁵⁹ YCX. EARN-2 Бага цалинтай ажиллагчдын хувь. https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NS0_0400_057V1

БНХАУ-тай хиллэдэг хилийн боомтод зорчих хөдөлгөөний хязгаарлалт тогтоосноор түүхий эдийн үнэ, ялангуяа ноос, ноолуур, арьс ширний ханш буурсан. 2020 оны 3-р улирлын байдлаар экспорт 14.4 хувь буурсан байна. Үүнд түүхий болон боловсруулсан арьс шир, ангийн үсээр хийсэн бүтээгдэхүүний экспорт 44.4 хувиар, мал, амьтан, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүний экспорт 39.8 хувиар тус тус буурсан нь нөлөөлжээ.⁶⁰ Энэхүү үнийн уналтаас болж малчин өрхийн орлого ихээхэн өөрчлөгдсөн. 2018 онд хийсэн малчдын аж байдлын судалгаагаар малчин өрхийн сарын орлого нь 959.0 мянган төгрөг буюу жилийн орлого нь 11.5 сая төгрөг байжээ. 2018 онд ноолуурын дундаж ханш кг тутамд 99,550 төгрөг, малчид ноолуураас жилд 4,431 мянган төгрөгийн орлого олдог бөгөөд өөрөөр хэлбэл малчдын орлогын 40 хувийг ноолуур эзэлдэг байна.⁶¹ Гэтэл энэ жил ноолуурын үнэ кг тутамд 50,000 төгрөг⁶² болтол унасантай харьцуулбал малчдын орлого 20 хувиар буурсан байх магадлалтайг харуулж байна. ҮСХ-ны статистик мэдээлэлд үндэслэн, хөдөөгийн өрхийн орлогын бүтцийг өнгөрсөн оныхтой харьцуулбал мал аж ахуйн үйлдвэрлэлийн орлого нь 9 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 12. Хөдөөгийн өрхийн орлогын бүтэц (2019 дотор талд, 2020 гадна талд)



Тэмдэглэл: 2019 оныг дотор талын тойрог, 2020 оныг гадна талын тойргоор харуулав.
 Эх сурвалж: 1212.mn, ҮСХ, 2020 оны 3-р улирлын байдлаар

Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлд албан бус хөдөлмөр эрхлэгчид томоохон байр суурийг эзэлдэг. Хөдөө аж ахуйн бус салбарт ажиллагсадын гурван хүн тутмын нэг буюу 31,5 хувь нь албан бус хөдөлмөр эрхлэгчид байна. Мөн тэдгээрийн 36.2 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт ажилладаг бөгөөд КОВИД-19 цар тахлын хямралд хамгийн их өртөөд байна. Албан бус хөдөлмөр эрхлэгч эмэгтэйчүүдийн 62.6 хувь худалдаа, үйлчилгээний салбарт ажилладаг бөгөөд, тэдний олонх нь түрээсийн төлбөр, банкны зээлээ эргэн төлөхөд хүндрэл учирсан байна.⁶⁴ Гүнзгийрүүлсэн ярилцлагын үед албан бус хөдөлмөр эрхлэгч эмэгтэйчүүд хүүхдийнхээ боловсролын нэмэлт хэрэгцээ, зээлийн эргэн төлөлтийн талаар санаа зовж байгаагаа илэрхийлж байв.

⁶⁰ ҮСХ. Монгол улсын ДНБ. 2020 оны 3-р улирлын тайлан

⁶¹ ХНХЯ. Малчдын аж байдлын судалгаа. УБ. 2018

⁶² ҮСХ. Аймгийн төвүүдэд зарагдаж байгаа хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн. 2020 оны 3-р улирал. http://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_0600_001V6

⁶³ ҮСХ. Нэг өрхийн сарын дундаж орлого. 2020 оны 3-р улирал. https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_1900_018V1

⁶⁴ ҮСХ. Ажиллах хүчний судалгаа. УБ. 2019

Цар тахлын улмаас миний орлого илт багассан. Хөл хорионы үед бүр дэлгүүр маань хаагдсан, дээрээс нь гайгүй орлого олдог үе болох баяр наадам, тэмдэглэлт өдрүүдийг хориглочихсон. Орлого олсон олоогүйгээс шалтгаалахгүйгээр банкны өр, түрээсийн төлбөр тогтмол хэмжээгээрээ л нэхэгдээд байдаг.


Бэлэн хувцасны худалдаа эрхлэгч эмэгтэй, Улаанбаатар

Хөл хорионоос болоод орлого багассан. Би жижиг фото студи эрхэлдэг байсан боловч хөл хорионы үед үйлчилгээг минь зогсоочихсон.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч эмэгтэй, Завхан

Монгол ахуй соёлд гэр бүл, төрөл садангийн тусламж дэмжлэг хүнд хэцүү үед чухал үүрэг гүйцэтгэдэг. Цар тахлын үед өрхийн орлогын бүтэц дэх 'Бусдаас үнэгүй авсан' орлогын эзлэх хувь мэдэгдэхүйц буурч, 2020 оны 2 болон 3-р улирлын байдлаар нийт өрхийн орлогын 3.3 хувь хүртэл буурсан үзүүлэлттэй байна.⁶⁵ Гэр бүл, төрөл садангийн тусламж нь хүмүүсийн сэтгэл санаа, аж байдалд эерэг нөлөө үзүүлдэг бөгөөд ялангуяа бусдаас хамааралтай өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн болон орлого багатай өрхөд сэтгэл санааны дэмжлэг болсоор ирсэн. Гэсэн хэдий ч, дэлхий даяар олон хүн КОВИД-19 цар тахалд өртөж байгаа тул төрөл садангийн зүгээс орлого багатай өрхөд өмнөх шигээ тусламж дэмжлэг үзүүлэх байдал улам хумигдаж байна.

Зураг 13. Өрхийн орлогын бүтэцэд бусдаас үнэгүй авсан орлогын эзлэх хувь



Манай хүү цар тахлаас өмнө байнга мөнгө явуулдаг байсан, гэхдээ энэ жил ганц хоёр удаа л явуулсан. Түүний тусламж бидэнд их чухал байдаг. [Өмнөд] Солонгост байдал бүр л хэцүү байгаа юм шиг байна лээ, тиймээс одоо хүүдээ л их санаа зовох юм.


Ахмад настан эмэгтэй, Улаанбаатар

Гэрийн хөлсгүй хөдөлмөр

КОВИД-19 цар тахлын хөл хорионы улмаас гэрийн хөлсгүй хөдөлмөрийн эрэлт ихэссэн бөгөөд энэ нь өрхийн хэмжээнээс үл шалтгаалан гэрийн асаргаа буюу хүүхэд асрах, харж хандах ачаалал өсч, гэр бүлд сэтгэл зүйн стресс дарамтыг нэмэгдүүлэх болсон. YCX-оос 2019 онд хийсэн цаг ашиглалтын судалгаанд дунджаар эмэгтэйчүүд өдөрт гэрийн ажилд (273 минут буюу 2.6 дахин их цаг) эрэгтэйчүүдээс илүү их цаг зарцуулж байгааг харуулсан байна.⁶⁶ Эмэгтэйчүүдийн цаг их зардаг гэрийн ажлыг үнэлж тооцдоггүй бөгөөд үүнд зарцуулсан цаг хугацаа нь тэдний нийгмийн болон хөдөлмөрийн харилцаанд оролцох боломжийг нь төдий хэмжээгээр хязгаарладаг болох нь гүнзгийрүүлсэн ярилцлагын үед ажиглагдаж байв.

⁶⁵ YCX. Нэг өрхийн сарын дундаж орлогын бүтэц. 2020 оны 3-р улирал. https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NS0_1900_020V1

⁶⁶ YCX. Цаг ашиглалтын судалгаа. УБ. 2019


 Би 3 ачаа хардаг. Гэр хороололд амьдардаг, кабелийн ТВ байхгүй учир заримдаа манай ач нар хичээлээ үзэж амждаггүй. Сургууль хичээллэж эхлэхэд манай ач нар сургуульдаа явж надад өөртөө зарцуулах цаг зав гардаг байсан. Одоо би өдөрт дор хаяж 4 цагийг теле хичээл үзэхэд зориулж байна.

Ахмад настан эмэгтэй, Улаанбаатар

 Би 4 хүүхэдтэй, энэ хөл хорионы өдрүүдэд тэдний хичээлийг зохицуулж хийлгэнэ гэдэг хүнд даваа байна. Хүүхдүүдийнхээ хичээлийг нь хийлгэнэ, гэрийнхээ ажлыг хийнэ гэхээр өөрийнхөө ажлыг хугацаанд нь хийх боломжгүй болж байна.

Өрх толгойлсон эмэгтэй, Завхан

УОК-ын тогтоолоор 0-12 насны хүүхэдтэй эмэгтэйчүүдийг хөл хорионы үед гэрээсээ ажиллах эсвэл цалинтай чөлөө олгох тухай шийдвэр гарсан.⁶⁷ Ийнхүү хэсэгчилсэн хөл хорионы үед эмэгтэйчүүд хүүхдээ харж асрах, өрх гэрийнхээ ажлыг амжуулахын хажуугаар гэртээ ажлаа хийх боломжтой болсон хэдий ч хүүхдээ харж асрахын зэрэгцээ орон гэрийн ажлаа амжуулах, өөрийн албан ажлаа давхар хийх болсноор ачаалал нэмэгдсэн байна. Түүнээс гадна, дийлэнх эмэгтэйчүүдийн ажлын цаг нь богиноссон боловч боломжит орлого нь буурсан байна.

 Би гэрээсээ ажиллаж байгаа, үүнтэй холбоотойгоор миний цалин багассан. Манай захирал намайг онлайнгаар гэрээсээ ажиллахыг зөвшөөрсөн боловч долоо хоногийн гурван өдөрт нь ажиллана гээд цалинг маань 20 хувь бууруулсан.

Залуу эмэгтэй, Улаанбаатар

Эцэг эх нь ажилтай үед бага насны хүүхдүүдийг ихэвчлэн эмээ нар харж ханддаг. Энэ асуудал нь КОВИД-19 цар тахлын хөл хорионы дэглэмийн үед бүр ихэссэн байна.

 Хүүгийнхээ гэр бүлд нь нэмэр болох гээд ой найман сартай, 4 настай 2 хүүхдийг нь би гэртээ хардаг юм. КОВИД-19 хөл хорио эхэлснээс хойш эцэг эх нь хүүхдүүдтэйгээ ч уулзалдаж чадахгүй байна.

Ахмад настан эмэгтэй, Завхан

Гэр бүлдээ зарцуулах хөлсгүй хөдөлмөр нь хувь хүн, гэр бүл, нийгмийн сайн сайханд тодорхой үүрэг гүйцэтгэж ирсэн. Гэсэн хэдий ч хүүхэд асрах, гэрийн ажилд зарцуулах цаг тэгш бус байгаа нь жендэрийн үүргийн талаарх уламжлалт үзэл хандлага, жендэрийн хэвшмэл ойлголттой холбоотой байна. Гэр бүлийн ажил, хүүхэд асрахтай холбоотой хөлсгүй хөдөлмөрийг эмэгтэйчүүдийн хийх ёстой ажил мэтээр ойлгож ирсэн жендэрийн үүргийн талаарх хэвшмэл ойлголт нь гүнзгийрүүлсэн ярилцлагын үед түгээмэл хэвээр байгаа ажиглагдсан. Хөлсгүй хөдөлмөр нь эмэгтэйчүүдийг хүчирхэгжүүлэх, жендэрийн болон хөдөлмөрийн харилцааны тэгш бус байдлыг арилгах ТХЗ, төрийн бодлогын үр дүнтэй хэрэгжилтэд сөргөөр нөлөөлдөг. Иймээс олон нийт, орон нутгийн хамтын ажиллагаанд тулгуурлан хөлсгүй хөдөлмөрийн тэгш хуваарилалтыг дэмжих, гэр бүлд ээлтэй бодлогыг төрөөс хариуцан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

3.3 Засгийн газрын хариу арга хэмжээ

Засгийн газраас авч хэрэгжүүлж буй КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь эмэгтэйчүүдийн нийгэм-эдийн засгийн нөхцөл байдалд сөргөөр нөлөөлж байна. Энэхүү хэсэгт судалгааны харилцан хамаарал бүхий салбаруудтуй уялдуулан Засгийн газраас авч хэрэгжүүлсэн

⁶⁷ УОК-ын тогтоол №06, 2020 оны 3 сарын 10. SEC Resolution No6. 10 Mar 2020, жирэмсэн болон 0-12 насны хүүхэдтэй эмэгтэй ажилтан, албан хаагчийг гэрээсээ ажиллах нөхцөл боломжоор хангах, цалинтай чөлөө олгох тухай 3 дахь заалт

хөл хорионы арга хэмжээг нэгтгэн дүгнэсэн. (Хавсралт 2-оос Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоймыг харна уу)

Дэлхий дахинд цар тахал тархсан эхэн үед Монгол Улсын Засгийн газар цар тахлаас урьдчилан сэргийлэх үүднээс хүн хоорондын зай барих, амны хаалт хэрэглэх, хил хаах, олон улсын нислэгийг зогсоох зэргээр яаралтай арга хэмжээ авч, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг тогтоосон. Энэ хугацаанд гадаадаас эх орондоо буцаж ирсэн иргэдийн дунд КОВИД-19 халдварын тохиолдол илэрсээр байв. Дотоодод халдварлагдсан анхны тохиолдлууд 2020 оны 11 сараас бүртгэгдэж, Засгийн газар Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэргийг 2020 оны 11-р сарын 12-ны өдрөөс эхлэн хатуу хөл хорионы дэглэмд шилжүүлсэн.

Зорчих хөдөлгөөний хязгаарлалт, хөл хорио



Засгийн газраас хамгийн анх 2020 оны 2-р сарын 12-ны өдөр өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай тогтоолыг баталж хэрэгжүүлсэнээс хойш тус тогтоолыг 2020 оны 3-р сарын 2-ны өдрөөс хойших хугацаанд нийт 10 удаа,⁶⁸ харин дотоодод халдварлагдсан анхны тохиолдол батлагдахад 2020 оны 11-р сарын 11-ний өдрөөс 2020 оны 11 сарын 17-ны өдрийн хооронд зарласан бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх арга хэмжээг түүнээс хойш нийт 4 удаа сунгасан байна.⁶⁹ Одоогийн байдлаар хамгийн сүүлд хөл хориог 2020 оны 12-р сарын 23-ны өдрөөс 2021 оны 1-р сарын 06-ны өдөр хүртэл тогтоосон байна. Бүх нийтийг хамарсан хөл хорио, хүн хоорондын зай барих зэрэг арга хэмжээг дахин давтан сунгахдаа жижиглэнгийн бизнесийн үйл ажиллагааг хамгаалах санхүүгийн бодлогын арга хэмжээг орхигдуулсан. Үүний улмаас жижиглэнгийн бизнесүүд эргэлтийн хөрөнгө багассан эдийн засгийн тодорхой бус нөхцөлд, үйл ажиллагаагаа хэвийн явуулж, удирдахын тулд бизнесийн төлөвлөгөөгөө дахин эргэж харах, өөрчлөх зэрэг хүндхэн сорилтыг туулж байна.

Тусгаарлалт



Олон улсын нислэг, хил нэвтрэх хөдөлгөөнийг хориглож⁷⁰, зөвхөн гадаадад гацсан иргэдээ татаж авах тусгай үүргийн нислэгүүдийг үйлдэж байна. Эх орондоо эргэн ирсэн иргэдийг тусгаарлах байранд 21 хоног, гэрт нь 7 хоног тусгаарлах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Гэртээ тусгаарлагдах үед тухайн хүний гэр бүлийн бусад гишүүд мөн адил тусгаарлалтын дэглэмийг баримтлах шаардлагатай. Эх орондоо буцаж ирэх хүсэлт гаргасан иргэдээс жирэмсэн эх, ахмад настан, хүүхэд, хүнд өвчтэй хүмүүсийг тэргүүн ээлжинд тусгай үүргийн нислэгт хамруулахаар болсон байна.



КОВИД-19 тусгаарлалтын журмын дагуу манай хүү Улаанбаатараас ирээд тусгаарлалтанд орсон. Шинжилгээ өгөөд сөрөг гарсан ч манай сумын удирдлагууд түүнийг сумын зочид буудалд тусгаарлагдаж болох ба буудлын хөлсөнд 900,000 төгрөг төлөх ёстой гэсэн. Мөнгө төгрөгний боломжгүй учраас гэртээ дүү нартайгаа хамт тусгаарлагдаж байгаа. Хүүхдүүдтэйгээ хамт тусгаарлалтанд орчихвол ажлаас 14 хоног цалингүй чөлөө авна. Тиймээс цалингаа авахын тулд одоогоор эгчиндээ байгаа. Тэрнээс гадна, манай гэрийн хашааны хаалган дээр тусгаарлалтад байгаа гэсэн бичиг наачихсан байгаад жаахан сэтгэл хямрах маягтай болоод бухимдаад байна.

Өрх толгойлсон эмэгтэй, Завхан

⁶⁸ Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, хугацааг сунгах тухай Засгийн газрын тогтоол 63, 2020 оны 2 сарын 12; Засгийн газрын тогтоол 147, 2020 оны 4 сар; Засгийн газрын тогтоол 188, 2020 оны 5 сар; Засгийн газрын тогтоол 234, 2020 оны 6 сар

⁶⁹ Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, хугацааг сунгах тухай Засгийн газрын тогтоол 178, 2020 оны 11 сар; Засгийн газрын тогтоол 181, 2020 оны 11 сар; Засгийн газрын тогтоол 209, 2020 оны 12 сар; Засгийн газрын тогтоол 226, 2020 оны 12 сар

⁷⁰ Засгийн газрын тогтоол 39, Хилийн зарим боомтыг түр хаах, нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах тухай. 2020 оны 1 сарын 31.

Амьжиргааг дэмжих багц арга хэмжээ



Засгийн газраас КОВИД-19 цар тахлын эдийн засаг, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах зорилгоор хүүхдийн мөнгө, тэтгэмж болон хүнсний эрхийн бичгийн мөнгөн дүнг нэмэгдүүлж, хувь хүн, аж ахуйн нэгжид татвар, нийгмийн даатгалын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлж, нийслэлийн гэр хорооллын өрхөд түлээ түлшний үнийн хөнгөлөлт, бүх айл өрх, аж ахуйн нэгжийг ус, дулаан, цахилгааны төлбөрийн хөнгөлөлтөд хамруулах зэрэг багц арга хэмжээг хэрэгжүүлж байна.⁷¹ Эдгээр арга хэмжээг жендэрийн ялгаатай онцлог хэрэгцээ, цар тахалд хамгийн их өртсөн бүлгүүдийг нарийвчлан тодорхойлохгүйгээр хэт хавтгайруулан хэрэгжүүлж байгаа нь улс орны эдийн засагт эргээд сөргөөр нөлөөлөх талтай.

Гэрээсээ ажиллах зохицуулалт



2020 оны 3 дугаар сард Засгийн газраас жирэмсэн болон 0-12 насны хүүхэдтэй эмэгтэй ажилтнуудаа гэрээс нь ажиллуулах, эсвэл цалинтай чөлөө олгохыг төрийн болон хувийн хэвшлийнхэнд уриалсан.⁷² Энэхүү шийдвэрт зөвхөн эмэгтэйчүүдийг хамруулж байсан бол 11-р сард хатуу хөл хориог зарлахдаа, өмнөх алдаагаа засаж, жендэрийн мэдрэмжтэй хандан 0-12 насны хүүхэдтэй ганц бие эцгийг нэмж хамруулахаар болсон байна. Гэрээс ажиллах шийдвэрийг хэрэгжүүлэх үед эмэгтэйчүүдэд хамгийн ихээр тулгарч байсан асуудал нь гэрийн ажил, хүүхэд асрах гэх мэт хөлсгүй хөдөлмөрт илүү цаг зарцуулах шаардлагатай болсон явдал юм.

Нэг цэгийн үйлчилгээний төв болон түр хамгаалах байрны талаарх мэдээлэл



2020 оны 11-р сарын 12-ны өдөр Засгийн газраас бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, хөл хорионы үед ажиллах шаардлагатай аж ахуйн нэгжүүдийг нийтэд албан ёсоор зарласан.⁷³ Хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлдэг НЦҮТ, түр хамгаалах байрууд тухайн цаг хугацаанд үйл ажиллагаагаа хэвийн явуулж байсанч Засгийн газраас зарласан ажиллах боломжтой газруудын жагсаалтад тэднийг дурдаагүй нь хохирогчийн үйлчилгээ авах нөхцөлийг хязгаарлах эрсдэлтэй алхам болсон. Харин 2020 оны 12-р сарын 22-нд хатуу хөл хориог дахин сунгахдаа гэр бүл, хүүхэд хамгааллын үйлчилгээг ажиллах боломжтой газруудын жагсаалтад албан ёсоор танилцуулсан.⁷⁴

Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо

УИХ-аас улсын төсөв, эдийн засгийг дэмжих багц арга хэмжээний талаарх шийдвэрийг Монгол Улсын Засгийн газрын нягт хамтын ажилагааны хүрээнд баталж байна. Одоогийн УИХ-ын 75 гишүүний 13 буюу 17 хувь, Засгийн газрын гишүүдийн 3 буюу 18 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

⁷¹ Засгийн газрын тогтоол 114, Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай. 2020 оны 4 сар; Засгийн газрын тогтоол 167, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн амьжиргааг дэмжих нийгмийн хамгааллын зарим арга хэмжээний тухай. 2020 оны 5 сар; Засгийн газрын тогтоол 200, Сайжруулсан шахмал түлшний талаар авах зарим арга. 2020 оны 12 сар; Засгийн газрын тогтоол 211, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай. 2020 оны 12 сар.

⁷² УОК-ын тогтоол 06, 2020 оны 3 сарын 10.

⁷³ Засгийн газрын тогтоол 178, Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай, 2020 оны 11 сар; Засаг даргын захирамж А/1242, Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай. 2020 оны 11 сарын 12

⁷⁴ Засаг даргын захирамж А/1320, Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай. 2020 оны 12 сарын 22

Ийнхүү эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны түвшин бага байгаа нь эмэгтэйчүүдийн хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлох, улмаар жендэрийн мэдрэмжтэй шийдвэр гаргахад сөргөөр нөлөөлж байна.

Хил хаах, орон нутаг дахь хөл хөдөлгөөнийг хязгаарлахад салбарын яамдын дэмжлэг оролцоотойгоор Улсын Онцгой Комиссоос (УОК) тодорхой шийдвэрүүдийг гарган хэрэгжүүлж байна. Тус комисс нь 2020 оны УИХ-ын сонгуулийн дүнгээр бүтэц бүрэлдэхүүний хувьд дахин зохион байгуулагдсан бөгөөд одоогоор 26 гишүүнтэйгээс 3 нь буюу 11 хувийг эмэгтэй гишүүд бүрдүүлж байна. УОК дахь хүйсийн төлөөллийн хувь хэмжээ нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай Монгол Улсын хуулийн холбогдох заалтыг зөрчсөн байна.⁷⁵

10.2. Төрийн байгууллагын дэргэдэх болон үндэсний хэмжээний хороо, зөвлөл, комисс (цаашид “хороо” гэх) зэрэг зөвлөлдөх буюу хамтын удирдлагын байгууллагад аль нэгэн хүйсийн төлөөлөл нийт гишүүний 40 хувиас доошгүй байна.

... Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль

Эмэгтэйчүүдийн оролцооны түвшин ийнхүү хангалтгүй байгаа нь жендэрийн мэдрэмжтэй шийдвэр гаргахад сөргөөр нөлөөлдөг. Эмэгтэйчүүд, тэдний оролцооны байгууллага, бүлэг, сүлжээг идэвхтэй дэмжиж хамтран ажилласнаар КОВИД-19 цар тахлын үед эмэгтэйчүүдэд тулгарч буй асуудал бэрхшээлийг зөв тодорхойлоход олон нийт, шийдвэр гаргагчдад тодорхой дэмжлэг болж чадна.

3.4 Эмзэг бүлэг

Өрх толгойлсон эмэгтэйчүүд

Коронавирусын тархалтыг хязгаарлах зорилгоор авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь өрх толгойлсон ганц бие эцэг, эхчүүд, ялангуяа хүүхдээ ганцаараа өсгөхийн зэрэгцээ зөвхөн орлогоороо амьдардаг эхчүүдэд хүнд дарамт учруулж байна. ҮСХ-ны статистик мэдээгээр, Монгол Улсад 69,787 өрх толгойлсон эмэгтэй, 17,775 өрх толгойлсон эрэгтэй байна.⁷⁶ Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн 43.1 хувь (34,245) нь 18-аас доош насны хүүхэдтэй⁷⁷ бөгөөд хөл хорионы улмаас тэдний орлого буурч аж, амьдралд хүндрэл учирч байна.⁷⁸ Гэр бүл салсны дараа ихэнх эмэгтэйчүүд үр хүүхдээ асран хамгаалах үүргийг хүлээдэг. Ялангуяа цар тахлын үед гэр бүл салалттай холбоотой асуудал нь олон эмэгтэйчүүдийн амьдралд санхүүгийн болон сэтгэл зүйн дарамт учруулж байна.

КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний үеэр ганц бие өрх толгойлсон эцэг, эхчүүдийн гэрийн хөлсгүй хөдөлмөрт зарцуулах цаг нь нэмэгдсэн талаар гүнзгийрүүлсэн ярилцлаганд оролцогчид дурдаж байлаа.

 *Хүүхдээ хараад ажил хийж чадахгүй байгаа. Нэг хүүхэд минь хөгжлийн бэрхшээлтэй, нөгөө хүүхэд минь цахимаар хичээлээ хийдэг... амьдрал улам л хэцүү болж байна даа.*


Өрх толгойлсон эмэгтэй, Улаанбаатар

⁷⁵ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, 2011, 10-р зүйл.

⁷⁶ ҮСХ. Өрх толгойлсон ганц бие эцэг, эх. https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSQ_3300_044V1

⁷⁷ ҮСХ. 18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эх. https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSQ_3300_045V1

⁷⁸ UNDP. May 2020. Rapid Socio-Economic impact assessment of COVID-19 prevention measures on vulnerable groups and value chains in Mongolia

 Миний хоёр ихэр 4 настай. Хөл хорионоос өмнө би уул уурхайн компанид тогооч хийдэг байсан. Засгийн газраас КОВИД-19 цар тахлын үед 0-12 настай ээж нар гэртээ байж, хүүхдээ харах захирамжийн дагуу манай дарга намайг хүүхдүүдээ хар гэрээд цалингүй чөлөө олгосон. Надад манай 2 хүүхдийн мөнгөнөөс өөр орлого алга даа.

Өрх толгойлсон эмэгтэй, Дундговь

16-аас доош насны олон хүүхэдтэй байх тусам эмэгтэйчүүдийн, ялангуяа ганц бие эхчүүдийн хувьд гэрийн хөлсгүй хөдөлмөрт зарцуулах цаг улам бүр ихэсдэг байна.⁷⁹ НҮБХХ-ийн судалгаанд КОВИД-19 цар тахлын улмаас эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү ихээр сэтгэл санааны дарамтад өртөж байгааг онцолсон байна. Өрхийн орлого буурах, хүүхдээ асарч, халамжлахад их цаг зарцуулах, цар тахлын эрсдэлээс айж түгших шалтгааны улмаас эмэгтэйчүүд сэтгэл санааны тогтворгүй байдал, хямралд өртөж улмаар сэтгэцийн эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлж байна.⁸⁰

 Гэрт хүүхдүүд хоолгүй, түлээ нүүрсгүй болчихвий гэж санаа их зовж байна... Би өөрийгөө өрх толгойлсон гэнц бие хүн гэж өрөвдүүлэхийг хүсээгүй юм шүү... гэхдээ би маш их стрессдэж байна...

Өрх толгойлсон эмэгтэй, Улаанбаатар

 Гэртээ байхаар хүүхдэдээ маш хурдан уурлах юм. Өчүүхэн жижиг зүйл хийсэн ч тэднийг буруутгаад, хүүгээ хаяадаа цохиод авчихдаг.


Өрх толгойлсон эмэгтэй, Хэнтий

Засгийн газрын авч хэрэгжүүлж буй хариу арга хэмжээ нь ядуурал, тэгш бус байдал улам гүнзгийрэхээс урьдчилан сэргийлж чадсан байна хэмээн АХБ-аас үзжээ.⁸¹ Утсаар ярилцсан өрх толгойлсон эмэгтэйчүүд ч мөн адил хүүхдийн мөнгөн тэтгэмжийн дүн нэмэгдсэн нь тэдний амьдралд ихээхэн тус дэм болж байгааг онцлон дурдаж байлаа.

 Гурван хүүхэдтэй ганц бие ээж байна гэдэг үнэхээр хэцүү байдаг. Хүүхдийн мөнгө авдаггүй байсан бол амьдрахад бүр асуудалтай болох байлаа.

Өрх толгойлсон эмэгтэй, Завхан

Нийгмийн эмзэг бүлэг, тэр дундаа өрх толгойлсон эмэгтэйчүүдийн олонх, дэд бүтэц хөгжөөгүй, гадна нүхэн жорлонтой, цэвэр ус, хог хаягдлын менежмент муутай, нийтийн шүршүүртэй, цэвэр усны хангамж хүрэлцээгүй, ариун цэврийн шаардлага хангахгүй нөхцөлд амьдарч байна. Ариун цэвэр, дэд бүтцийн эдгээр асуудал нь эмэгтэйчүүд, охидын эрүүл мэндэд сөрөг, таагүй орчинг бүрдүүлж байна.

 Манайх гэр хороололд байдаг. Эрүүл ахуйн ариун цэвэр гэдэг бидний хувьд маш том асуудал. Коронавирусаас хамгаалахын тулд жорлонгоо сайжруулах хэрэгтэй гэж бодож байна. Харамсалтай нь манай хороонд байгаль орчинд ээлтэй, ариун цэврийн шаардлага хангасан жорлонгийн асуудлаар мэдээлэл, дэмжлэг юу ч алга байна.

Ахмад настан эмэгтэй, Улаанбаатар

КОВИД-19 цар тахал нь өрхийн хүнсний хэрэглээнд сөргөөр нөлөөлж байна. Ялангуяа өрх толгойлсон эмэгтэйчүүдийн хувьд орлого багасаж, хүнсний бүтээгдэхүүний үнэ өссөнөөр хүнсний хэрэглээ нь буурсан байна.⁸² Тус судалгаанд дурдсанаар сургууль, цэцэрлэг хаагдсантай холбогдуулан сургууль,

⁷⁹ ҮСХ. Цаг ашиглалтын судалгаа. УБ. 2019

⁸⁰ UNDP. May 2020. Rapid Socio-Economic impact assessment of COVID-19 prevention measures on vulnerable groups and value chains in Mongolia

⁸¹ АХБ, Монгол улс: Үр дүнтэй нийгмийн халамжийн системийн чадавхи бэхжүүлэх нь Монгол улс дахь КОВИД-19-ийн үеийн нийгмийн хамгааллын хариу арга хэмжээний үнэлгээ. 2020 оны 10 сар

⁸² UNDP. May 2020. Rapid socio-economic impact assessment of COVID-19 prevention measures on vulnerable groups and value chains in Mongolia

цэцэрлэгийн насны хүүхэдтэй өрхийн хүнсний хэрэглээнд зарцуулах зардал дунджаар 8.6 хувь буюу 5,400 төгрөгөөр нэмэгдсэн гэж дурджээ.⁸³ Айл өрхийн орлого буурсанаас зохих шим тэжээлтэй хоол хүнс худалдан авч чадахгүй болсон мөн цэцэрлэг, сургууль хаагдсанаас болж олон хүүхэд хоол тэжээлийн дутагдалд орж болзошгүй байна.

 Миний хувьд хүүхдүүд гэртээ байснаас сургуульдаа явсан нь дээр гэж бодож байна. Ядаж хоёр нь сургууль дээрээ үдийн цайнд орчихдог. Бага хүүхдүүд болохоор өдөржингөө л боов талхаа зөөчих юм. Тэдний минь буруу гэж юу байх вэ дээ. Орлогогүй болоод байдаг яана даа.

Өрх толгойлсон эмэгтэй, Улаанбаатар

Охид эмэгтэйчүүд


КОВИД-19 цар тахалтай холбоотойгоор жендэрт суурилсан хүчирхийлэл, тэр тусмаа нийгмийн эмзэг бүлгийн охид эмэгтэйчүүдийн хүчирхийлэлд өртөх байдал нь огцом өссөн талаар дэлхийн бусад улс оронд хийсэн олон судалгааны дүнгээс харж болно.⁸⁴

Хүүхдүүд гэртээ илүү удаан хугацаанд байх болсноор тэдний зан үйл, сэтгэцийн эрүүл мэндэд нөлөөлж байна. Өсвөр насны хүүхдүүд зөвхөн өөртөө санаа зовох биш өөрсдийн гэр бүл, гэр бүлийн орлого, хичээл сургуульдаа санаа зовниж байдаг. Эцэг эхийнхээ сэтгэл санааны дарамтад орж байгааг харсан хүүхдүүд айх, эргэлзэх, өөрийгөө хүрээлэн буй орчноос болон нийгмээс тусгаарлах зэргээр хэвийн бус аашлах үзэгдэл гарч байна.⁸⁵ Түүнчлэн ухаалаг утас, компьютер, интернэтийн тогтвортой сүлжээгүйгээс орлого багатай айл өрхийн хүүхдүүд зайн сургалт буюу онлайн хичээлдээ тогтмол хамрагдаж чадахгүйд хүрч байна.

 Ирэх жил би сургуулиа төгсөнө... Би маш их санаа зовж байна... Манайд компьютер байхгүй, интернэтэд орох боломжгүй.

Эмэгтэй сурагч, Дундговь

Өсвөр насныханд тулгардаг бас нэг асуудал бол цахим гадуурхал бөгөөд энэ нь цар тахлын үед улам ихсэх магадлалтай байна. КОВИД-19 цар тахлын улмаас хүүхэд залуучууд онлайн орчинд илүү их цаг хугацаа зарцуулах болсон. Цахим орчин нь түргэн шуурхай байдлаар мэдээлэл авах, үе тэнгийнхэнтэйгээ харилцах, нийгэмших зэрэг олон давуу талтай хэдий ч 'дэлгэцэнд олон цаг зарцуулах нь зарим талаар эрсдэлийг бий болгож байна. 2017 онд БШУЯ-наас гаргасан тайланд дурдсанаар хүүхдүүдийн дунд нэмэгдэж буй интернэт хэрэглээ нь цахим гадуурхал, бэлгийн болон сэтгэл санааны хүчирхийлэл, мөлжлөг нэмэгдэхэд нөлөөлж байгаа бөгөөд нийт хүүхдүүдийн 13.5 хувь нь цахим гадуурхалд өртсөн байна.⁸⁶

 Цахим хичээл эхэлснээс хойш би фэйсбүүк маш их хэрэглэх болсон. Харин найз нартайгаа чатлах үед тэдний зарим нь их муухай үг яриа ашиглах, муухай мессэж юм уу зохимжгүй зураг явуулдаг...нэг төрлийн цахим хүчирхийлэл шиг санагддаг.

Эмэгтэй сурагч, Улаанбаатар

⁸³ Мөн тэнд

⁸⁴ UN Women. (2020b). Covid-19: Ending violence against women and girls. Key Priorities And interventions for effective response and recovery. UN Women East and Southern Africa.

⁸⁵ Laura Castañeda. 12 Oct. 2020. Negative Impacts during a COVID-19 Pandemic on Children, Adolescents & Families, Mexico

⁸⁶ БСШУСЯ. Цахим гадуурхлын өнөөгийн нөхцөл байдлын зөвлөх судалгаа. 2017

КОВИД-19 цар тахлын үеэр өсвөр насны охидын жирэмслэлт хөгжиж буй орнуудын хувьд томоохон асуудал болоод байна⁸⁷. Сүүлийн жилүүдэд өсвөр насны охидын жирэмслэлт Монгол Улсад буураагүй бөгөөд 2019 онд 15-19 насны өсвөр насны охидын төрөлтийн түвшин 1000 эмэгтэй тутамд 31.7⁸⁸ байсан бөгөөд КОВИД-19 цар тахлын улмаас энэ тоо өсөх магадлалтай юм. Тиймээс охидыг аливаа хүчирхийлэл, эрт жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх, тэднийг хүчирхэгжүүлэх нийгмийн үйлчилгээний хөтөлбөрүүдийг бэхжүүлэх шаардлагатай байна.

2018 онд хөдөөгийн өсвөр насны охидын 6.1 хувь, хотын охидын 2.7 хувь нь 18-аас доош насандаа хүүхэд төрүүлсэн байна.⁸⁹ Үүнээс үзэхэд, хөдөөгийн охидын нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн боловсролыг нэмэгдүүлж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад анхаарах хэрэгтэй байна. Охид, эмэгтэйчүүдийг хүчирхэгжүүлэн чадваржуулснаар тэд өөрт хэрэгтэй аливаа шийдвэрийг бодит мэдээлэлд суурилан гаргадаг болно.

Айл өрхүүд эдийн засгийн хүндхэн асуудалтай тулгарч байгаа нь гэр бүлийн гишүүдийн сэтгэл зүй, хоорондын харилцаанд хүндрэл учруулж байна. Түүнчлэн залуу охид, эмэгтэйчүүдийн гэр бүлийн үүрэг хариуцлага нэлээдгүй нэмэгдэж, эрх чөлөө нь хягаарлагдан, үндсэн эрхээ эдэлж чадахгүйд хүрэх тохиолдол гарч байна. Шинэ залуу үеийнхний оролцоог нэмэгдүүлж, жендэрийн тэгш байдлыг хангах үүднээс КОВИД-19 цар тахалтай холбоотой асуудлаар шийдвэр гаргах үйл явцад охид, эмэгтэйчүүдийн дуу хоолойг сонсох, үйл ажиллагаанд татан оролцуулах, дэмжин ажиллах нь чухал юм.

Ахмад настай эмэгтэйчүүд

Монгол Улсад 55-аас дээш насны 374,428 иргэн амьдарч байгаагийн 215,799 буюу 57.6 хувь нь эмэгтэйчүүд байна.⁹⁰ Ганц бие өрх үүсгэн амьдардаг өндөр наснтуудад нийтлэг тохиолддог эрүүл мэндэд нөлөөлж байдаг зүйл бол нийгмээс тусгаарлагдах, ганцаардах явдал байдаг. Өнөөгийн байдлаар манай улсад 55-аас дээш насны 29,080 эмэгтэй, 65-аас дээш насны 10,421 эрэгтэй хүмүүс ганцаараа амьдарч байна.⁹¹ Улаанбаатар хотод 65-аас дээш насны иргэдийн 50 хувь нь амьдардгаас 6,985 буюу 7 хувь нь эрүүл мэндийн хувьд сул дорой түвшинд байгаа нь тэднийг эмзэг бүлэгт хамаарах шалтгаан болж байна.⁹²

КОВИД-19 цар тахлын үед залуучууд санхүүгийн асуудалд анхаарлаа хандуулж буй бол ахмад настнууд амьдралын өдөр тутмын хэрэгцээндээ илүү санаа зовж байгаа нь ажиглагдлаа. НҮБХХ-ийн судалгаагаар КОВИД-19 цар тахлын үед 50 хүртэлх насны иргэдийн дунд стрессийн түвшин нь хүйсийн ялгаваргүйгээр эрэгтэй, эмэгтэй аль алиных нь хувьд нэмэгдэж байсан бол 50-аас дээш насны эрэгтэйчүүдийн хувьд буурч, харин 60-аас дээш насны эмэгтэйчүүдийн хувьд өссөн үзүүлэлттэй байна.⁹³

⁸⁷ World Vison. 2020. COVID-19 Aftershocks: Access denied - Teenage pregnancy threatens to block a million girls across Sub-Saharan Africa from returning to school.

⁸⁸ ҮСХ. өсвөр насны 1000 эмэгтэйд ногдох төрөлтийн түвшин. https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NS0_2100_047V1

⁸⁹ ҮСХ. Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа. УБ. 2018

⁹⁰ ҮСХ. Монгол улсын хүн ам. 2019. https://1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NS0_0300_003V1

⁹¹ ҮСХ. Өрх үүсгэн ганц биеэр амьдардаг өндөр настай хүний тоо. http://1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NS0_0300_014V1


⁹² <https://www.who.int/mongolia/news/detail/17-08-2020-reaching-the-most-vulnerable-older>

⁹³ UNDP, May 2020. Rapid socio-economic impact assessment of COVID-19 prevention measures on vulnerable groups and value chains in Mongolia

 *Би өөртөө биш, ач зээ нартаа санаа их зовох юм. Ийм хүнд хэцүү цагт яаж амьдралаа даа гэж тэдэндээ санаа зовдог юм. Миний хувьд одоогоор тэдэнд хийж өгч чадах юм алга. Тэтгэврийн хэдээ л зориулах юм.*

Ахмад настан эмэгтэй, Улаанбаатар

Монгол Улсад ахмад настанд зориулсан эрүүл мэндийн болон асрамжийн үйлчилгээний хүртээмж хангалтгүй байгаа нь КОВИД-19 цар тахлын үеийн ахмад настнуудын нөхцөл байдлыг улам дордуулж байна. Ганцаараа амьдардаг ахмад настнууд хөл хорионы үед мэдээллээс хоцрох, эм тариа, хоол хүнс болон бусад шаардлагатай үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байх зэрэг бэрхшээлтэй тулгарч байна. Онцгой асрамж, халамж шаардлагатай ахмад настнуудын хувьд албан бус (төрөл садан, найз нөхөд) болон албан ёсны (орон нутгийн халамж, нийгмийн ажилтан, өрхийн эрүүл мэндийн ажилтнууд) дэмжлэг авч чадахгүй байх нөхцөлд хүрч байна.

 *Телевиз, гар утас хоёртойгоо л найзалж байна. Одоохондоо би өөрийгөө аваад явчихна. Миний бие өвдвөл, хөл хорионы үед хэн намайг харж хандах бол гэж санаа зовох юм.*

Ахмад настан эмэгтэй, Улаанбаатар

Цар тахлын үед зарим ахмад настнууд гэр бүлийн гишүүд, үр хүүхдүүддээ чухал дэмжлэг үзүүлж байна. Тэдний зарим нь санхүүгийн хувьд дэмжлэг үзүүлж байгаа бол зарим нь ач, зээ нараа харж асрахад тусалж байна. Түүнчлэн хөл хорионы үеэр ажиллаж буй хүүхдүүддээ туслах үүднээс өндөр настнууд ач зээ нараа харж асрахад ихээхэн цаг хугацаа зарцуулах болсон байна. Нөгөө талаар КОВИД-19 цар тахлын үеэр ахмад настнууд хүчирхийлэлд өртөх магадлал нэмэгдэж буй бөгөөд тэд бие махбодын болон сэтгэл санааны хүчирхийлэл, эдийн засгийн мөлжлөг, үл хайхрах байдал, дарамтанд орж болзошгүй байна. Ахмад настнууд технологийн мэдлэг чадвар дутмагаасаа болж бусдын хараат байдалд орох нь нэмэгдэж буй бөгөөд ялангуяа тэдний мөнгө, санхүүгээ захиран зарцуулах эрх нь зөрчигдөхөд хүрч байна.

Ахмад настнуудын талаар хийсэн судалгаа, статистик, хүйсээр ангилсан тоон мэдээлэл хангалтгүй байгааг энд нэмж дурдах нь зүйтэй гэж үзэж байна. Жендэрийн ялгаатай байдал буюу хүйсийн бодит байдлыг тодорхой харуулсан тоон мэдээлэл хангалтгүй байгаа нь ахмад настны жендэрийн онцлог, амьдралын нөхцөл байдлыг үнэлэхэд сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

Хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүд

2019 оны байдлаар Монгол Улсын нийт хүн амын 3.3 хувь буюу 107,075 хүн хөгжлийн бэрхшээлтэй байгаагийн 42.9 хувь буюу 45,980 нь эмэгтэйчүүд байна. Улаанбаатар хотод хөгжлийн бэрхшээлтэй 34,860 хүн амьдарч байгаагийн 14,945 нь эмэгтэйчүүд байна.⁹⁴

КОВИД-19 цар тахлын нөхцөл байдал нь хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй гэр бүл, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдтэй гэр бүлд нэмэлт хүндрэл учруулж байна. Асрамж, халамжийн үйлчилгээ, туслах хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж, интернэтэд холбогдох боломж хязгаарлагдмал байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эмзэг байдлыг улам бүр даамжруулж байна.


 *Миний охин тусгай сургуульд сурдаг. Сургуулиас хүүхэд бүрт зориулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээл ордог байсан боловч хөл хорионы улмаас тэр хөтөлбөр нь зогссон.*

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ээж, Улаанбаатар

⁹⁴ YCS. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо. https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NS0_3900_002V1

Бусдаас байнгын хараат буюу өдөр тутам дэмжлэг тусалцаа авдаг хөгжлийн бэрхшээлтэй хүн хөл хорионы үед тусгаарлалтанд орсноор эрүүл мэнд, нийгмийн тусламж үйлчилгээг авч чадахгүйд хүрч байна. Эрүүл мэнд, нийгмийн хүчин зүйлсийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүн эрүүл мэндийн үндсэн тусламж үйлчилгээнд тэр бүр хамрагдаж чадахгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд ялгаварлан гадуурхалд өртөх байдал ажиглагдсаар байгаа бөгөөд хүчирхийллийн үед бусдаас тусламж эрэх чадвар хомс байдаг нь тэдний хувьд бэрхшээлтэй асуудал хэвээр байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүн урьдчилан сэргийлэх болон хамгааллын хариу үйлчилгээнд хамрагдах нь бага байдаг. АХБ-ны судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй хүнийг гэрт нь цоожлох, хүүхэд харуулах гэх мэт цалин хөлсгүй хөдөлмөр эрхлүүлэхээс гадна, тэдний зарим нь бэлгийн хүчирхийлэлд өртөж байж болзошгүй байна гэж дурджээ.⁹⁵


 *Хөл хорионы энэ өдрүүдэд үйлчлүүлэгчдээ гаргахгүй, эргэлтээр хүмүүс ирэхийг зөвшөөрөхгүй байгаа. Энэ бүхэн тэдэнд маш хэцүү байгаа нь ойлгомжтой.*

Нийгмийн ажилтан, Ахмадын асрамжийн төв

Малчин эмэгтэйчүүд

Монгол Улсад мал аж ахуйн салбар нь ДНБ-ний 10.9 хувийг эзэлж, экспортын орлогын 8.2 хувийг бүрдүүлдэг бөгөөд нийт ажиллах хүчний 25.3 хувь буюу дөрөвний нэг нь энэ салбарт ажиллаж байна.⁹⁶ ҮСХ - ны мэдээгээр 171,605 малчин өрхийн 285,482 малчид мал маллаж байгаа нь нийт хүн амын 19.5 хувийг эзлэх бөгөөд үүнээс 119,114 буюу 41.7 хувь нь эмэгтэйчүүд байна. Эмэгтэйчүүд малчин өрхийн амьжиргаанд идэвхтэй хувь нэмэр оруулж байна.

2020 оны байдлаар гурван малчны нэг нь ядуу амьдарч байна.⁹⁷ Малчид орон нутгийн уур амьсгал, мал ахуйгаасаа хамааралтай амьдардаг тул байгалийн гамшигт үзэгдэл, бэлчээрийн доройтол, мал, малын гаралтай түүхий эдийн үнийн хэлбэлзэлд амархан өртдөг. 2020 зуны ган, өвлийн зудын байдал тэдний амьжиргаанд сөргөөр нөлөөлж байна. 2020 оны 11-р сарын 20-ны зудын эрсдэлийн үнэлгээгээр газар нутгийн 40 хувьд зуд болох эрсдэлтэй (6 хувь маш өндөр эрсдэлтэй, 30.4 хувь нь өндөр эрсдэлтэй), 28.2 хувьд дундаж эрсдэлтэй⁹⁸ бөгөөд зудын эрсдэлтэй бүс нутагт амьдарч буй малчин өрхийн хувьд бэлэн мөнгө, малын эм, тариа, өвс тэжээл, хоол хүнсний хангамж чухал асуудал болж байна. Дэлхийн Банкны судалгаагаар малчин өрхийн мал аж ахуйгаас олох орлого өнгөрсөн онтой харьцуулахад 70 хувь буурсан гэж дүгнэсэн нь КОВИД-19 цар тахал малчид, тэдний гэр бүлд сөрөг нөлөө үзүүлсэн болохыг давхар нотолж байна.⁹⁹ Ялангуяа 200-аас цөөн тооны малтай малчин өрхийн хувьд орлогын өөр эх үүсвэргүй, төрөөс өгдөг халамж, тэтгэмжээс ихээхэн хамааралтай байгаа нь зуд болон бусад санхүүгийн хямралт нөхцөл байдал, цар тахлын үед ихээхэн хүндрэл бэрхшээлтэй тулгарахад нөлөөлж байна.

 *Мал бол манай гэр бүлийн амьжиргааны эх үүсвэр. Миний хувьд мал маллахаас өөр ажил хийж чадахгүй. Зуд болж цаг хэцүүдээд малын өвс, тэжээлийн үнэ өссөн тул 350 толгой малынхаа 100 гаруйг нь зарсан. Хөл хорионы улмаас наад захын ахуйн хэрэгцээний зүйлсийн үнэ өссөн. Үнийн өсөлт бид нар шиг цөөн малтай, орлого багатай өрхийн амьдралд хүндхэн нөлөөлж байна.*

Малчин эмэгтэй, Дундговь

⁹⁵ ҮСХ. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо. https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NS0_3900_002V1

⁹⁶ ADB. Dec 2019. Living with Disability in Mongolia: Progress toward Inclusion


⁹⁷ Дэлхийн Банк, ҮСХ. Өрхийн нийгэм, эдийн засгийн 2018 оны судалгааны мэдээлэлд суурилсан Ядуурлын дүр төрх -2018 тайлан. 2020 он.

⁹⁸ Цаг уур, орчны шинжилгээний газар. Зудын эрсдэлийн тайлан. 2020 оны 11 сар, <http://tsag-agaar.gov.mn/>

⁹⁹ Дэлхийн Банк, ҮСХ. “Коронавирусийн нөлөөллийг тодорхойлох өрхөд суурилсан судалгаа” – утсанд суурилсан судалгааны 2 дахь шатны дүн. 2020 оны 12 сарын 17


Байгалийн гамшигт үзэгдэл, КОВИД-19 цар тахалтай зэрэгцэн банкны зээл малчдын амьжиргаанд хүндрэл учруулж байна. Нийт малчдын 40 хувь нь зээлтэй байгаа талаар ҮСХ-ны судалгааны тайланд дурджээ.¹⁰⁰ Малчид банкнаас зээл авахын тулд малаа даатгалд хамруулсан байх шаардлагатай байдаг бөгөөд банкны барьцаанд малын тоо толгой нь хүрэхгүй байсан ч даатгалд хамрагдан өөрийн боломжоос илүү хэмжээний зээл банкнаас авсан малчид их байна. Энэ нь цөөн тооны малтай малчид амьжиргааны гол эх үүсвэр болсон малаа алдах, ган, зудын үед өртэй үлдэх эрсдэлд хүргэж байна.

ҮСХ-ны тайланд дурдсанаар, 2019 оны байдлаар нийт малчдын 27.4 хувь, үүнээс эмэгтэй малчдын 45.7 хувь нийгмийн даатгалд хамрагдсан байна. Малчдын 66 хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсанаас эрэгтэй малчдын 62 хувь, эмэгтэй малчдын 71.7 хувь байна.¹⁰¹ Эрүүл мэндийн даатгал зөвхөн эмчид үзүүлэх, эмнэлэгт хэвтэхэд хэрэг болдог хэмээн гүнзгийрүүлсэн ярилцлагад оролцогч эмэгтэй малчид үзэж байгаа нь тэд эрүүл мэндийн даатгалын ашиг тусын талаар төдийлөн сайн ойлголт байхгүйг харуулж байна. Отроор явж буй малчдын хувьд орон нутгийн замын нөхцөлөөс хамааран эрүүл мэндийн үйлчилгээ авч чадахгүй тохиолдол гарсаар байна. КОВИД-19 цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээнээс шалтгаалан малчид хөл хорионд орж, ялангуяа өөр аймагт оторлох үеэр эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байх эрсдэлтэй тулгарч байна.

 *Нөхөр бид хоёр отороор явж байгаа. Би жирэмсэн тул хэдэн долоо хоногийн өмнө эмчид үзүүлэх шаардлагатай болсон юм. Гэтэл манай гэр бүл оторлож байгаа газартаа хөл хорионд орчихсон. Бидэнд мэдээлэл ч алга. Явж болохгүй бол яахав гээд л сууж байна.*

Малчин эмэгтэй, Хэнтий

Судалгаанд оролцогч эмэгтэйчүүдийн дийлэнх нь гэр бүл салалт болон мөнгө санхүүгийн хараат байдал тэдний эдийн засгийн бие даасан байдалд сөргөөр нөлөөлж байна гэж үзэж байна. Энэ нь даамжирч гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан болоход нөлөөлж байна. Гэр бүлийн гишүүд удаан хугацаанд тусдаа амьдрах нь малчин гэр бүлийн хувьд гэр бүл салалт, гэр бүлийн хүчирхийллийн үндсэн шалтгаан болсоор ирсэн. Хичээлийн жилийн хугацаанд олон гэр бүл хөдөө болон аймаг, сумын төвд тусдаа амьдардаг. Сургууль хаагдсанаар эдгээр гэр бүлүүд эргэн нэгдэж, хамтдаа амьдрах боломжтой болсон ч зудын нөхцөл байдлын улмаас тусдаа амьдрах явдал байсаар байна. Гэр бүлийн гишүүд хоёр талд тусдаа амьдрах нь өрхийн зардлыг мөн адил нэмэгдүүлдэг талтай.

 *Коронавирусаас болж сургууль хаахаас өмнөхөн би хүүхдүүдтэйгээ сумын төвд амьдарч байсан юм. Одоо бид нар цугтаа хөдөө амьдарч байна. Гэтэл хань минь отроор Төв аймагт явж байна... гэрээсээ 200 гаруй километр хол байна.*

Малчин эмэгтэй, Дундговь

Гүнзгийрүүлсэн ярилцлагад оролцогч малчдын хэлснээр КОВИД-19 цар тахал болон зудын нөхцөл байдал тэдний амьдралд хүндээр тусаж байна. Малчин эмэгтэйчүүд өрхийн орлогодоо маш их санаа зовж байсан. Тэдний олонх нь хүүхдийнхээ хичээлийг гэртээ давтуулах хүнд асуудалтай тулгарч байгаагаа дурдаж байлаа.¹⁰² Амьжиргааны баталгаат түвшингээс доогуур орлоготой малчин өрхийн хүүхдүүд боловсролын хоцрогдолд орох эрсдэлтэй байна.¹⁰³ Түүнээс гадна үйлчилгээний

¹⁰⁰ ҮСХ. Монгол улсын хөдөө аж ахуйн салбарын 2019 оны танилцуулга. 2020

¹⁰¹ ҮСХ. Монгол улсын хөдөө аж ахуйн салбарын 2019 оны танилцуулга. 2020

¹⁰² UNICEF. June 2020. Mongolia Novel Coronavirus (COVID-19) Situation Report No2

¹⁰³ UNICEF. August 2020. Mongolia Novel Coronavirus (COVID-19) Situation Report No4

байгууллагууд интернэт горимд шилжин ажиллах болсноор аймаг, сумаас хол алслагдсан орон нутагт амьдардаг малчид нийгмээс тусгаарлагдах, мэдээллийн гадна хоцорч үлдэх шалтгаан болж байна. Эцэг эхчүүд хүүхдээ боловсролын хоцрогдолд оруулахыг хүсдэггүй ч цахим хичээл хийхэд хэрхэн дэмжиж туслахаа мэдэхгүй санаа нь зовсон байдал ажиглагдаж байлаа.

 Ухаалаг утас, интернет хэрэглэнэ гэдэг тусгай чадвар шаардах эд байна. Миний хувьд сурахгүй зүйл юм байна лээ, төвөгтэй хэцүү.


Малчин эмэгтэй, Хэнтий

Шилжин суурьшсан эмэгтэйчүүд

Шилжин суурьшсан хүмүүсийн олонх нь орлого бага байдгаас гадна, илүү дээр амьдрах нөхцөл хайж төрсөн газар нутгаа орхих сонголтыг хийдэг. Түүнчлэн ядуурал, ган, зуд гэх мэт цаг уурын эрс тэс уур амьсгалын нөхцөл байдал шилжилт хөдөлгөөнд нөлөөлж байна. ҮСХ-ны 2020 оны хүн ам, орон сууцны тооллогын тайланд дурдсанаар аймгаас Улаанбаатар хотруу шилжих хөдөлгөөн сүүлийн таван жилд 49.1 хувиар буурсан нь Улаанбаатар хотын захирагчийн хөдөөнөөс хот руу шилжих хөдөлгөөнийг зогсоосон шийдвэртэй холбоотой байх магадлалтай.¹⁰⁴

Шилжин суурьших шалтгаанд ажилгүйдэл голлох байр суурийг эзэлдэг. Мөн эдийн засгийн илүү боломжийг эрэлхийлэх, эрүүл мэнд, боловсрол, нийгэм, төрийн үйлчилгээний хүртээмжээс үүдэн шилжин суурьших хөдөлгөөн нэмэгддэг.

НҮБХХ-ийн судалгаанд өгүүлснээр КОВИД-19 цар тахал шилжин суурьшигчдад ихээхэн нөлөөлсөн байна. Шилжин суурьшсан өрхүүд нийгмийн ямар нэг даатгал, халамжинд хамрагдаагүй, мөнгөн хадгаламж хуримтлал байхгүйн улмаас ядууралд өртөх магадлал өндөр байдаг байна.¹⁰⁵ Шилжин суурьшигчид нь нутгийн иргэдтэй адил эрх эдэлж чадахгүйн улмаас эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ, нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох боломж хязгаарлагдаж байдаг. Ядуу байдал, олуулаа бөөгнөрөн амьдрах (гэр дотроо хүн хоорондын зай барих), олон төрлийн ажил хийх (олон хүнтэй харилцах байдалд орох) зэрэг тулгамдаж буй нөхцөл байдал нь гадаад, дотоодод шилжин суурьшигч иргэдийн КОВИД-19 цар тахлын хямралд өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

 Жил гаруйн өмнө манайх хотод нүүж ирээд гэр хороололд суурьшсан. Сайхан амьдрах л гэж нүүж ирсэн. Гэтэл бид зээлээс зээлийн хооронд амьдарч, дээшилсэн юм алга. Коронагийн нөхцөл байдлаас бидний амьдрал улам хүндэрчихлээ. Сум нутаг руугаа буцмаар байгаа боловч манай нөхөр явах дургүй байна. . .

Шилжиж ирсэн эмэгтэй, Улаанбаатар


КОВИД-19 цар тахлаас үүдсэн эдийн засгийн хямралын үед шилжин суурьшсан иргэд ажилгүйдэл, цалин хөлсгүй болох эрсдэлд ихээр өртөж байна. Түүнчлэн тэдний орлогоос хамааралтай гэр бүлд нь энэ байдал шууд нөлөөлж, хүндрэл учруулж байна. Цар тахлын улмаас бий болсон эдийн засгийн хямралын улмаас олонх шилжин суурьшсан иргэд ажилгүй, орлогогүй болж байна. НҮБ-ийн Эмэгтэйчүүдийн байгууллагаас КОВИД-19 цар тахлын үед дэлхий даяар 25 сая эмэгтэй шилжилт хөдөлгөөний явцад ажилгүйдэлд өртөж болзошгүйг анхааруулсан байна¹⁰⁶.

¹⁰⁴ Засаг даргын захирамж А/1042, Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай. 2017 оны 1 дүгээр сарын 09

¹⁰⁵ UNDP. May 2020. Rapid socio-economic impact assessment of COVID-19 prevention measures on vulnerable groups and value chains in Mongolia

¹⁰⁶ UN Women. 2020. COVID-19: Ending violence against women and girls. Key priorities and interventions for effective response and recovery. UN Women East and Southern Africa.

Хил хааж, аялал жуулчлал зогссоноор Замын-Үүд (урд хилийн боомт) зэрэг хилийн боомт газрын ойролцоо ажиллаж амьдардаг иргэд ажил, хөдөлмөрөө үргэлжлүүлэн хийж чадахгүйд хүрсэн. Тэд ихэвчлэн зоогийн газар, зочид буудал, тээвэр үйлчилгээний салбарт бичил бизнес эрхэлдэг байна. Зарим иргэдийн хувьд илүү орлого олох боломж эрэлхийлэн БНХАУ-д түр хугацаагаар ажилладаг байсан бол хил хаасны улмаас орлогогүй болсон байна.

 *Аймгийн төвд цалин багатай ажилтай амьдрахад их хэцүү л дээ. Тиймээс манай найз бид хоёр Өвөр Монголд нэг жижигхэн хувийн аж ахуйтай компанид цалин сайтай ажилд орж гурван сар ажилласан. Бидний ажиллаж байсан компанийн эзэн нь өвөрмонгол хүн байсан. Хөл хорионоос болоод бид нутаг буцаж ирсэн. Хүүгээ сайн боловсролтой болгохын тулд би хотод гайгүй ажлын боломж хайж ирсэн.*

Шилжиж ирсэн эмэгтэй, Улаанбаатар

4. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

4.1 Дүгнэлт

КОВИД-19 цар тахал нь хүн бүрийн амьдралд нөлөөлөөд зогсохгүй жендэр болон нийгэм-эдийн засгийн тэгш бус байдлыг улам гүнзгийрүүлж байна. Энэхүү тэгш бус байдал нь охид, эмэгтэйчүүд, орлого багатай иргэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, малчид, шилжин суурьшигчдын аж амьдралд дараах байдлаар нөлөөлж байна:

Эдийн засгийн тэгш бус байдал



Цар тахал нь ядуурал нэмэгдэхэд олон талаар нөлөөлж байна. Зарим иргэд цар тахлын үеэр ажлаа үргэлжлүүлэн хийх боломжтой байсан хэдий ч ихэнх иргэдийн орлого буурч байна. КОВИД-19 цар тахлаас ангижрахын тулд улс орны зүгээс ЖДҮ болон хувиараа хөдөлмөр эрхлэгчид, ядуу болон ядууралд өртөх магадлал өндөр хүмүүст онцгой анхаарал хандуулснаар эдийн засгийн тэгш бус байдлыг бууруулахад хувь нэмэр оруулах боломжтой.

Эрүүл мэндийн тэгш бус байдал:



Урьд өмнө нь байсан эрүүл мэндийн үйлчилгээ болон иргэдийн эрүүл мэндийн тэгш бус байдал нь цар тахлын үеэр ядуу иргэдийн эмзэг байдлыг улам бүр нэмэгдүүлж байна, эрүүл мэндтэй холбоотой тэгш бус байдалд нийгэм, эдийн засгийн байдал, газар зүйн байршил, хүйс, үндэстэн ястны ялгаатай байдал голлох хүчин зүйл болж байна. Эмнэлгийн үйлчилгээ ядуу иргэдэд ялангуяа эмэгтэйчүүдэд хүртээмжгүй байхаас гадна хот болон хөдөө, орон нутгийн түвшинд эмнэлгийн үйлчилгээ ялгаатай байгаа нь эмэгтэйчүүдэд илүү хүндрэл учруулж байна. Газар зүйн байршилын хувьд алслагдмал байх тусмаа эмнэлгийн үйлчилгээ, ариутгал, хүчин чадал болон дэд бүтэц тааруу байгаа нь охид эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн байдалд сөрөг нөлөөтэй байна. Эрүүл мэнд болон үйлчилгээний тэгш бус байдалд охид, эмэгтэйчүүд, ХБИ болон ахмад настангууд зэрэг нийгэм, эдийн засгийн хувьд эмзэг иргэд илүүтэй өртөж байна. Эрүүл мэндийн тэгш бус байдал улам бүр нэмэгдэж байгаа нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгаатай байдлыг бууруулах, эмзэг бүлгийн хүн амын амьдралыг сайжруулах бодлого боловсруулах шаардлагатай байгааг харуулж байна.

Боловсролын тэгш бус байдал:



Дижитал хэрэглээний ялгаатай байдал нь тэгш бус байдлыг гүнзгийрүүлж улмаар ядуу болон алслагдмал хөдөө орон нутагт амьдарч буй иргэдийн боловсролын үйлчилгээнд хамрагдах ялгаатай байдлыг улам бүр нэмэгдүүлж байна. Эсрэг хүйсийн үе тэнгийнхэнтэй нь харьцуулахад залуу охид, эмэгтэйчүүд ахуйн хүрээний цалин хөлсгүй гэр орны ажлаас болоод сурч боловсроход цаг бага зарцуулж байна. Энэ нь олон ам бүлтэй, ядуу гэр бүл, хөдөө орон нутаг болон гэр хороололд амьдардаг охидуудын боловсролын ялгаатай байдлыг бий болгож байна.

Хүний эрх болон тэгш бус байдал:



Жендэрийн тэгш бус байдлаас болж охид, эмэгтэйчүүд КОВИД-19 цар тахлын нөлөөлөлд илүү өртөж байна. Цар тахлын улмаас охид, эмэгтэйчүүдийн цалин хөлсгүй ажлын ачаалал эрс нэмэгдэж, ялангуяа эмзэг бүлгийн иргэдийг үл тоомсорлон, эрхийг нь үгүйсгэх хандлага их байна. КОВИД-19 цар тахлаас өмнө байсан жендэрийн тэгш бус байдал энэ цаг үед эдийн засаг, нийгэм, улс төрийн хүрээнд улам бүр нэмэгдэж байна. Охид, эмэгтэйчүүдийн, ялангуяа хөдөө орон нутагт амьдардаг, ядуу айл өрхийн охид, эмэгтэйчүүдийн дуу хоолой, оролцоог дэмжиж бэхжүүлсэнээр, тэдний ялгаатай онцлог хэрэгцээг харгалзсан шийдвэр гаргах, бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд анхаарах хэрэгтэй байна.

Хот, хөдөөгийн тэгш бус байдал



Гэр хороолол болон хөдөө орон нутгийн иргэд өөрсдийгөө халдвараас хамгаалах байдал нь төвлөрсөн шугаманд холбогдсон байшин, орон сууцанд амьдардаг хүмүүстэй харьцуулахад хангалтгүй байна. Хөдөө орон нутгийн иргэд болон ялангуяа ядуу амьдралтай айл өрхийн охид, эмэгтэйчүүд зохистой ариун цэврийн байгууламж байхгүй, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, интернет сүлжээ, мэдээлэл авах гэх мэт иргэдэд зориулсан дэд бүтэц муугаас хохирч үлдэж байна. Цар тахлын үед болон дараа нь хотын захын болон хөдөө орон нутагт амьдарч буй эмзэг бүлгийн иргэдийг чадваржуулан хүчирхэгжүүлэх урт хугацааны бодлого, арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Эдгээр нэмэгдэж буй ялгаатай байдал нь тогтвортой хөгжлийн зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэхэд саад учруулж болзошгүй байна. КОВИД-19 цар тахлын эрсдлийг бууруулах, хүртээмжтэй, үр дүнтэй сэргэлтийг бий болгохын тулд хувь хүн, хамт олон, олон нийтийг чадавхжуулж, тэдний идэвхтэй оролцоог дэмжих замаар оролцоог хангасан нийгмийг байгуулах хэрэгтэй. Хэнийг ч үлдээхгүй байх зарчимд тулгуурласан бөгөөд аль болох хурдан сэргэлтийг бий болгож чадах нийгмийг байгуулахын тулд охид, эмэгтэйчүүд болон нийгмийн эмзэг бүлгийн гишүүдийг эдийн засаг болон бодлогын арга хэмжээний төвд тавин анхаарч, бүх иргэддээ тэгш боломж олгосон хэрэгжилтийг хангах шаардлагатай.

Нүүдэлчин амьдралын хэв маяг, малчин айлын дотуур байрны хүүхдүүд, гэр хорооллын хүн ам, бие биенээ дэмжих онцлог, аав ээж ах дүү нараа харж асрах үүрэг хариуцлага зэрэг тухайн орны соёлын онцлог шинж нь цар тахлын дэгдэлтээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах ажилд ихээхэн хүндрэл учруулах эсвэл даван туулахад тус дөхөм үзүүлж болох талтай байна. Тиймээс тухайн орны өвөрмөц эдгээр хүчин зүйлсийг, ялангуяа охид, эмэгтэйчүүдийн ялгаатай онцлог хэрэгцээг КОВИД-19 цар тахлын хямралаас гарах стратегидаа харгалзан тооцох нь хэнийг ч орхигдуулахгүй, илүү сайн сайхан ирээдүйг бүтээн байгуулахад чухал юм.

4.2 Зөвлөмж

Богино хугацаанд

Хүүхэд болон эмзэг бүлгийн иргэдийн амьжиргааг дэмжих чиглэлээр одоо хэрэгжиж буй нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдээ КОВИД-19 цар тахлын улмаас уналтад орсон эдийн засаг сэргэтэл үргэлжлүүлэх;

КОВИД-19 хөл хорионы үед ЖСХ/ГБХ-ийг аль болох эрт илрүүлэх шинэлэг арга замуудыг хэрэгжүүлэх, хүчирхийллийн эрсдэл, тархалтыг бууруулах үүднээс орон нутгийн түвшинд хамтарсан багийн гишүүдийн хяналтыг тогтмолжуулан сайжруулах;

Хөл хорионы үед хүүхдүүдийг тэр дундаа охидыг цахим хүчирхийлэл болон бусад хэлбэрийн хүчирхийлэл, тухайлбал ЖСХ/ГБХ-ээс хамгаалахын тулд эцэг эх, асран хамгаалагчийн оролцоог хангаж, тэдэнд зориулсан цахим сургалт, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх;

Хөдөө орон нутаг, аслагдсан газар нутгийн сурагчид, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулан тусгайлан сургалтын багц боловсруулан хэрэгжүүлэх;

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан ганцаарчилсан сургалтын цахим хөтөлбөр боловсруулах;

Бүх төрлийн нийгмийн үйлчилгээг, ялангуяа гамшиг болон хөл хорионы үед охид, эмэгтэйчүүдэд үзүүлэхдээ хүний эрхэд суурилсан болон тэгш хүртээмжийн аргачлалыг харгалзан тооцсон байх;

Жендэрийн мэдрэмжтэй шийдвэр гаргах, хүйсээр ангилсан тоон мэдээлэл болон жендэрийн шалгуур үзүүлэлтүүдийг нарийн боловсруулж гаргах, үнэн зөв мэдээллийг олон нийтэд ойлгомжтойгоор нээлттэй байлгах;

Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуульд заасан сул зогсолтын олговрын хэрэгжилтэд Ковид-19 цар тахлын үед хяналт, аудит хийх зайлшгүй шаардлагатай. Хөл хорионы арга хэмжээг давагдашгүй хүчин зүйл гэж үзвэл Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн

Дунд хугацаанд

Цар тахлын үед тэргүүн эгнээнд ажиллаж буй эмэгтэйчүүд зонхилсон эрүүл мэнд, онцгой байдал, хүнс, нийгмийн үйлчилгээ, нийтийн тээвэр, харилцаа холбоо, ус шугам сүлжээний албан хаагчдын сэтгэл зүй, ар гэрийн сайн сайхан байдалд дэмжлэг үзүүлэхийн тулд эдгээр салбарт ажиллаж байгаа эцэг эхчүүдийн хүүхэд асрах үйлчилгээг хөгжүүлэх;

Олон нийтийн мэдлэг ойлголт, нийгмийн халамжийн үйлчилгээ, гэр бүлд ээлтэй бодлогын орчин, асаргаа болон гэрийн ажилд эрэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, цаг хугацаа хэмнэсэн дэд бүтэц, техник технологид хөрөнгө оруулалт хийх, гэр бүл, эмэгтэйчүүдэд ээлтэй татварын бодлого хэрэгжүүлэх замаар гэрийн цалин хөлсгүй хөдөлмөр эрхлэх цаг хугацааг бууруулах, ажлын хувиарлалтыг өөрчлөх боломжтой;

Сум, орон нутгаас хол амьдарч буй нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд, ХБХ, ахмад настан, шилжин суурьсан иргэд, малчдыг нарийн мэргэжлийн эмч нараас зөвлөгөө, мэдээлэл авах, эмчийн жороор эм, тариа хүлээн авах боломжийг бүрдүүлж ухаалаг болон суурин утсанд суурилсан системийг нэвтрүүлэх;

Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг ажилтнуудын коронавирүс халдварт өртөх эрсдэлийг бууруулах үүднээс эрүүл мэндийн хяналтын системийг сайжруулах болон бусад ухаалаг төхөөрөмж, технологийн хөгжлийг үйлчилгээндээ нэвтрүүлэх замаар эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх;

Эмэгтэйчүүд давамгайлсан ерөнхий боловсролын сургуулийн багш нар, ялангуяа ахлах ангийн багш нарыг дэмжиж цахим хичээлтэй холбоотой техник технологийн суурь хэрэгцээг нь нэн түрүүнд хангах;

ЖДҮ эрхлэгчдийн төрөл хэлбэр, хүчин чадал, хэмжээнээс үл шалтгаалан тэдний цахим үйлчилгээ авах болон үзүүлэх, технологийн хүчин чадал, менежментийг сайжруулахад туслахын тулд цахим платформуудыг бий болгож ажиллуулах, цахим борлуулалтын суваг, нийлүүлүүлэлтийн хэлхээг сайжруулах, Ковид-19 цар тахлын дараах байдалтай уялдуулсан чадавх бэхжүүлэх, зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хэрэгтэй байна;

Эмэгтэйчүүдийн эрхэлж буй ЖДҮ-ийг дэмжих, тэдний санхүүгийн үйл ажиллагааг

Урт хугацаанд

Гамшиг, цар тахлын үед болон отроор явж буй малчин өрхийн гишүүд эрүүл мэнд (ж нь: жирэмсэний хяналт), нийгмийн үйлчилгээ (ж нь: нийгмийн хамгаалал) – нд хамрагдах боломжийг нэмэгдүүлэхийн тулд тэдний хэрэгцээнд тулгуурласан журам боловсруулан хэрэгжүүлэх;

Жендэрийн тэгш байдал, тогтвортой хөгжлийг хангах үүднээс Охид, эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг сайжруулахад анхаарах;

Охид, эмэгтэйчүүдийг аливаа хүчирхийлэл, эрсдлээс урьдчилан сэргийлэх, нийтийн ба хувийн орон зайд өөрсдийн аюулгүй байдлаа хамгаалах чадавхыг нэмэгдүүлэхэд тогтмол анхаарах нь чухал байна;

Гэрийн хөлсгүй хөдөлмөр, гэрийн асаргааны ажилд зарцуулж буй цаг өртөггүй мөнгөн дүнгээр тооцоолон тодорхойлж гаргах хэрэгтэй. Энэ нь нийгэмд бугсаар буй жендэрийн хэвшмэл ойлголт, хандлагыг өөрчлөхөд түлхэц үзүүлнэ;

Цар тахлын дараа, цалин хөлсгүй хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдийг хөдөлмөрийн зах зээл дээр ажиллах боломжийг нэмэгдүүлэхэд нь анхаарч давтан сургалт, шинэ ур чадвар эзэмших хөтөлбөрт тогтмол хамруулах ажлыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх шаардлагатай. Ажиллах хүчний оролцоог дэмжиж холбогдох хууль, журамд оруулах;

Цар тахлын үед болон цаашид учирч болох гамшигын үед, нийгмийн аливаа үйлчилгээг хүргэхдээ хүний эрхэд суурилсан, жендэрийн мэдрэмжтэй, тэгш хүртээмжтэй байдлыг хангасан хоёр-талт сургалтын хөтөлбөрийг үйлчилгээ үзүүлэгч болон үйлчилгээ хүртэгч нарт зориулан боловсруулах;

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон бусад хуулийн хэрэгжилтэд жендэрийн квотыг онцгой анхаарч үзэх шаардлагатай;

Хуулийн хариуцлагын механизмыг сайжруулах, хяналт тавих тал дээр анхааран ажиллах;

засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд үүнийг заавал тусгаж, хөл хорионы улмаас үйл ажиллагаа нь сул зогссон аж ахуйн нэгжүүдийн ажилтнуудад энэхүү цалингийн олговрыг олгох нь зүйтэй;

Ковид-19 цар тахлын улмаас ажилгүй болсон иргэдийг нийгмийн даатгалын шимтгэлээс эдийн засаг хэвийн байдалд ортол эсвэл хоёр жилийн хугацаатайгаар чөлөөлөх шаардлагатай. Ингэснээр тухайн иргэд нийгмийн даатгалын зөрүү үүсэхгүй байх, цаашид тэтгэвэр тэтгэмж тогтоолох, зээл тусламжинд хамрагдахад нь дэмжлэг болно;

Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан нийслэлийн гэр хороололд байршиж эмзэг бүлгийн хүмүүст үйлчилдэг төрийн бус байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хөл хорионы үед дэмжиж, Засгийн газраас авч хэрэгжүүлж буй сайжруулсан шахмал түлшний үнийн хөнгөлөлт эдлэх боломжийг олгох;

Хөдөлмөр эрхлэлт болон нийгмийн бусад үйлчилгээтэй холбоотой мэдээллийг янз бүрийн боловсролын түвшинтэй, бүх насны хүмүүст ойлгомжтойгоор хүлээж авахад амархан байдлаар сайжруулан ард иргэдийн хүртээл болгох;

Онцгой байдлын үед эмзэг бүлгийн болон ядууралд нэн ойрхон буй өрх толгойлсон эмэгтэйчүүд, ахмад настан, ажилгүй эсхүл хувиараа хөдөлмөр эрхэлж буй залуу эмэгтэйчүүдийг хүчирхийллийн аливаа хэлбэр, ялгаварлан гадуурхалтаас хамгаалахын тулд олон нийтэд түшиглэсэн нийгмийн хамгааллын хөтөлбөр боловсруулах;

бэхжүүлэхийн тулд Монгол улсын Жижиг дунд үйлдвэрийн тухай хуульд “эмэгтэй өмчлөгтэй ЖДҮ” гэсэн хуулийн тодорхойлолтыг бий болгох. ЖДҮ эрхлэгчид, МҮХАҮТ, ЖҮХ, болон ХНХЯ – ны зүгээс холбогдох хууль, журамд дээрх тодорхойлолтыг оруулах талаар санаачлан ажиллах;

Жендэрийн мэдрэмжтэй нийгэм эдийн засгийн шийдвэр гаргахын тулд иргэний нийгмийн байгууллагуудыг шийдвэр гаргалтад татан оролцуулахыг дэмжих, ялангуяа жендэрийн мэргэжилтэн эсхүл жендэрийн чиглэлээр мэргэшсэн байгууллагууд, тухайлбал УОК-ын бүрэлдэхүүнд эдгээр байгууллагын төлөөллийг гишүүнээр оруулах гэх мэт;

Ковид-19 дараах нийгэм, эдийн засаг сэргээх хөтөлбөр боловсруулахад иргэний нийгмийн байгууллагуудын улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх оролцоог нэмэгдүүлэх;

Эмзэг бүлэг, түүний дотор өсвөр насны охид, залуу эмэгтэйчүүдэд зориулсан цахим болон биечлэн уулзах боломжийг бүрдүүлсэн сэтгэлзүйн зөвлөгөө өгөх, хамгаалах үйлчилгээг хөгжүүлэх;

Коронавирус болон бусад халдварт өвчнөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх үүднээс гэр хороолол, хөдөө орон нутагт амьдарч буй эмзэг бүлгийн охид, эмэгтэйчүүдэд зориулсан эрүүл ахуйн шаардлага хангасан эко-жорлон, цэвэр ус, ариун цэврийн бусад үйлчилгээг сайжруулахад анхааран ажиллах;

Ковид-19 цар тахлын дараах нөлөөг бууруулахын тулд Олон улсын болон үндэсний ТББ-уудын санал зөвлөмжид үндэслэн урт хугацааны стратеги, төлөвлөгөөг боловсруулахдаа ТХЗ болон Засгийн газрын стратегитай уялдуулах шаардлагатай байна. Тухайн стратегийг боловсруулахдаа эмэгтэйчүүдийн оролцоог дэмжиж улмаар охид, эмэгтэйчүүдийн онцгой хэрэгцээг харгалзан үзэх хэрэгтэй.

НОМ ЗҮЙ

АХБ. Техникийн туслалцааны тайлан. Монгол улс: КОВИД-19 хямралын үед Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ба шийдвэрлэх нь. 2020 оны 6 сар.

АХБ, Монгол улс: Үр дүнтэй нийгмийн халамжийн системийн чадавхи бэхжүүлэх нь Монгол улс дахь КОВИД-19-ийн үеийн нийгмийн хамгааллын хариу арга хэмжээний үнэлгээ. 2020 оны 10 сар.

АХБ. Ажиглалт ба санал: Ажиллах хүчин дэх эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн оролцоог ижил түвшинд хүргэснээр Монгол Улсын урт хугацааны эдийн засгийн өсөлтийг дэмжих нь. УБ. 2020 оны 12 сар.

БСШУСЯ. Цахим гадуурхлын өнөөгийн нөхцөл байдлын зөвлөх судалгаа. 2017.

Дэлхийн Банк, УСХ. Өрхийн нийгэм, эдийн засгийн 2018 оны судалгааны мэдээлэлд суурилсан Ядуурлын дүр төрх -2018 тайлан. 2020 он.

Дэлхийн Банк, УСХ. “Коронавирусийн нөлөөллийг тодорхойлох өрхөд суурилсан судалгаа” – утсанд суурилсан судалгааны 2 дахь шатны дүн. 2020 оны 12 сарын 17

ДЭМБ. Монгол улс дахь, эрүүл мэндийн ажилтнуудын хүний нөөцийн мэдээлэл. 2014.

ЖҮХ. Монгол улсын жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ, 2005 оноос өнөөг хүртэлх ололт амжилт ба сорилт, сургамж. УБ.2019
Мринал Чадха, Каролайн Форд, Ната Дувури. Дотны хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийллийн эдийн засгийн өртөг, зардлын тооцоо. НУБХАС. 2020 он.

МҮХАҮТ. 2020. Монголын бизнесийн орчин 2020 судалгааны тайлан. УБ. 2020 оны 12 сар.

МҮХАҮТ. Хатуу хөл хорионы үеийн бизнесийн нөхцөл байдал судалгааны тайлан. УБ. 2020 оны 11 сар.

НҮБ. Бодлогын зөвлөмж: КОВИД-19-ийн нөлөө эмэгтэйчүүдэд. 2020 оны 4 сар.

НҮБХАС Монгол. КОВИД-19: Нөхцөл байдлын тайлан №4. 2020 оны 8 сар.

НҮБХАС Монгол. КОВИД-19: Нөхцөл байдлын тайлан №5. 2020 оны 11 сар.

НҮБХАС Монгол. КОВИД-19 цар тахлын ЖСХ/ГБХ, түүний хохирогчид үзүүлэх үйлчилгээнд үзүүлэх нөлөөлөл, түргэвчилсэн үнэлгээний тайлан, 2020 оны 5 сар

НҮБХХ. Бодлогын зөвлөмж: КОВИД-19 жендэрийн тэгш бус байдал ба эдийн засагт нөлөөлөхүй талаар шийдвэр гаргагч нарт зориулсан зөвлөмж. 2020 оны 4 сар.

УСХ. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд үзүүлж буй Коронавирусны нөлөөлөл судалгаа, 2 дахь шат. 2020 оны 9 сар.

УСХ. Ажиллах хүчний судалгаа. УБ. 2019.

УСХ. Коронавирус ба эдийн засаг. 2020 оны 11 сар

УСХ. Монгол улсын ДНБ. 2020 оны 3-р улирлын тайлан

УСХ. Монгол улсын нийгэм эдийн засгийн байдал, сарын танилцуулга. УБ. 2020 оны 11 сар.

УСХ. Монгол улсын хөдөө аж ахуйн салбарын 2019 оны танилцуулга. 2020.

УСХ. Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа. УБ. 2018.

УСХ. Цаг ашиглалтын судалгаа. УБ. 2019.

УСХ. Эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд. УБ. 2018.

ХНХСИ. Монголын гэр бүлийн харилцааны хэв шинж өөрчлөлт судалгааны тайлан. УБ. 2019.

ХНХЯ. Малчдын аж байдлын судалгаа. УБ.2018.

ХНХЯ. НҮБХАС. Монгол улсад КОВИД-19 улмаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь ЖСХ/ГБХ-ийн хохирогч хамгаалал, нөхөн сэргээх үйлчилгээнд үзүүлсэн нөлөөллийн үнэлгээ. Улаанбаатар. 2020 оны 5 сар.

Хүүхдийг ивээх сан. Коронавируст цар тахлын үр нөлөөний үнэлгээ, 2020

ХЭҮК. 2020. Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дэх илтгэл. Малчин эмэгтэйчүүдийн хүний эрхийн нөхцөл байдал. УБ. 2020.

Цаг уур, орчны шинжилгээний газар. Зудын эрсдэлийн тайлан. 2020 оны 11 сар.

Ч.Бат-Уянга. Багшлах, суралцах үйлд Ковид-19 ийн үзүүлсэн нөлөө бичил судалгааны илтгэл. 2020. Боловсролын цахим форум 2020 оны 12 сарын 9-10.

ЭМХТ. Монгол улсын эрүүл мэндийн үзүүлэлт. 2019.

Вэбсайт:

Монгол улсын Статистикийн нэгдсэн мэдээллийн сан, <https://www.1212.mn/>

Монгол улсын эрхзүйн мэдээллийн нэгдсэн систем, <https://www.legalinfo.mn/>

Улаанбаатар хот, Нийслэлийн засаг даргын тамгын газар, <https://ulaanbaatar.mn/>

Улсын онцгой байдлын газар, <https://nema.gov.mn/>

Цаг уур, орчны шинжилгээний газар, <http://www.tsag-agaar.gov.mn/>

Англи хэл дээр

ADB. 2014. Gender Toolkit for Micro, Small and Medium-Sized Enterprise Finance and Development. Manila

ADB. COVID-19 impact and recovery options for micro, small, and medium-sized enterprises (MSMEs) and the informal sector in Mongolia, ADB. Dec 2019. Living with Disability in Mongolia: Progress toward Inclusion

ADB. December 2020. ADB Briefs. Sustainable Recovery Options for Mongolia's Micro, Small, and Medium-Sized Enterprises. Manila.

ADB. June 2020. Project administration manual 54214-001, Mongolia: Shock-Responsive Social Protection Project

FAO, Sep 2014. Local Economy Wide Impact Evaluation Models (LEWIE): how to measure the local income multiplier of social cash transfers, Presented to International Seminar and Policy Forum, Brasilia.

IFC. 2014. MSMEs and Women-owned MSMEs in Mongolia. Washington, D.C.

ILO, UNICEF. 2020. COVID-19 and child labour: A time of crisis, a time to act

Laura Castañeda. 2020. Negative Impacts during a COVID-19 Pandemic on Children, Adolescents & Families. Mexico.

Leonard M Lopoo, Andrew S London. 2016. Household Crowding During Childhood and Long-Term Education Outcomes.

The International Finance Corporation (IFC). 2014. MSMEs and Women-owned MSMEs in Mongolia. Washington.

UN Women. (2020b). COVID-19: Ending violence against women and girls. Key Priorities and interventions for effective response and recovery. UN Women East and Southern Africa.

UNDP COVID-19 Response, Verification list: Gender-Responsive Socio-Economic of COVID-19 Impacts

UNDP. May 2020. Rapid Socio-Economic impact assessment of COVID-19 prevention measures on vulnerable groups and value chains in Mongolia

UNFPA Mongolia. Jul 2020. Situation report #1 on COVID-19 response

UNICEF. August 2020. Mongolia Novel Coronavirus (COVID-19) Situation Report No4

UNICEF. Global COVID-19 Mid-Term Situation Report No. 9 Feb – July 2020

UNICEF. June 2020. Mongolia Novel Coronavirus (COVID-19) Situation Report No2

Wendy C. Regoeczi. 2008. Crowding in Context: An Examination of the Differential Responses of Men and Women to High-Density Living Environments

WHO. 2019. A Gender and Equity Analysis of The Global Health and Social Workforce.

World bank. Jul 2020. Understanding People's perspective on identification: Qualitative research toolkit.

World vision. 2020. COVID-19 Aftershocks: Access denied - Teenage pregnancy threatens to block a million girls across Sub-Saharan Africa from returning to school.

Эрх зүйн баримт бичгүүд

1. Хууль (он цагийн дарааллаар)
 - 1998, Эрүүл мэндийн тухай хууль
 - 1999, Хөдөлмөрийн тухай хууль
 - 1999, Гэр бүлийн тухай хууль
 - 2002, Боловсролын тухай хууль
 - 2011, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль
 - 2012, Нийгмийн халамжийн тухай хууль
 - 2017, Гамшгаас хамгаалах тухай хууль
 - 2019, Жижиг дунд үйлдвэрийн тухай хууль
 - 2020, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль
2. Засгийн газрын тогтоол (он цагийн дарааллаар)
 - Засгийн газрын тогтоол 472, Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай. 2019 оны 12 сарын 25.
 - Засгийн газрын тогтоол 30, Шинэ коронавирусын эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай. 2020 оны 1 сарын 26.
 - Засгийн газрын тогтоол 39, Хилийн зарим боомтыг түр хаах, нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах тухай. 2020 оны 1 сарын 31.
 - Засгийн газрын тогтоол 62, Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай. 2020 оны 2 дугаар сарын 12.
 - Засгийн газрын тогтоол 63, Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай. 2020 оны 2 сарын 12.
 - Засгийн газрын тогтоол 68, Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан санхүү, төсвийн чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай. 2020 оны 2 сар.
 - Засгийн газрын тогтоол 101, Ноолуурын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай. 2020 оны 4 сар.
 - Засгийн газрын тогтоол 114, Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай. 2020 оны 4 сар.
 - Засгийн газрын тогтоол 127, Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай. 2020 оны 9 сар.

- Засгийн газрын тогтоол 139, Коронавируст халдвар (КОВИД-19)-аас урьдчилан сэргийлэх чиглэлээр боловсролын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай. 2020 оны 4 сар.
- Засгийн газрын тогтоол 140, Журам батлах тухай (НД шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх). 2020 оны 4 сар.
- Засгийн газрын тогтоол 147, Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай. 2020 оны 4 сар.
- Засгийн газрын тогтоол 167, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн амьжиргааг дэмжих нийгмийн хамгааллын зарим арга хэмжээний тухай. 2020 оны 5 сар.
- Засгийн газрын тогтоол 168, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед төсвийн зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай. 2020 оны 5 сар.
- Засгийн газрын тогтоол 178, Мал аж ахуйн түүхий эдийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай. 2020 оны 5 сар.
- Засгийн газрын тогтоол 188, Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай. 2020 оны 5 сар.
- Засгийн газрын тогтоол 234, Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай. 2020 оны 6 сар.
- Засгийн газрын тогтоол 32, Боловсролын салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний тухай. 2020 оны 7 сар.
- Засгийн газрын тогтоол 181, Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай. 2020 оны 11 сар.
- Засгийн газрын тогтоол 183, Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай. 2020 оны 11 сар.
- Засгийн газрын тогтоол 194, Бэлэн байдлын зэргийг бууруулах тухай. 2020 оны 11 сар.
- Засгийн газрын тогтоол 209, Бэлэн байдлын зэргийг бууруулах тухай. 2020 оны 12 сар.
- Засгийн газрын тогтоол 200, Сайжруулсан шахмал түлшний талаар авах зарим арга. 2020 оны 12 сар.
- Засгийн газрын тогтоол 211, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай. 2020 оны 12 сар.
- Засгийн газрын тогтоол №226, Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай. 2020 оны 12 сар.
- 3. Улсын Онцгой Комиссын (он цагийн дарааллаар)
 - Комиссын тогтоол 01, Олон нийтийг хамарсан үйл ажиллагааг түр зогсоох тухай. 2020 оны 1 сарын 24.
 - Комиссын тогтоол 05, Шашин сүм хийдийн үйл ажиллагааг зохион байгуулахгүй байх тухай, хот хоорондын зорчих хөдөлгөөнийг зогсоох тухай. 2020 оны 2 сарын 20.
 - Комиссын тогтоол 06, Зорчигч, тээврийн хөдөлгөөнийг хязгаарлах тухай. 2020 оны 3 сарын 10.
 - Комиссын тогтоол 12, Нийгмийн эмзэг бүлэгт чиглэсэн халдвараас сэргийлэх, өрхийн амьжиргааг дэмжих нийгэм хамгааллын цогц арга хэмжээ хэрэгжүүлэх тухай. 2020 оны 3 сарын 17
 - Хурлын тэмдэглэл 17, ЕБС төгсөгчдөөс монгол хэл, бичгийн шалгалт авахгүй байх тухай. 2020 оны 4 сарын 14.
 - Хурлын тэмдэглэл 20, Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацааг сунгах тухай. 2020 оны 4 сар.
 - Хурлын тэмдэглэл 22, Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацааг сунгах тухай. 2020 оны 5 сарын 25.
 - Хурлын тэмдэглэл 25, Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацааг сунгах тухай. 2020 оны 7 сарын 1.
 - Хурлын тэмдэглэл 26, Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацааг сунгах тухай. 2020 оны 7 сарын 9.
 - Хурлын тэмдэглэл 29, СӨБ, ЕБС-ийн үйл ажиллагааг хэвийн горимд шилжүүлэн ажиллах тухай. 2020 оны 9 сарын 14.
 - Хурлын тэмдэглэл 29, Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацааг сунгах тухай. 2020 оны 9 сарын 14.
 - Хурлын тэмдэглэл 30, Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацааг сунгах тухай. 2020 оны 10 сарын 26.
 - Хурлын тэмдэглэл №33, УБ хотын орох гарах хөдөлгөөнийг зогсоох тухай. 2020 оны 11 сарын 10.
 - Комиссын тогтоол 12, Зорчигч тээврийн хэрэгсэлийн гарах хөдөлгөөн, бүх шатны боловсролын байгууллагын хичээл, сургалт, үзвэр үйлчилгээ, цахим болон хүүхдийн цахим тоглоомын төвүүдийн үйл ажиллагааг түр зогсоох тухай. 2020 оны 11 сарын 11.
 - Хурлын тэмдэглэл 35, ЕБС-ийн хичээлийг цахимаар зохион байгуулах тухай. 2020 оны 11 сарын 14.
 - Хурлын тэмдэглэл 37, Гамшигаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлыг сунгах тухай. 2020 оны 11 сарын 29.
 - Хурлын тэмдэглэл 38, Гамшигаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлыг сунгах тухай. 2020 оны 12 сарын 8.
- Шадар сайдын тушаал 153, Зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай. 2020 оны 12 сар.
- 4. Нийслэлийн Засаг даргын захирамж (он цагийн дарааллаар)
 - Засаг даргын захирамж А/346, Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах зарим арга хэмжээний тухай. 2020 оны 3 сарын 30.
 - Засаг даргын захирамж А/521, Иргэдийн эрүүл мэндийн талаар авах зарим арга хэмжээний тухай. 2020 оны 4 сарын 16
 - Засаг даргын захирамж А/590, Захирамжид өөрчлөлт оруулах тухай. 2020 оны 4 сарын 30.
 - Засаг даргын захирамж А/616, Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж байгаа зарим арга хэмжээний тухай. 2020 оны 5 сарын 4.
 - Засаг даргын захирамж А/930, Коронавируст /КОВИД-19/ цар тахлын үед эдийн засгийг дэмжих зарим арга хэмжээний тухай. 2020 оны 6 сарын 30.

- Засаг даргын захирамж А/1241, Коронавируст /КОВИД-19/ цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай. 2020 оны 11 сарын 11.
- Засаг даргын захирамж А/1242, Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай. 2020 оны 11 сарын 12.
- Засаг даргын захирамж А/1248, Захирамжид өөрчлөлт оруулах тухай. 2020 оны 11 сарын 18.
- Засаг даргын захирамж А/1251, Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай. 2020 оны 11 сарын 21
- Засаг даргын захирамж А/1250, Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай. 2020 оны 11 сарын 20.
- Засаг даргын захирамж А/1308, Нийслэлийн Онцгой комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай. 2020 оны 12 сарын 21.
- Засаг даргын захирамж А/1320, Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай. 2020 оны 12 сарын 22.

ХАВСРАЛТ 1. ЧИГЛҮҮЛЭХ АСУУЛТУУД

Нийгмийн үйлчилгээ

Боловсролын салбарт ажиллаж буй эмэгтэйчүүдийн нэн тэргүүний хэрэгцээ хангагдсан уу? Тэд найдвартай, түргэн шуурхай мэдээлэл олж авах, онлайн хэрэгсэл, технологи ашиглах чадамжтай байсан уу? Цахим хичээлийн дараа танхимын сургалт эхлэхэд тэдний ажлын ачаалал хэр байна вэ?

КОВИД-19 хямралын дараа хичээл таслалт, сургууль завсардалт, хичээлийн гүйцэтгэл зэрэг нь охид, хөвгүүд болон залуучуудын боловсролд ямар нөлөө үзүүлсэн бэ? Сургуулиуд хаагдсан нь охид, хөвгүүдийн хооллолтонд хөл хорионы үе болон дараа хэрхэн нөлөөлсөн бэ? Тэд найдвартай интернэт холболттой байсан уу?

Эрүүл мэндийн салбарт ажиллаж буй эмэгтэйчүүдийн нэн тэргүүний хэрэгцээ хангагдсан уу? Тэд найдвартай мэдээлэл, хувийн хамгаалах хэрэгсэл болон бусад хэрэгцээт зүйлсээ олж авч чадсан уу? Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ авах эсхүл төрөхийн эндэгдэлд КОВИД-19 (эрүүл мэндийн нөөцийн дахин хуваарилалт, жирэмсэн эхчүүдийн хөдөлгөөний хязгаарлалт гэх мэт байдлаар) нөлөөлсөн үү?

Хямралыг даван туулах зорилгоор Засгийн газраас өрхийн амьжиргааг дэмжих ямар багц арга хэмжээ авч байна вэ? Эдгээр арга хэмжээ нь охид, эмэгтэйчүүдийн нөхцөл байдлыг сайжруулахад тусалж байна уу?

КОВИД-19 цар тахлын үед (ГБХ-ийн тайлан, тус тайланд хамрагдсан байгууллагууд, ГБХ-ийн дуудлага, Хамгаалах байранд үйлчүүлсэн хүмүүсийн тоо) эмэгтэйчүүд, охидын эсрэг ЖСХ/ГБХ өссөн үү?

Хөдөлмөр эрхлэлт ба орлого

Эрэгтэй болон эмэгтэй хүмүүс аль салбарт ажиллаж, ямар ажил хийж байна вэ? Эдгээр салбарт КОВИД-19 цар тахал хэрхэн нөлөөлж байна? Зорчигч тээврийн хөдөлгөөнийг хорих, бөөгнөрөл үүсгэхгүй байх зэрэг хөл хорионы үеийн арга хэмжээ эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ажлын байр болон орлогод хэрхэн нөлөөлж байна вэ?

ЖДҮ болон эмэгтэйчүүдийн өмчит бизнес аль салбарт хамгийн их тархалттай байна вэ? КОВИД-19 цар тахал тэдэнд хэрхэн нөлөөлсөн байна вэ?

КОВИД-19 цар тахлын бэлэн байдал нь албан болон албан бус ЖДҮ-ийн эргэлт, орлого, үйлдвэрлэлд хэрхэн нөлөөлөв? Эмэгтэйчүүдийн өмчит бизнест ялгаатай байдлаар нөлөөлсөн үү?

КОВИД-19 цар тахлын улмаас аж ахуйн нэгжүүд ямар өөрчлөлт хийв? ААН-ийн үйл ажиллагааг хүчээр хааж зогсооход (хатуу хөл хорионы үед), эзэд нь ямар арга хэмжээ авсан бэ?

Эмэгтэйчүүдийн өмчит бизнесүүд, ялангуяа ЖДҮ-үүд КОВИД-19 хөтөлбөрт (ж.нь татварын хөнгөлөлт, зөвлөгөө, санхүү, баталгаа, гэх мэт) хамрагдаж чадсан уу? Засгийн газрын хөтөлбөрүүд эмэгтэй бизнес эрхлэгчид болон хувиараа хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдэд тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн үү?

Бизнесийг дэмжих санаачилга, бодлогод эмэгтэйчүүдийг чадавхжуулах, жендэрийн ялгаатай байдлыг арилгахад Засгийн газрын зүгээс шууд анхаарч байна уу? (ж.нь санхүүгийн багц арга хэмжээ, татварын хөнгөлөлт гэх мэт).

Хөл хорионы нөхцөл байдал өрх дэх цалин хөлсгүй асран халамжлал, хөдөлмөрт ямар нөлөөлөл үзүүлж байна вэ? Гэр бүлийн гишүүд гэрийн ажлыг хэрхэн хуваарилж байна вэ?

Засгийн газрын хариу арга хэмжээ

Гамшиг бэлэн байдлын арга хэмжээ авч хэрэгжүүлэх үед онцгой байдал/цагдаа/дотоодын цэргийн байгууллагуудад ямар нэг хариуцлагын тогтолцоо байна уу? Тэд эмэгтэй, эрэгтэй хүмүүст үзүүлж буй өөр өөр нөлөөллийг харгалзан үзэж байна уу?

Гамшиг бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх төлөвлөлт нь салбар хоорондын харилцаанд жендэрийн гол асуудлыг бодолцсон уу? Засгийн газраас авч хэрэгжүүлж арга хэмжээ хүн бүрт ойлгомжтой, хүртээмжтэй байна уу?

КОВИД-19 цар тахлын үед авах хариу арга хэмжээ, шийдвэр гаргах үйл явц, засаглалын бүтцэд охид, эмэгтэйчүүд хамрагдаж байна уу? КОВИД-19 цар тахлын үед шийдэр гаргах түвшний байгууллагуудад хүйсийн хуваарилалт ямар байна вэ? КОВИД-19 гамшиг бэлэн байдлын үе болон цар тахлын дараах бодлого төлөвлөлтийн шийдвэр гаргах үйл явцад жендэрийн мэргэжилтнүүдийг оролцуулж байна уу?

Эмзэг бүлэг

КОВИД-19 цар тахлын хямрал малчдад нөлөөлж байна уу? Хямралын үе болон хямралын дараах бодлого хөтөлбөрүүд малын нөөц ашиглах, орлого олох хүмүүст нөлөөлж байна уу? Хөдөө орон нутгийнхан эрүүл мэндийн зохистой үйлчилгээг авч байна уу? Малчин өрхүүдэд КОВИД-19 цар тахлын нөлөөллийг арилгах талаар ЗГ тодорхой арга хэмжээ авсан уу?

Хөл хорионы арга хэмжээ шилжин ирсэн эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн ажил ба орлогын тогтвортой байдалд хэрхэн нөлөөлж байна вэ? Тэдний амьдарч буй орон байрны нөхцөл байдал КОВИД цар тахлаас хамгаалахуйц байж чадах уу? Хямралын улмаас тэднийг ямар нэг байдлаар ялгаварлан гадуурхаж байна уу? ЗГ-аас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ/шийдвэр тэдний орлогын эх үүсвэрт нөлөөлсөн үү?

КОВИД-19 цар тахлын улмаас эрүүл мэндийн эх үүсвэрийг дахин хуваарилалт хийхэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нийгэм, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртэх боломж байна уу? Хямралын улмаас хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хооронд ялгаа гарч байна уу? Тусгаарлах, хөл хорих арга хэмжээ авснаар тэдний хувьд ЖСХ-д өртөх эрсдэл нэмэгдсэн үү? Гамшиг бэлэн байдлын бодлого, төлөвлөгөө нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ялангуяа эмэгтэйчүүд, охидын онцлог хэрэгцээг харгалзан үзсэн үү? ЗГ эдгээр нөлөөллийг арилгах арга хэмжээ авсан уу?

Ахмад настны гэрийн асаргаанд нөлөөлсөн үү? Тэтгэврийн насны эмэгтэйчүүдийн хүүхэд асрах гэрийн цалин хөлсгүй хөдөлмөр эсхүл цалинтай ажлын ачаанд хэрхэн нөлөөлж байна вэ?

КОВИД-19 хямрал бага, дунд орлоготой өрх толгойлсон эмэгтэйчүүдийн орлогод хэрхэн нөлөөлсөн бэ? Амьжиргааны нөхцөл байдал нь өрхүүдийг КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хөл хорионы дэглэмийг дагаж мөрдөхөд хэрхэн нөлөөлж байна вэ?

ХАВСРАЛТ 2. ЗАСГИЙН ГАЗРЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ, ТОЙМ

Холбогдох баримт бичиг

Засгийн газрын хариу арга хэмжээ

1 дүгээр САР

**2020.01.26 ЗГ-ын 30 дугаар тогтоол,
УОК-ын 1-р
хуралдаан**



БНХАУ-тай хиллэх автозамын боомтоор тээврийн хэрэгслээр болон явганаар нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах, олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахыг хориглох, хичээл сургалтын үйл ажиллагааг 3-р сарын 2-ныг хүртэл зогсоох

**2020.01.31 ЗГ-ын 39 дүгээр
тогтоол**



БНХАУ-аас дамжин ирэх гадаадын иргэдийг 2-р сарын 1-нээс 3-р сарын 2-ны хугацаанд хил нэвтрүүлэхгүй байх ба энэхүү хязгаарлалт нь агаарын замын, төмөр замын, автозамын бүх боомтуудад хамаарах, Монгол Улсын иргэдийн БНХАУ руу зорчих хөдөлгөөнийг 2-р сарын 1-нээс 3-р сарын 1-нийг хүртэл хязгаарлах, харин БНХАУ-д байгаа Монгол Улсын иргэд 2-р сарын 6-ныг хүртэл чөлөөтэй хилээр нэвтрэх бөгөөд 2-р сарын 6-наас хойш зөвхөн агаарын болон төмөр замын боомтоор хил нэвтрэх

2 дугаар САР

2020.02.12 ЗГ-ын 62 дугаар тогтоол



Боловсролын үйл ажиллагаа зогсоосныг 3-р сарын 30-ныг хүртэл сунгах, Цагаан сарын баярыг бүх нийтээр тэмдэглэхийг хориглох, хот хоорондын хөдөлгөөнийг хязгаарлах

**2020.02.13 ЗГ-ын 63 дугаар тогтоол,
УОК-ын 5-р хуралдаан**



БНХАУ-д сүүлийн 14 хоногийн хугацаанд зорчсон гадаад улсын иргэдийг 3-р сарын 2-ныг хүртэл хилээр нэвтрүүлэхгүй байх, 2-р сарын 26-ныг хүртэл хот хоорондын автозамын хөдөлгөөнийг хориглох, олноор цуглах аливаа үйл ажиллагаа, шашны үйл ажиллагааг 3-р сарын 30-ныг хүртэл хориглох

2020.02.19 ЗГ-ын 68 дугаар тогтоол












Үр тариа, элсэн чихэр, өндөг гэх мэт зарим нэр төрлийн барааны импортын болон гаалийн албан татвараас чөлөөлөх, (холбогдох хуулийн төслийг хожим УИХ-аар баталсан)

3 дугаар САР

**УОК-ын 10 болон 11-р хуралдаан,
2020.03.10 УОК-ын 6 дугаар тогтоол**



2020 оны 3-р сарын 10-нд тус улсад гадаадын иргэнээс анхны тохиолдол бүртгэгдэж, хүнсний түгээлт үйлчилгээнээс бусад бүх төрлийн үйл ажиллагааг зогсоох, хот хоорондын хөдөлгөөнийг хориглох, олон улсын нислэг, төмөр замын болон бусад зорчих тээврийн хөдөлгөөнийг хязгаарлах. 12 ба түүнээс доош настай хүүхэдтэй эмэгтэй ажилчдыг гэрээс ажиллуулах эсвэл цалинтай чөлөө олгох зохицуулалтаар хангахыг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад уриалсан.

<p>УОК-ын 12-р хуралдаан</p> 	<p>Холбогдох яам салбарын удирдлагуудад эмзэг бүлгийн иргэдэд цар тахлыг даван туулахад дэмжлэг үзүүлэхийг зөвлөсөн.</p>
<p>2020.03.19 ЗГ-ын 101 дүгээр тогтоол</p> 	<p>МУЗГ-аас ноолуурын салбарт бизнес эрхлэгчдэд түүхий эд бэлтгэх нөөц бүрдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор 3 хувийн зээл олгох асуудлыг судалж шийдвэрлэх талаар Хөгжлийн банкинд үүрэг болгосон.</p>
<p>2020.03.27 ЗГ-ын 114 дүгээр тогтоол, 2020.04.17 ЗГ-ын 140 дүгээр тогтоол, 2020 оны 4 дүгээр сарын 09-нд хөнгөлөлт чөлөөлөлт нь УИХ-аар батлагдсан</p> 	<p>ЗГ-аас цар тахлыг даван туулахтай холбогдсон эдийн засаг нийгмийн багц арга хэмжээг танилцуулж хожим нь УИХ-аар батлагдсан. Үүнд: ажилтан болон ажил олгогчдын төлөх нийгмийн даатгалын хураамжийг чөлөөлөх, сайн дураар нийгмийн даатгалд хамрагдсан иргэдэд мөн адил хамаарах, орлого нь буурсан 1.5 тэрбумаас бага орлоготой аж ахуйн нэгжүүдэд ажлын байраа хадгалахад нь зориулж ажилтан бүрт нь 200,000 төгрөгний дэмжлэг үзүүлэх, хүүхдийн мөнгийг 30,000 төгрөг болгож нэмэгдүүлэх</p>
<p>4 дүгээр САР</p>	
<p>2020.04.14 ЗГ-ын 139 дүгээр тогтоол, УОК-ын 17-р хуралдаан</p> 	<p>Боловсролын үйл ажиллагааг зогсоосныг 9-р сарын 1-нийг хүртэл сунгах, ЕБС-ийн улсын шалгалтуудыг зохион байгуулахгүй байх</p>
<p>2020.04.16 Нийслэлийн ЗД-ын захирамж А/521</p> 	<p>Улаанбаатарт амралтын газар, фитнес, иогийн газруудын үйл ажиллагааг нээх</p>
<p>2020.04.29 ЗГ-ын 147 дугаар тогтоол, УОК-ын 20-р хуралдаан</p> 	<p>Олон нийтийг хамарсан үйл ажиллагааг хориглох, олон улсын улсын нислэгийг зогсоосон хугацааг 5-р сарын 31-нийг хүртэл сунгах, ачаа тээвэр, эмчилгээний тоног төхөөрөмж, хэрэгслийн тээвэрлэлт хэвийн үргэлжлэх, гадаадад гацсан Монгол Улсын иргэдийг эх оронд нь авчрах болон Монгол Улсад гацсан гадаадын иргэдийг нутаг буцаах ажлыг үргэлжлүүлэх</p>
<p>2020.04.29 МУ-ын Хууль</p> 	<p>УИХ-аас Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай</p>
<p>2020.04.30 Нийслэлийн ЗД-ын захирамж А/590</p> 	<p>Улаанбаатарт спорт сургалтын төв, клуб, баарны үйл ажиллагааг нээх, шашны үйл ажиллагааг иргэдийн бөөгнөрөл багатайгаар зохион байгуулах</p>
<p>5 дугаар САР</p>	
<p>2020.05.04 Нийслэлийн ЗД-ын захирамж А/616</p> 	<p>Улаанбаатарт цар тахлын дэгдэлтээс урьдчилан сэргийлэх үүднээс бүх төрлийн баарны үйл ажиллагааг зогсоох</p>



<p>2020.05.04 Нийслэлийн ЗД-ын захирамж А/616</p> 	<p>Улаанбаатарт цар тахлын дэгдэлтээс урьдчилан сэргийлэх үүднээс бүх төрлийн баарны үйл ажиллагааг зогсоох</p>
<p>2020.04.29 УИХ-ын 32 дугаар тогтоол, 2020.05.06 ЗГ-ын 167 дугаар тогтоол</p> 	<p>Цар тахлыг даван туулахтай холбогдуулсан эдийн засаг нийгмийн 2 дахь багц арга хэмжээг ЗГ-аас зарлав. Үүнд: хүүхдийн мөнгийг 100,000 төгрөг болгон нэмэгдүүлэх, хүнсний эрхийн бичгийн үнийн дүнг 2 дахин нэмэгдүүлэх, нийгмийн халамжийн сангаас олгодог нийгмийн халамжийн тэтгэвэр, үүнд 3 ба түүнээс дээш хүүхэдтэй ганц бие эх, эцэгт олгодог тэтгэмжийг нэмэгдүүлэх, малчдад нэг кг ноолуур тутамд 20,000 төгрөгний урамшуулал олгох</p>
<p>2020.05.27 ЗГ-ын 188 дугаар тогтоол, УОК-ын 22-р хуралдаан</p> 	<p>Хөл хориог 6-р сарын 30-ныг хүртэл сунгах, гадаадын иргэдийн тус улсын хилээр нэвтрүүлэхгүй байх, хот хоорондын хөдөлгөөн хязгаартай байх зэрэг нь үргэлжлэх</p>
<p>6-10 дугаар САР</p>	
<p>2020.06.30 ЗГ-ын 234 дүгээр тогтоол, УОК-ын 25-р хуралдаан</p> 	<p>УИХ-ын сонгуулийн сурталчилгаа, санал хураалтыг хязгаарлалтын дэглэмийн дагуу зохион байгуулах, үзвэр үйлчилгээний газруудыг нээх, гэвч олноор цугларах, олон нийтийн арга хэмжээг хориглосон хэвээр байх.</p>
<p>УОК-ын 26-р хуралдаан</p> 	<p>Олон улсын нислэгийг цуцалсан хугацааг 7-р сарын 31-нийг хүртэл сунгах, Үндэсний баяр наадмыг үзэгчгүйгээр зохион байгуулах</p>
<p>2020.07.29 ЗГ-ын 32 дугаар тогтоол, 2020.08.06 Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаал А/17</p> 	<p>Сургууль, цэцэрлэгийг хязгаарлалтын дэглэмийг баримтлан эхлүүлэх, нэг ангид 20-25 хүүхэдтэй байх, 7 хоногийн 3 өдөрт хичээлийг ангид заахдаа сурагчдыг тогтмол маск зүүлгэх, цэцэрлэгт шинээр 2 настай хүүхдийг элсүүлэхгүй, 5 настай хүүхдийг бүрэн хамруулах</p>
<p>УОК-ын 29-р хуралдаан</p> 	<p>9-р сарын 15-наас хичээл сургалтын үйл ажиллагааг хэвийн горимд оруулж багш, сурагчдыг байнга маск зүүлгэх, 2 настай хүүхдийг цэцэрлэгт хамруулж эхлэх</p>
<p>2020.09.30 ЗГ-ын 127 дугаар тогтоол</p> 	<p>ЗГ-аас өмнө хэрэгжүүлсэн нийгэм эдийн засгийн багц арга хэмжээнд зарим өөрчлөлт хийж үргэлжлүүлэхээр болсноо зарлав. Үүнд: хүүхдийн мөнгө, хүнсний эрхийн бичиг, нийгмийн халамжийн тэтгэмжүүдийг нэмэгдсэн байдлаар нь он дуустал үргэлжлүүлэн олгох, нийгмийн даатгалыг 5 хувиар чөлөөлөх</p>
<p>УОК-ын 30-р хуралдаан</p> 	<p>Өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг дахин 12-р сарын 31-ныг дуустал сунгах</p>

11 дүгээр САР

2020.11.11 ЗГ-ын 178 дугаар тогтоол, УОК-ын 33-р хуралдаан, 2020.11.11 Нийслэлийн ЗД-ын захирамж А/1241



Монгол Улсад коронавирус (КОВИД-19) цар тахлын анхны дотоодын тохиолдол 11-р сарын 11-нд илэрч Засгийн газраас 11-р сарын 17-нийг хүртэл 5 хоногийн хугацаанд бүх нийтийн бэлэн байдал тогтоов. Хөл хорионы хугацаанд хүнсний үйлдвэрлэл худалдаа, шатахуун түгээлт, эрүүл мэнд, эм хэрэгслийн худалдаа үйлчилгээ, цахилгаан эрчим хүч, оршуулгын үйлчилгээ зэрэг 11 төрлийн үйлчилгээнээс бусад бүх үйл ажиллагааг зогсоох, иргэд зөвхөн ойролцоо хүнсний дэлгүүрээр үйлчлүүлэх, үйл ажиллагаа нь зөвшөөрөгдсөн байгууллагын ажилтнууд л ажилдаа ирж очих, иргэд байнга маск зүүх ба нэг дор олноор цуглахгүй байх, гадаад гацсан иргэдийг авчрах нисэлгүүдийг түр хугацаанд хойшлуулах. Улаанбаатарт 0-12 насны хүүхэдтэй эмэгтэйчүүд, ганц бие эцгийг гэрээсээ ажиллах боломжоор хангахыг бүх төрийн байгууллагуудад даалгаж, хувийн байгууллагуудад уриалга гаргасан.

2020.11.12 Нийслэлийн ЗД-ын захирамж А/1242



Улаанбаатарт нийтийн тээвэр, хүнсний түгээлтийг тодорхой цагийн хуваарьт оруулах, архи суогтууруулах ундаагаар үйлчлэх худалдахыг хориглох, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг мөн тодорхой цагт хориглох

2020.11.15 ЗГ-ын 181 дүгээр тогтоол, УОК-ын 35-р хуралдаан



Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 12-р сарын 1 хүртэл сунгах, өмнө хязгаарласан үйлчилгээг үргэлжлүүлэн хориглох, дотуур байранд буй оюутнуудад хүнсний тусламж үзүүлэх

2020.11.18 ЗГ-ын 183 дугаар тогтоол



Нийгэм эдийн засгийн зарим арга хэмжээг 2021 оны 6-р сарыг дуустал үргэлжлүүлэх, мөн нэмж зарим багц арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр ЗГ-аас зарласан. Үүнд: хугацаандаа төлөөгүй татварын тооцоонд алданги, торгууль тооцохгүй байх, хэрэглээний болон ипотекийн зээлийн эргэн төлөлтийг иргэний хүсэлтээр хойшлуулах, мөн бүх төрлийн тэтгэвэр тэтгэмжийг онлайн эсвэл төлбөрийн картаар олгох ба банкинд дугаарлан бөөгнөрөх нөхцөлийг бүрдүүлэхгүй байх

2020.11.18 Нийслэлийн ЗД-ын захирамж А/1248



Улаанбаатарт нийтийн тээврийн үйлчлэх хугацааг тогтоож, хүнс, эм хэрэгслийн түгээлтийг шөнийн 22 цагаас өглөөний 06 цагт тээвэрлэх



2020.11.21 Нийслэлийн ЗД-ын захирамж А/1251



Улаанбаатарт зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагын ажилтнуудын тээврийн хэрэгсэлд QR тусгай зөвшөөрөл олгох, хүнсний түгээлтийг өглөөний 07 цагаас оройны 17 цаг хүртэл хугацаанд зөвшөөрөх

2020.11.29 ЗГ-ын 194 дүгээр тогтоол, УОК-ын 37-р хуралдаан



Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг Улаанбаатар хот, Сэлэнгэ, Архангай аймагт 12-р сарын 11-нийг хүртэл сунгах, бусад аймагт гамшгийн онцгой байдлын зэрэглэл бууруулах, хүнсний зах дэлгүүр, шатахуун түгээх станц, эмийн сан, эмнэлэг, цахилгаан станц, оршуулгын үйлчилгээ, зарим боловсруулах үйлдвэрлэл зэрэг 18 төрлийн үйлчилгээнээс бусад үйлчилгээг хязгаарлах, иргэд зөвхөн хүнсний дэлгүүрээр үйлчлүүлэх болон зөвшөөрөгдсөн байгууллагын ажилтнууд ажилдаа ирж очихдоо гадагш гарах, гадуур зорчсон иргэд очсон газартаа QR кодоор бүртгүүлэх

12 дугаар CAP

2020.12.02 ЗГ-ын 200 дугаар тогтоол



Улаанбаатарт гэр хорооллын иргэдэд шахмал түлшний үнийг 50% бууруулах

УОК-ын 38-р хуралдаан



Хэрэв тухайн иргэнд КОВИД-19 цар тахлын шинж тэмдэг илрээгүй бол тусгаарлалтын хугацааг тусгаарлах төвд 14 хоног, гэртээ 7 болгон бууруулах

2020.12.09 ЗГ-ын 209 дүгээр тогтоол, 2020.12.11 Нийслэлийн ЗД-ын захирамж А/1280



Бүх нийтийн бэлэн байдлын зэргийг 12-р сарын 14-нөөс эхлэн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг болгон бууруулах ба Улаанбаатарт хөдөлгөөний хязгаарлалтыг үргэлжлүүлэн тогтоох, хүнсний дэлгүүр, шатахуун түгээх станц, эмийн сан, эмнэлэг зэрэг үйлчилгээн дээр нэмж ресторан зоогийн газар, кафе болон зарим худалдаа үйлчилгээний газруудыг нээх, гэсэн хэдий ч үүнд зочид буудал, фитнес, саун, баар зэрэг өндөр эрсдэлтэй үйлчилгээний газрууд хамаарахгүй байх, иргэд зайлшгүй шаардлагагүй бол гэртээ байх, гадуур явахдаа маск байнга хэрэглэх. Улаанбаатарт 0-12 насны хүүхэдтэй эмэгтэйчүүд, ганц бие эцгийг гэрээсээ ажиллах боломжоор хангахыг бүх төрийн байгууллагуудад даалгаж, хувийн байгууллагуудад уриалга гаргасан.

2020.12.13 ЗГ-ын 211 дүгээр

тогтоол



ЗГ-аас нийгэм эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн айл өрх, албан байгууллагын цахилгаан, дулаан, усны төлбөрийг хөнгөлөх арга хэмжээг танилцуулсан. Мөн шахмал түлшний үнийг нэмж 25% буюу нийт 75% хөнгөлөх шийдвэр гаргав.

2020.12.21 ЗГ-ын 226 дугаар

тогтоол, 2020.12.22 Нийслэлийн

ЗД-ын захирамж А/1320



Дотоодод дахин шинэ халдварын голомт илэрч Улаанбаатар хотыг 12-р сарын 23-наас 2021 оны 01-р сарын 06-ныг хүртэл дахин бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэв. Нэн шаардлагатай бус үйлчилгээнүүдийг хязгаарлаж хүнсний дэлгүүр, шатахуун түгээх станц, эмийн сан, банк, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон хүүхэд гэр бүл хамгааллын үйлчилгээ зэрэг зарим үйлчилгээг зөвшөөрсөн. Нийтийн тээвэр, такси үйлчилгээ болон хоол хүргэлтийн үйлчилгээ зөвшөөрөгдөж тусгай үүргийн нислэгүүдийг тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан.

#EmpowerWomen
#BuildForwardBetter